



**ИНД-91**

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРЭМ**

**ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЕРӨНХИЙ ДҮРЭМ**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **Дүрмийн тайлбар**

ИНД-91 нь Монгол Улсын нисэхийн ерөнхий үйл ажиллагаа, нислэгийн дүрмийн үндсэн зохицуулалтыг хийхэд оршино. Энэ дүрэмд агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангах, нислэгийн үйл ажиллагааг аливаа этгээд, эд зүйлсэд аюул учруулахгүйгээр явуулахад тавигдах шаардлагуудыг тодорхойлно.

ИНД-91 нь Агаарын хөлгийн Ашиглагч, түүнчлэн зорчигчдод хамааралтай дор дурдсан зүйлсийг зохицуулна:

- Ашиглагч болон зорчигчдод хамаарах ерөнхий дүрэм;
- нислэгийн ерөнхий болон үйл ажиллагааны дүрэм;
- ил харааны нислэгийн дүрэм (ИХНД) болон хэрэглэлийн нислэгийн дүрмээр (ХНД) үйлдэх нислэгийн үйл ажиллагаа;
- агаарын хөлгийн хэрэглэл, тоног төхөөрөмжид тавигдах шаардлага;
- Ашиглагчийн техник үйлчилгээнд тавигдах шаардлага;
- тусгай нислэгийн үйл ажиллагаанууд болох уран жолоодлогын нислэг, агаарын үзүүлбэр, планер чирэх болон шүхэр хаях нислэгүүдэд тавигдах шаардлага;
- гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа;
- агаарын хөлгийн дуу чимээнд тавигдах хязгаарлалт.

**Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-91-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-91, түүний өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-91 нь анх 2003 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах өөрчлөлтийг багтаасан:

<b>Өөрчлөлтийн дугаар</b>	<b>Хүчин төгөлдөр болсон огноо</b>
Өөрчлөлт 1	2005 оны 9-р сарын 14
Өөрчлөлт 2	2007 оны 9-р сарын 18
Өөрчлөлт 3	2008 оны 5-р сарын 30
Өөрчлөлт 4	2008 оны 9-р сарын 11
Өөрчлөлт 5	2010 оны 4-р сарын 16
Өөрчлөлт 6	2013 оны 1-р сарын 11
Өөрчлөлт 7	2014 оны 9-р сарын 12
Өөрчлөлт 8	2016 оны ...р сарын ...

ИНД- 91-ийн өөрчлөлт 8-ыг Шинэ Зеландын Part 91-ийн 2015 оны 9-р сарын 24-ний өдрийн Өөрчлөлт 25-д үндэслэн боловсруулсан болно.

**Тэмдэглэл:** ИНД-91-ийг англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбар нь давамгайлна.



## А Бүлэг. Ерөнхий зүйл

### 91.1. Зорилго

(a) Энэ дүрмийн зорилго нь иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх ерөнхий үйл ажиллагааны зохицуулалтыг тогтооход оршино.

(b) Энэ дүрмийн (c)(1) болон (d)-д хамааралтайгаар, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд, энэ дүрмийн дараах заалтууд улсын агаарын хөлгийн нислэгт хамаарна:

- (1) 91.129:
- (2) 91.223-с 91.225 иргэний агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэж байвал:
- (3) 91.229 иргэний агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэж байвал:
- (4) 91.233:
- (5) 91.241:
- (6) 91.245-с 91.247:
- (7) 91.309:
- (8) 91.313:
- (9) 91.407-с 91.411:
- (10) 91.425-с 91.427:
- (11) 91.431:
- (12) 91.541.

(c) Энэ дүрмээр дараах нислэгийн үйл ажиллагааг зохицуулахгүй:

- (1) онцгой нөхцөл байдлын үед **иргэний хамгаалалтын** зорилгоор үйлдэх дараах аливаа нислэг:
  - (i) аливаа дайн, эсхүл бусад онцгой байдал; эсхүл
  - (ii) Монгол Улсын аюулгүй байдал болон Монгол Улсын бусад эрх ашгийн үүднээс; эсхүл
  - (iii) онцгой байдал зарласан үед иргэний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажиллагаанд; эсхүл
  - (iv) нийтийн үйлчилгээнд туслах; эсхүл
  - (v) ИНД-71-ийн дагуу тогтоосон аюултай, хязгаарлалтай болон цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд үйлдэх улсын агаарын хөлгийн аливаа нислэг;
- (2) ИНД-101-ийн дагуу үйлдэх нислэг;

(2A) Иргэний нисэхийн хууль болон ИНД-102-ийн дагуу гэрчилгээжсэн хүнгүй агаарын хөлөг (unmanned aircraft) ашиглагчийн үйл ажиллагааны нэмэлт нөхцөлд энэ дүрмийн шаардлагыг хангана гэж заасан бол;

(3) ИНД-105-д хамаарах үйл ажиллагаа.

(d) Энэ дүрмийн дараах зүйлс нь улсын агаарын хөлгийн дадлагын нислэг энэ зүйлийн (c)-ийн (1)-дэх заалтад хамаарч байвал зохицуулахгүй:

(1) 91.225 (b):

(2) 91.233:

(3) 91.313 хяналттай агаарын зайн гадна бол:

(4) 91.407 хяналттай агаарын зайн гадна бол:

(5) 91.427 хяналттай агаарын зайн гадна бол.

### **91.3. Тодорхойлолт ба товчлол**

*Нөөц*

### **91.5. Нисэх багийн тушаал, зааврыг дагаж мөрдөх**

91.203-т заасан эрхийн хүрээнд зорчигчид агаарын хөлгийн даргаас өгсөн тушаал, зааврыг дагаж мөрдөх үүрэгтэй.

### **91.7. Зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулах**

(a) ХНД-ээр нислэг үйлдэж буй Агаарын хөлөг ашиглагч (цаашид Ашиглагч гэх), эсхүл агаарын хөлгийн дарга аливаа этгээдийг зөөврийн гар утас болон бусад цахилгаан соронзон долгионы нөлөө үзүүлэх зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулахыг хориглоно.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгөөр хэрэглэлийн ойртолт, эсхүл хөөрөлт, эсхүл нислэгийн бусад онцгой тохиолдлын үед Ашиглагч, эсхүл агаарын хөлгийн дарга аливаа этгээдийг зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулахыг хориглоно.

(c) Энэ зүйлийн (b)-д дараах хэрэгслүүд хамаарахгүй:

(1) сонсголын аппарат;

(2) зүрхний ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төхөөрөмж;

(3) зөөврийн дуу бичигч;

(4) сахлын цахилгаан машин;

(5) электрон бугуйн цаг; эсхүл

(6) агаарын хөлгийн холбоо, навигацийн системд нөлөөлөхгүй, Ашиглагчаас тодорхойлсон бусад зөөврийн цахилгаан хэрэгсэл.

(d) Дараах тохиолдолд:

(1) Агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглагдах агаарын хөлгийн хувьд, Ашиглагч энэ зүйлийн (c)-ийн (6)-д заасан хэрэгслүүдийг тодорхойлно;

(2) бусад агаарын хөлгийн хувьд Ашиглагч, эсхүл агаарын хөлгийн дарга энэ зүйлийн (c)-ийн (6)-д заасан хэрэгслүүдийг тодорхойлж болно.

### **91.9. Агаарын хөлгөөр галт зэвсэг тээвэрлэх, ашиглах**

(a) Энэ зүйлийн (c) болон (e)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд дараах зүйлсийг хориглоно:

(1) агаарын хөлгөөр галт зэвсэг тээвэрлэх; эсхүл

(2) агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэхэд хүргэх; эсхүл

(3) агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэхийг зөвшөөрөх.

(b) Энэ зүйлийн (d)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд агаарын хөлөгт галт зэвсэг ашиглахгүй.

(c) Дараах тохиолдолд галт зэвсгийг агаарын хөлөгт тээвэрлэж болно:

(1) галт зэвсгийг:

(i) нислэгийн үед хэн ч хүрэх боломжгүй байрлуулсан;

(ii) ашиглах боломжгүй; эсхүл

(2) зөвхөн галт зэвсэг эзэмших эрх бүхий этгээд, эсхүл бүлэг этгээдийг тээвэрлэх тусгай зориулалтын нислэгт дараах тохиолдолд зөвшөөрнө:

(i) Ашиглагч, галт зэвсэг тээвэрлэхийг зөвшөөрсөн;

(ii) галт зэвсэг нь ашиглах боломжгүй; эсхүл

(3) амьтан тээвэрлэж байгаа агаарын хөлгийн хувьд, Ашиглагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зорчигч болон агаарын хөлгийн аюулгүй байдлын үүднээс тухайн амьтныг мэдээ алдуулах зорилгоор; эсхүл

(4) агаарын хөлгөөс газарт байгаа ан амьтныг мэдээ алдуулах, буудах зорилгоор дараах тохиолдолд галт зэвсэг ашиглана:

(i) агаарын хөлөг галт зэвсэг ашиглагдах газарт очих хүртэл цэнэглэгдээгүй;

(ii) агаарын хөлөгт зөвхөн, тухайн газарт буй ан амьтныг мэдээ алдуулах, буудах зорилгоор оролцох эрх бүхий этгээдийг тээвэрлэнэ.

(d) Дараах тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

- (1) амьтан тээвэрлэж буй агаарын хөлгийн хувьд, багийн гишүүн нь зорчигч болон агаарын хөлгийн аюулгүй байдлын үүднээс тухайн амьтныг мэдээ алдуулах шаардлагатай гэж үзсэн; эсхүл
- (2) агаарын хөлгөөс газарт байгаа ан амьтныг мэдээ алдуулах, буудах зорилгоор:
  - (i) газарт байгаа бусад амьд амьтан, хүн, эд хөрөнгөд аюул учруулахгүй гэж үзвэл;
  - (ii) хот, тосгон, хүн оршин суугаа газрын дээгүүр бол хориглоно.

(e) Галт зэвсгийг агаарын хөлөгт цэрэг, цагдаа, хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагын ажилтнууд дараах тохиолдолд тээвэрлэнэ:

- (1) тухайн агаарын хөлгөөр, хөлсөөр зорчигч тээвэрлэн агаарын тээврийн, эсхүл арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бол галт зэвсэг тээвэрлэх этгээд нь:
  - (i) хуулиар галт зэвсэг эзэмших эрхтэй;
  - (ii) гүйцэтгэх үүрэгт нь галт зэвсэгтэй байхыг шаардсан;
  - (iii) энэ зүйлийн (f)-д заасны дагуу Дарга агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэхийг зөвшөөрсөн;
  - (iv) энэ зүйлийн (f)-д заасны дагуу Даргын тавьсан хязгаарлалт, эсхүл бусад нөхцлийг зөвшөөрсөн; эсхүл
- (2) тухайн агаарын хөлөг зөвхөн батлан хамгаалах, цагдаа, хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагын ажилтнуудыг тээвэрлэж байгаа тохиолдолд галт зэвсэг нь цэнэггүй байна; эсхүл
- (3) батлан хамгаалах, цагдаа, хууль хэрэгжүүлэгч бусад байгууллагын тусгай үүрэг гүйцэтгэж байгаа этгээд үүрэгт ажлынхаа дагуу тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байвал.

(f) Дарга цагдаа болон хууль хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагын хүсэлтийг үндэслэн:

- (1) батлан хамгаалах, цагдаа, хууль хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагаас галт зэвсэг тээвэрлэх шаардлагатай гэж үзэн хүсэлт тавьсан бол, хөлсөөр зорчигч тээвэрлэх агаарын тээврийн, эсхүл арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх нислэгт галт зэвсэг тээвэрлэхийг зөвшөөрч болно;
- (2) зохих нөхцөл, хязгаарлалт тавьж болно;
- (3) **уг байгууллагын** шийдвэрийг Ашиглагч болон хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.



(g) Дарга өөрөөр зөвшөөрөөгүй бол, энэ зүйлийн (f)-д заасны дагуу хүсэлт гаргагч нь Даргад тухайн агаарын тээврийн болон арилжааны агаарын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэхээр төлөвлөсөн өдрөөс нэг хоногийн өмнө гаргана.

(h) Энэ зүйлийн (f)-ийн (1)-д заасны дагуу галт зэвсэг **тээвэрлэх** этгээдийн тоо болон түүний агаарын хөлөгт байрлах байршлын талаар агаарын тээврийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө тухайн агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байна.

### **91.11. Агаарын хөлөг, түүний тоног төхөөрөмжийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцох**

Аливаа этгээд агаарын хөлгийн аливаа эд анги, тоноглол, утааны мэдрэгч, үйл ажиллагаанд ашиглаж буй суурин болон зөөврийн төхөөрөмж, навигацийн тоног төхөөрөмж (эдгээрээр хязгаарлахгүй)-ийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

### **91.13. Агаарын хөлгийн дуу чимээ болон чичирхийлэлт**

Дараах тохиолдолд аэродромын орчимд агаарын хөлгөөс гарах дуу чимээ, эсхүл чичирхийлэл нь .....шаардлагаас чөлөөлөгдөнө:

- (1) тухайн агаарын хөлөг хөөрөлт, эсхүл буулт үйлдэж байгаа бол; эсхүл
- (2) газар, эсхүл усан дээр тухайн агаарын хөлөг явгалах хөдөлгөөн хийж байгаа бол; эсхүл
- (3) тухайн агаарын хөлгөөр хөөрөлт үйлдэхийн өмнө дараах зүйлсийг шалгах зорилгоор хөдөлгүүр ажиллуулж байгаа бол:
  - (i) хөдөлгүүр тохирох үзүүлэлтэд хүрч байгаа эсэхийг; эсхүл
  - (ii) хэрэглэл, хэрэгсэл, эсхүл бусад төрөөрөмжүүд нь тохирох нөхцөлд байгаа эсэхийг.

### **91.15. Агаарын хөлгийг түлшээр цэнэглэх**

Аливаа этгээд агаарын хөлгийг түлшээр цэнэглэх, эсхүл юүлэхдээ дараах зүйлсийг баталгаажуулна:

- (1) зорчигч агаарын хөлөгт байх, суух, буух, эсхүл аль нэг хөдөлгүүр ажиллаж байх үед агаарын хөлгийг 3.1А ангиллын түлшээр цэнэглэх, эсхүл юүлэхийг хориглоно; эсхүл
- (2) зорчигч агаарын хөлөгт байх, суух, буух үед агаарын хөлгийг 3.1С, эсхүл 3.1D ангиллын түлшээр цэнэглэх, эсхүл юүлэхийг хориглоно.

## **Б Бүлэг. Үйл ажиллагааны шаардлага**

### **91.101. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар**

(a) Энэ зүйлийн (c) болон ИНД-103, ИНД-106-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд дараах шаардлагыг хангаагүй бол нислэгийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

(1) тухайн агаарын хөлөг нь:

- (i) хүчин төгөлдөр НТЧ-ын гэрчилгээгүй;
- (ii) НТЧ-гүй; эсхүл

(2) ИНД-21-ийн дагуу тусгай нислэгийн зөвшөөрөл олгогдоогүй агаарын хөлөг.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл тусгай нислэгийн зөвшөөрөлтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэх этгээд дараах шаардлагыг хангасан байна:

(1) НТЧ-ын гэрчилгээ, эсхүл тусгай нислэгийн зөвшөөрөлтэй цуг олгогдсон үйл ажиллагааны хязгаарлалтын хүрээнд;

(2) агаарын хөлөгт ИНБД-ийн дагуу шаардсан тэмдэглэгээ, зурган мэдээлэл тавина.

(c) Аливаа этгээд дараах шаардлагыг хангасан бол хүчин төгөлдөр НТЧ-ын гэрчилгээгүй агаарын хөлгөөр НТЧ-ын гэрчилгээ олгох, сунгах, эсхүл сэргээх зорилгоор нислэг үйлдэж болно:

(1) ИНД-21-ийн “Б” Бүлгийн дагуу олгогдсон, тухайн агаарын хөлгийн маягийн, эсхүл маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээтэй;

(2) ИНД- 21.191-ийн шаардлагыг хангасан;

(3) ИНД-43.101-ийн (a)(1)- (5) дахь заалтын зохих шаардлагыг хангасан этгээд тухайн агаарын хөлгийг “нислэгт тэнцэнэ” гэдгийг баталгаажуулсан;

(4) агаарын хөлгийн дарга нь ИНД-61-ийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэх болон тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй, эсхүл хүлээн зөвшөөрсөн гэрчилгээтэй;

(5) нислэгийн үйл ажиллагаанд оролцох зайлшгүй шаардлагатайгаас бусад этгээдийг тээвэрлээгүй бол.

### **91.103. НТЧ-ын хязгаарлагдмал ангиллын гэрчилгээ - үйл ажиллагааны хязгаарлалтууд**

ИНД-21-ийн “Е” Бүлгийн дагуу олгогдсон НТЧ-ын *хязгаарлагдмал ангиллын* гэрчилгээтэй агаарын хөлгөөр, дор зааснаас бусад этгээдэд нислэгийн зааварчилгаа өгч нислэг үйлдэхийг зөвшөөрөхгүй:

- (1) маягийн зэрэглэлийн шилжин сургалтын зааварчилгаа; эсхүл
- (2) хөдөө аж ахуйн зэрэглэл олгох нислэгийн зааварчилгаа; эсхүл
- (3) тодорхой зорилго бүхий нислэгийн дагуу гэрчилгээжсэн агаарын хөлгийн нислэгийн зааварчилгаа.

**91.105. НТЧ-ын тусгай ангиллын гэрчилгээ - үйл ажиллагааны хязгаарлалтууд**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд НТЧ-ын *тусгай ангиллын* гэрчилгээтэй агаарын хөлгөөр зорчигч, эсхүл ачааг төлбөртэй тээвэрлэн нислэгийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

(b) Дараах шаардлагыг хангасан, НТЧ-ын *тусгай ангиллын* гэрчилгээтэй агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэх этгээдэд энэ зүйлийн (a) заалт хамаарахгүй:

- (1) ИНД-61-ийн дагуу багшлах эрхийн зэрэглэлтэй бөгөөд:
  - (i) энэ зүйлийн (e), (f)(2)(i), (g)(1) болон (j)(2)(i)-д заасны дагуу агаарын хөлөгт нислэгийн зааварчилгаа өгч байгаа бол; эсхүл
  - (ii) агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн шилжин сургалтын зааварчилгаа өгч буй бол; эсхүл
- (2) энэ зүйлийн (e)-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай этгээд бол; эсхүл
- (3) тухайн агаарын хөлөг нь *тусгай ангиллын – үндсэн (primary), тусгай ангиллын – хэт хөнгөн спортын агаарын хөлөг (LSA), тусгай ангиллын – хязгаарлагдмал (limited)* НТЧ-ын гэрчилгээтэй болон Даргаас ИНД-115-ын дагуу олгосон сонирхогчийн нислэгийн үйл ажиллагааны гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа бол.

(c) Дарга бичгээр тусгайлан зөвшөөрөөгүй бол хөөрөлт, буулт үйлдэхээс бусад тохиолдолд хот, суурин буюу хүн ам шигүү суурьшсан нутаг дэвсгэрийн дээгүүр НТЧ-ын *тусгай ангиллын* гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно.

(d) НТЧ-ын *тусгай ангиллын* гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэж байгаа этгээд нь тухайн агаарын хөлгийн онцлогийн талаар агаарын хөлгийн бүхээгт байгаа бүх этгээдэд ИНД-21.205-д заасан тэмдэглэгээний дагуу анхааруулж мэдэгдэнэ.

(e) Дор дурдсанаас бусад тохиолдолд, аливаа этгээд *тусгай ангиллын – туршилтын (experimental)* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно:

- (1) агаарын хөлгийн шинэ загварын концепцийн судалгаа, шинжилгээний ажил хийх, агаарын хөлгийн шинэ тоног төхөөрөмж, шинэ тоноглолын

суурилуулалт болон агаарын хөлгийн үйл ажиллагааны шинэ аргачлал (technique), шинэ агаарын хөлөг ашиглаж байгаа бол; эсхүл

- (2) агаарын хөлөг нь НТЧ-ын холбогдох дүрмийн шаардлагыг хангаж байгааг үзүүлж байгаа бол; эсхүл
- (3) нислэгийн дүгнэлт гаргах нислэг үйлдэж байгаа бол; эсхүл
- (4) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн шилжин сургалтын зааварчилгаа өгч байгаа бол.

(f) *Тусгай ангиллын – үзүүлэх (exhibition)* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр үйл ажиллагаа явуулах аливаа этгээд:

- (1) тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг дагалдан ирэх ИНД-47.55-ийн (с)-д заасны дагуу нислэг үйлдэнэ;
- (2) дараах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг хориглоно:
  - (i) Дарга зөвшөөрөөгүй бол нисгэгчийн үнэмлэх эсхүл зэрэглэл олгох зааварчилгаа өгөх нислэг, үүнд агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгох шилжин сургалтын зааварчилгаа өгөх нислэг хамаарахгүй;
  - (ii) хөдөө аж ахуйн нислэг;
  - (iii) ИНД-133-ийн дагуу нисдэг тэрэгний дүүжин нислэг. Хэрэв Дарга зөвшөөрсөн бол нисэхийн үзүүлэх нислэгт оролцож буй дүүжин нислэг хамаарахгүй;
  - (iv) тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг дагалдан ирэх ИНД-47.55-ийн (с)-д зөвшөөрөгдснөөс өөр этгээд тээвэрлэх, эсхүл энэ дэд зүйлийн 2.1-д зааснаас өөр этгээд тээвэрлэхийг.

(g) Аливаа этгээд дараах зорилгоор *тусгай ангиллын – сонирхогчийн бүтээсэн (amateur-built)* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно:

- (1) нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгох зааварчилгаа өгөх нислэг /үүнд тухайн агаарын хөлгийг бүтээсэн этгээд, эсхүл эзэн нь агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгох шилжин сургалтын зааварчилгаа өгөх нислэг хамаарахгүй/;
- (2) хөдөө аж ахуйн нислэг;
- (3) ИНД-133-ын дагуу нисдэг тэрэгний дүүжин нислэг.

(h) Аливаа этгээд дараах зорилгоор *тусгай ангиллын – үндсэн (primary)* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно:

- (1) хөдөө аж ахуйн нислэг;
- (2) ИНД-133-ийн дагуу нисдэг тэрэгний дүүжин нислэг.

(i) Аливаа этгээд, *тусгай ангиллын – хэт хөнгөн спортын агаарын хөлгийн (LSA)* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр хөдөө аж ахуйн нислэг үйлдэхийг хориглоно.

(j) Аливаа этгээд, *тусгай ангиллын – хязгаарлагдмал (limited)* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр:

(1) тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг **дагалдан ирэх** ИНД-47.55-ын (с)-д зөвшөөрсний дагуу нислэг үйлдэх;

(2) дараах зорилгоор үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

(i) Дарга зөвшөөрөөгүй бол нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл олгох зааварчилгаа өгөх нислэг, үүнд агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгох шилжин сургалтын зааварчилгаа өгөх нислэг хамаарахгүй:

(ii) хөдөө аж ахуйн нислэг:

(iii) ИНД-133-ын дагуу нисдэг тэрэгний дүүжин нислэг:

(iv) дараах тооноос ихгүй этээдийг тээвэрлэхийг:

**А. онгоцны хувьд 10-иас ихгүй:**

**В. нисдэг тэрэгний хувьд 5-аас ихгүй.**

### **91.107 Агаарын хөлгийн бүртгэл**

(a) Энэ зүйлийн (b) болон ИНД-106-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд дараах дүрэм, эсхүл зөвшөөрлийн дагуу улсын бүртгэлд бүртгэгдээгүй болон харагдахуйц бүртгэлийн дугааргүй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно:

(1) ИНД-47; эсхүл

(2) Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон зөвшөөрөл; эсхүл

(3) агаарын хөлгийн бүртгэлийг харилцан хүлээн зөвшөөрөх талаар бусад улстай байгуулсан гэрээний дагуу гадаад улсаас олгосон бүртгэл.

(b) Дараах тохиолдолд, энэ зүйлийн (a) хэсэг ИНД-148-ын дагуу үйлдвэрлэгчийн гэрчилгээжүүлсэн агаарын хөлөгт хамаарахгүй:

(1) гэрчилгээ эзэмшигчид ИНД-21-ийн дагуу НТЧ-ын *тусгай нислэгийн зөвшөөрөл (special flight permit – continuing authorization)* олгогдсон;

(2) шинэ агаарын хөлөг шалгах нислэгийн шатанд байгаа бол.

### **91.109 Агаарын хөлгийн нислэгийн заавар**

Аливаа этгээд, тухайн агаарын хөлгийн нислэгийн зааварт тусгагдсан хязгаарлалтуудын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

### **91.111 Агаарын хөлөгт авч явах шаардлагатай баримт бичиг**

Аливаа этгээд, ИНД-103, ИНД-104 болон ИНД-106-ийн дагуу гэрчилгээжсэнээс бусад агаарын хөлгийн бүхээгт дараах баримт бичгийг заавал авч явах үүрэгтэй:

- (1) 91.101-ийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, НТЧ-ын хүчинтэй гэрчилгээ, эсхүл түүний баталгаажсан хуулбар;
- (2) агаарын хөлгийн нислэгийн заавар, эсхүл үүнтэй тэнцэхүйц Даргын хүлээн зөвшөөрсөн баримт бичиг;
- (3) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт:
  - (i) 91.619-д шаардсан агаарын хөлгийн техникийн бүртгэл;
  - (ii) жин ба төвлөрөлтийн өгөгдөл, эсхүл үүнтэй тэнцэхүйц баримт бичиг;
  - (iii) агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ;
- (4) гадаад улсад нислэг үйлдэж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт:
  - (i) радио холбоо ашиглах эрхийн гэрчилгээний хуулбар;
  - (ii) агаарын хөлгийн хүчин төгөлдөр бүртгэлийн гэрчилгээ, эсхүл түүний баталгаажсан хуулбар;
- (5) Монгол Улсад нислэг үйлдэж байгаа гадаад улсын бүртгэлтэй агаарын хөлөгт:
  - (i) агаарын хөлгийн хүчин төгөлдөр бүртгэлийн гэрчилгээ, эсхүл түүний баталгаажсан хуулбар;
  - (ii) 91.803-ын (а)(2)-т заасан агаарын хөлгийн дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ болон 91.807-ийн (а)(2)-т заасан хөдөлгүүрээс гарах хорт утааны зөвшөөрөгдөх хэмжээний шаардлагыг хангасан баримт бичиг.

### **91.112 Нислэгийн өдөр тутмын бүртгэл тэмдэглэл**

(а) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, Ашиглагч нь нислэг бүрт дараах мэдээллийг багтаасан өдөр тутмын бүртгэл тэмдэглэлийг хөтөлж, хадгална:

- (1) Ашиглагчийн нэр;
- (2) агаарын хөлгийн даргын нэр;
- (3) нисэх бүрэлдэхүүний бусад гишүүдийн нэрс;
- (4) агаарын хөлгийн бүртгэлийн дугаар;
- (5) нислэгийн огноо;
- (6) нислэгийн зорилго;

- (7) нислэг эхэлсэн цаг;
- (8) хөөрсөн аэродромын нэр;
- (9) нислэгийн цаг.

(b) Ашиглагч нь өдөр тутмын нислэгийн тэмдэглэлээ тухайн нислэг үйлдсэн өдрөөс хойш 12 сарын хугацаанд хадгална.

(c) ИНД-115.455, эсхүл ИНД-135.503-т заасны дагуу өдөр тутмын нислэгийн тэмдэглэл хөтлөх этгээдээс энэ зүйлийн (a) болон (b)-д заасан зүйлсийг шаардахгүй.

### **91.113. Нисэх багийн гишүүдийн тоо**

Аливаа этгээд, агаарын хөлгийн нислэгийн зааварт тогтоосноос цөөн тооны нисэх багтайгаар нислэг үйлдэхийг хориглоно.

### **91.115. Агаарын хөлгийн үйлчлэгчид тавигдах шаардлага**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд 19-өөс дээш тооны зорчигч тээвэрлэх агаарын хөлгийн багийн гишүүнд дараах тооны агаарын хөлгийн үйлчлэгчийг томилох үүрэгтэй:

- (1) 20-50 зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт 1-ээс доошгүй;
- (2) 51-100 зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт 2-оос доошгүй;
- (3) 101-ээс дээш тооны зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт 2-оос доошгүй, мөн 50 зорчигч тутамд нэмэлт нэг үйлчлэгч.

(b) Дараах агаарын хөлөгт агаарын хөлгийн үйлчлэгч шаардахгүй:

- (1) шүхэрчид тээвэрлэж буй агаарын хөлөгт; эсхүл
- (2) агаарын бөмбөлөгт; эсхүл
- (3) *Хамааралгүй*;
- (4) 19 хүртэл зорчигч тээвэрлэх агаарын хөлөгт 4-өөс доош насны хүүхдийг 91.207-ийн (d)(1)-ийн дагуу тээвэрлэж байгаа бөгөөд нийт зорчигчийн тоо 24-өөс хэтрээгүй бол.

(c) Агаарын хөлгийн үйлчлэгч дараах шаардлагыг хангасан байна:

- (1) дараах тохиолдолд үүрэг гүйцэтгэх чадвартайгаа харуулсан байх:
  - (i) онцгой нөхцөлийн үед;
  - (ii) ослын үед зорчигчдыг агаарын хөлгөөс яаралтай гаргах нөхцөлд;
- (2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан ослын үед ашиглах тоног төхөөрөмжийг ажиллуулах чадвар эзэмшсэн байна.

### **91.117. Агаарын хөлгийн даргыг томилох**

- (a) Нэгээс дээш нисгэгчтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэх тохиолдолд Ашиглагч нь тухайн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх этгээдийг томилсон байна.
- (b) Энэ зүйлийн зорилгын үүднээс *Ашиглагч* гэдэгт тухайн агаарын хөлгийг нисгэх зөвшөөрөл, эсхүл нисэх шалтгааныг бий болгож буй этгээдийг ойлгоно.

### **91.119. Агаарын хөлгөөр явгалалт үйлдэх**

Ашиглагч, эсхүл техник үйлчилгээний байгууллагаас зохих зөвшөөрөл олгогдоогүй аливаа этгээд, дараах шаардлагыг хангаагүй бол аэродромын хөдөлгөөнт бүсэд агаарын хөлгөөр явгалалт үйлдэхийг хориглоно:

- (1) агаарын хөлгөөр явгалалт үйлдэх чадвар эзэмшсэн байх;
- (2) радио холбоо ашиглах шаардлагатай бол радиотелефон холбоо ашиглах чадвартай байх;
- (3) тухайн аэродромын холбогдох газрын хөдөлгөөний дүрэм, журамтай танилцсан байх.

### **91.121. Зорчигчдын үйлчилгээнд зориулсан тоног төхөөрөмжийг хурааж бэхлэх**

Дараах тоног төхөөрөмжийг дор зааснаар байрлуулаагүй тохиолдолд агаарын хөлгөөр явгалалт, хөөрөлт ба буулт үйлдэхийг хориглоно:

- (1) зорчигчдын хоол, хоолны тавиур, эсхүл ширээг хураагаагүй бол; эсхүл
- (2) зорчигчдын үйлчилгээнд зориулсан тэргэнцрийг бэхлээгүй бол; эсхүл
- (3) зорчигчдын суудлын эгнээ рүү сунадаг дэлгэц хураагдаагүй бол.

### **91.123. Сургалтын нислэгт ашиглах агаарын хөлөгт тавигдах шаардлага**

Аливаа этгээд Дараах тоног төхөөрөмж суурилуулаагүй агаарын хөлгөөр (агаарын бөмбөлөгөөс бусад) сургалтын нислэг гүйцэтгэхгүй:

- (1) бүрэн ажиллагаатай хос удирдлага; эсхүл
- (2) аль ч нисгэгчийн суудлаас хөдөлгүүрийн чадал болон агаарын хөлгийн бүх тэнхлэгийн дагуух хөдөлгөөнийг удирдах удирдлага.

/pitch, roll, yaw, and engine power controls which can be operated at either crew station./

### **91.125 Хэрэглэлийн дуураймал нислэг**

- (a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, хэрэглэлийн дуураймал нислэг үйлдэх бол дараах шаардлагыг хангасан байна:



- (1) тухайн агаарын хөлөг нь хоёр нисгэгчийн суудалтай бөгөөд аль нэг нисгэгчийн суудал эзэлсэн **аюулгүй ажиллагаанд хяналт тавьж буй** нисгэгч нь хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэхтэй;
- (2) **аюулгүй ажиллагаанд хяналт тавьж буй** нисгэгч нь:
  - (i) агаарын хөлгийн урд болон хажуу талыг ажиглах боломжтой байх; эсхүл
  - (ii) нэмэлт харааны (adequately supplement the vision) ажиглалт хийх үр чадвартай байх;
- (3) агаарын хөлөгт дараах тоног төхөөрөмж суурилуулсан байна:
  - (i) бүрэн ажиллагаатай хос удирдлага; эсхүл
  - (ii) аль ч нисгэгчийн суудлаас хөдөлгүүрийн чадал болон агаарын хөлгийн бүх тэнхлэгийн дагуух хөдөлгөөнийг удирдах удирдлага.

*/pitch, roll, yaw, and engine power controls which can be operated at either crew station./*

(b) Энэ зүйлийн (a)(3)-т заасан шаардлагыг биелүүлээгүй агаарын хөлгөөр дараах тохиолдолд хэрэглэлийн дуураймал нислэг үйлдэхийг зөвшөөрнө:

- (1) хэрэглэлийн дуураймал нислэг нь хяналттай агаарын зайн гадна үйлдэгдэх бол;
- (2) агаарын хөлгийн дарга хэрэглэлийн дуураймал нислэгийн нөхцөлийг шууд өөрчлөн, хэвийн нислэгийн нөхцөлийг сэргээх боломжтой бол.

### **91.127. Аэродром ашиглах**

(a) Тухайн агаарын хөлгөөр хөөрч, буухад тохиромжгүй бол аливаа этгээд тухайн аэродромыг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахгүй.

(b) Аливаа этгээд дараах шаардлага хангаагүй аэродромыг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно:

- (1) тухайн аэродром эзэмшигчийн зүгээс тавьсан аэродром ашиглалтын хязгаарлалт, нөхцлүүдийг биелүүлэх боломжтой;
- (2) хөөрч буух зурвас, нисдэг тэрэгний талбай, усан дээр буух тайлбай нь тухайн агаарын хөлөгт тохирсон шөнийн цагт хөөрөлт, буулт үйлдэх гэрэлтүүлгээр тоноглогдсон, гэрэлтүүлэг нь ажиллагаатай;
- (3) тухайн аэродромын тодорхой хөдөлгөөний хэсэг агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюултай гэж тэмдэглэгдсэн, эсхүл аэродром эзэмшигчээс энэ тухай мэдэгдсэн бол;
- (4) аэродром дээрх үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй аливаа этгээд, машин техник, бусад саадууд нь хөөрч буух зурвасны ойролцоо, эсхүл талбайд байрлаагүй бол.

(с) Дараах нөхцөлд аливаа нисгэгч агаарын хөлгөөр аэродром орчмын хайрцаг нислэгийн хөдөлгөөнд оролцохгүй:

- (1) ямар нэгэн саадтай бол;
- (2) өөр аэродромын хайрцаг нислэгийн хөдөлгөөн, эсхүл хэрэглэлийн нислэгээр ойртолт үйлдэх журамтай зөрчилдөх бол.

(d) Энэ зүйлийн (а), (b), (с)-д зааснаас гадна, дараах зүйлсийг бататгаагүй бол аливаа этгээд нисдэг тэргээр нислэг үйлдэхгүй:

- (1) хот, суурингийн нутаг дэвсгэрт нисдэг тэрэгний хөөрч буух талбай, эсхүл дүүжин нислэг үйлдэх бүс болгон ашиглах талбайн орчны физик газар зүйн үзүүлэлт, саадын хязгаарлалт нь нислэг үйлдэж буй нисдэг тэрэгний үзүүлэлтэд тохирохгүй, ил харааны таних тэмдэг, гэрэлтүүлэг, тэмдэглэгээ суурилуулаагүй бол;
- (2) хот, суурингийн гадна нисдэг тэрэгний хөөрч буух талбай, эсхүл дүүжин нислэг үйлдэх бүс болгон ашиглах талбай нь дараах шаардлагыг хангаагүй бол:
  - (i) нисдэг тэрэг саадаас чөлөөтэй дүүжин нислэг хийхэд тохиромжтой;
  - (ii) талбай (heliport) нь нисдэг тэрэг хөөрч буухад тохиромжтой байх;
- (3) 1-р ангиллын нисдэг тэрэгнээс бусад, нисдэг тэрэгний буулт, хөөрөлт болон авторотацитай буулт үйлдэхэд газар дээр байгаа аливаа зүйлд хохирол учруулах бол.

#### **91.129. Хязгаарлалттай болон аюултай бүсэд нислэг үйлдэх**

(а) ИНД-71-ийн дагуу тогтоосон хязгаарлалттай бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- (1) хяналт тавих эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй бол;
- (2) хязгаарлалттай бүсэд тогтоосон нөхцөлийг биелүүлэх боломжгүй бол;
- (3) хязгаарлалттай бүсэд хяналт тавих байгууллагаас тогтоосон аливаа нөхцлийг биелүүлэх боломжгүй бол.

(b) ИНД-71-ийн дагуу тогтоосон аюултай бүсэд нислэг үйлдэхээр төлөвлөсөн нислэг, агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэдгийг тухайн нисгэгч тогтоогоогүй бол энэхүү бүсэд нислэг үйлдэхгүй.

#### **91.131. Нам өндрийн нислэгийн бүс**

(а) ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- (1) шөнийн цагт; эсхүл

(2) өдрийн цагт дараах шаардлагыг хангаагүй бол:

(i) тухайн нисгэгч нь:

- A. нислэгийн зааварчилга авч байгаа; эсхүл
- B. ИНД-61-ийн дагуу олгогдсон багш-нисгэгчийн зэрэглэлтэй байх; эсхүл
- C. тухайн нислэг үйлдэх эрхийг ИНД-61-ийн дагуу олгогдсон багш-нисгэгчийн зэрэглэлтэй нисгэгч олгосон бөгөөд нам өндрийн нислэгийн бүсийн хязгаар болон энэхүү бүс рүү орох, гарах аргачлалыг нислэгийн өмнөх ярианд гүйцэтгэсэн байх;
- (ii) тухайн нисгэгч нам өндрийн нислэгийн үйл ажиллагааны хязгаарлалттай танилцсан байх;
- (iii) тухайн нисгэгч нам өндрийн нислэгийн үйл ажиллагааны хязгаарлалтын хүрээнд нислэг үйлдэх;
- (iv) тухайн нисгэгч нам өндрийн нислэгийн бүсэд орохын өмнө холбогдох VHF давтамж дээр нам өндрийн нислэг үйлдэх хугацаа болон гүйцэтгэх үйлдэл, маневруудын дэлгэрэнгүйг мэдээлэх;
- (v) тухайн нисгэгч нам өндрийн нислэгийн бүсэд холбогдох VHF давтамж дээр байнгын хяналттай байж тус бүсийг орхихдоо мэдээлнэ.

(b) ИНД-71-д заасны дагуу нам өндрийн нислэгийн бүсэд нислэг үйлдэж буй нисгэгч газарт байгаа аливаа этгээд болон эд зүйлд аюулгүй нислэг үйлдэнэ.

(c) ИНД-71-д заасны дагуу нам өндрийн нислэгийн бүсэд нислэг үйлдэж буй нисгэгч агаарын хөлөгтөө зорчигч тээвэрлэхгүй.

### **91.133. Цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд нислэг үйлдэх**

ИНД-71-д заасны дагуу цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- (1) тухайн цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд хяналт тавих байгууллагаас нислэг үйлдэх зөвшөөрөл аваагүй бол:
  - (i) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг бол; эсхүл
  - (ii) гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд нислэг үйлдэх бол;
- (2) цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд тогтоосон нөхцөлийг биелүүлэх боломжгүй бол;
- (3) цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд хяналт тавих байгууллагаас тогтоосон аливаа нөхцлийг биелүүлэх боломжгүй бол.

**91.135. Заавал мэдээлэх бүсэд нислэг үйлдэх**

(a) Энэ зүйлийн (b), (c)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг хангаагүй бол ИНД-71-д заасан заавал мэдээлэх бүсэд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

(1) тухайн бүсэд тогтоосон радио холбооны давтамж дээр дараах мэдээллийг өгсөн байна:

(i) **тухайн бүсэд орох** - агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр болон заавал мэдээлэх бүсэд үйлдэх нислэгийн төлөвлөлт;

(ii) **заавал мэдээлэх бүс дэх аэродромын хайрцаг нислэгийн тойрогт орох** - агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр ба нислэгийн төлөвлөлт;

(iii) **заавал мэдээлэх бүс дэх аэродромоос хөөрөх зурвасанд орохын өмнө** - агаарын хөлгийн дуудлага, хөөрөлт үйлдэх зурвасны чиглэл, хөөрөлтийн дараах нислэгийн төлөвлөлт;

(iv) **нислэгийн мэдээлэл дамжуулах шаардлагатай гэж үзсэн үед** - агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр болон нислэгийн төлөвлөлт;

(2) заавал мэдээлэх бүсэд тогтмол радио холбооны хяналттай байх;

(3) агаарын хөлөг суултын, эсхүл мөргөлдөхөөс сэргийлэх гэрлээр тоноглогдсон бол асаасан байх.

(b) Заавал мэдээлэх бүсэд группээр нислэг үйлдэх агаарын хөлгүүд энэ зүйлийн (a)-ийн (1) болон (2)-ыг үл харгалзан, дараах шаардлагыг хангасан бол нислэг үйлдэж болно:

(1) группээр нисэж буй нисгэгчид (a)(3)-ын заалтыг мөрдөж байгаа бол;

(2) удирдан нисэж буй нисгэгч нь (a)(1) болон (2)-ыг мөрдөж байгаа бол.

(c) Заавал мэдээлэх бүсэд радио холбоо нь ажиллагаагүй агаарын хөлгөөр дараах тохиолдолд радио холбоогоо засварлах зорилготой нислэг үйлдэхийг зөвшөөрнө:

(1) нисгэгч нь энэ зүйлийн (a)(3)-ыг мөрдөж байгаа бол;

(2) нисгэгч нь энэ зүйлийн (a)(1)-д заасан мэдээллийг өөрийн өмнөөс хэн нэгнээр дамжуулах боломжтой бол.

(d) Заавал мэдээлэх бүсэд шүхэр буулгах үйл ажиллагаа гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр болон шүхрээр буух этгээдийн тоо, нислэгийн төлөвлөлтийг тухайн ажиллагаа эхлэхээс өмнө мэдээлнэ.

### **91.137. Галт уулын аюултай бүсэд нислэг үйлдэх**

Галт уулын аюултай бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- (1) шөнийн цагаар, эсхүл
- (2) хэрэглэлээр нисэх цаг агаарын нөхцөлд, эсхүл
- (3) өдрийн цагт, ил харааны цаг агаарын нөхцөлд галт уулын аюултай бүсэд нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөл бүрдсэнийг дараах эх сурвалжаас авч бататгаагүй бол:
  - (i) SIGMET-д зарлагдсан холбогдох цаг агаарын мэдээлэл:
  - (ii) NOTAM мэдээлэл:
  - (iii) ИНД-174-ийн дагуу гэрчилгээжсэн байгууллагаас өгөгдсөн холбогдох бусад мэдээлэл.

### **91.139. Ерөнхий зориулалтын нисэхийн районд нислэг үйлдэх**

ИНД-71-д заасан ерөнхий зориулалтын нисэхийн районд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- (1) шөнийн цагаар; эсхүл
- (2) өдрийн цагт дараах зүйлсийг бататгаагүй бол:
  - (i) өдрийн цагт ерөнхий зориулалтын нисэхийн район нь байнгын идэвхтэй (active); эсхүл
  - (ii) тухайн агаарын зайд хяналт тавьж буй НХҮ-ний байгууллагаас ерөнхий зориулалтын нисэхийн районыг идэвхжүүлсэн бол тухайн бүсэд нисэх зөвшөөрлийг НХҮ-ний байгууллагаас авсан байх ба НХҮ-ний байгууллагаас өгсөн ерөнхий зориулалтын нисэхийн районыг орхих болон бусад бүх зааварчилгыг биелүүлнэ; эсхүл
  - (iii) тухайн агаарын зайг ашиглах хэрэглэгчээс тухайн агаарын зайд хяналт тавьж буй НХҮ-ний байгууллагад мэдэгдэж нисэхийн районыг идэвхжүүлсэн бол урьдчилан мэдэгдэнэ.

## **В Бүлэг. Нислэгийн ерөнхий дүрэм**

### **91.201. Агаарын хөлгийн даргын үүрэг**

Агаарын хөлгийн дарга дараах үүрэгтэй:

- (1) нислэгийн өмнө дор дурдсан зүйлсийг шалгасны дараа агаарын хөлөг нь нислэгт тэнцэх чадвартай болон аюулгүй нислэг үйлдэх боломжтой гэдгийг бататгах:

- (i) ИНД- 91.111-ийн шаардлагад нийцсэн баримт бичиг;
- (ii) нислэгийн өмнөх үзлэг;
- (2) нислэгийн бүх хугацаанд агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, тээвэрлэж байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангах;
- (3) энэ хэсгийн (1)-д заасан үзлэг, шалгалт болон нислэгийн дараа тухайн агаарын хөлгийн үзлэг, шалгалт, нислэгийн үед нисэх багт мэдэгдсэн аливаа дутагдлын талаар техникийн дэвтэрт, эсхүл Дарга хүлээн зөвшөөрсөн баримт бичигт тэмдэглэнэ.

### **91.203. Агаарын хөлгийн даргын эрх**

Агаарын хөлгийн дарга агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа зорчигч болон эд зүйлсийн аюулгүй ажиллагаатай холбоотой тушаал, заавар өгөх, мөн агаарын хөлөг, зорчигчийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэж үзсэн тохиолдолд дараах этгээд болон ачааг тээвэрлэхээс татгалзах эрхтэй:

- (1) мансууруулах бодис болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээд нь агаарын хөлөг болон зорчигчдод аюул учруулж болзошгүй гэж үзсэн бол;
- (2) аливаа этгээд болон ачаа тээш нь агаарын хөлөг болон зорчигчдод аюул учруулж болзошгүй гэж үзсэн бол.

### **91.205. Багийн гишүүдийн ажлын байр**

(a) Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлгийн хөөрөлт, буултын үед багийн гишүүн бүр:

- (1) агаарын хөлгийн ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэхээс бусад тохиолдолд ажлын байрандаа байна;
- (2) ажлын байранд байх хугацаандаа хамгаалах бүсээ бүсэлсэн байна.

(b) Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлгийн хөөрөлт, буултын үед багийн гишүүн нь мөрөвчит хамгаалах бүсийг бүсэлсэн байна. Энэ заалт нь дараах тохиолдолд хамаарахгүй:

- (1) багийн гишүүний ажлын байрны суудал нь мөрөвчит хамгаалах бүсээр тоноглогдоогүй; эсхүл
- (2) мөрөвчит хамгаалах бүсээ бүсэлсэн үед ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй бол.

### **91.207. Хамгаалах бүс хэрэглэх**

(a) Агаарын хөлгийн дарга нислэгийн дараах үе шатуудад зорчигчдыг суудалдаа сууж, хамгаалах бүсээ бүслэхийг шаардана:

- (1) хөөрөлт, буултын үед;
  - (2) агаарын хөлөг газрын гадаргуугаас дээш 300м (1000ft) ба түүнээс нам өндөрт нислэг үйлдэх үед;
  - (3) аюулгүй байдлыг хангах үүднээс агаарын хөлгийн дарга шаардлагатай гэж үзсэн бүх хугацаанд;
  - (4) уран жолоодлогын нислэгийн үед;
  - (5) бүхээгийн хаалтгүй агаарын хөлөгт (open cockpit).
- (b) Хэрэв аюулгүй гэж үзвэл агаарын хөлгийн дарга нислэгийн зорилготой холбоотой үүрэг гүйцэтгэж буй зорчигчоос хамгаалах бүсээ бүслэхийг дор дурдсан нислэгийн явцад шаардахгүй байж болно:
- (1) хөөрөлт, буултын үед;
  - (2) агаарын хөлөг газрын гадаргуугаас дээш 300м (1000ft) ба түүнээс нам өндөрт нислэг үйлдэх үед.
- (c) Хөөрөлт, буултын үед агаарын хөлгийн дарга зорчигчдоос суудлын түшлэгийг хөөрөлт, буултын байрлалд тохируулахыг шаардана.
- (d) Энэ зүйлийн (a)(1), (2) болон (3) дахь заалтууд дараах тохиолдолд дөрвөөс доош насны хүүхдэд хамаарахгүй:
- (1) асран хамгаалагч нь насанд хүрсэн, зорчигчийн суудалд сууж хүүхдийг тэвэрч яваа болон хүүхдэд бэхэлсэн хамгаалах бүс нь харгалзан яваа хүний хамгаалах бүсэнд бэхлэгдсэн бол; эсхүл
  - (2) зорчигчийн суудал нь хүүхдийн хамгаалах хэрэгслээр тоноглогдсон, хүүхэд тухайн хэрэгсэлд тогтоосон жингийн хязгаарлалтаас хэтрээгүй, асран хамгаалагч нь нислэгийн явцад аюулгүй байдалд анхаарал тавих боломжтой бол.
- (e) Энэ зүйлийн (a) заалт агаарын бөмбөлөгийн зорчигч болон шүхрээр буух этгээдэд хамаарахгүй.

#### **91.209. Хүчилтөрөгчийн тоноглол ашиглах**

- (a) Битүүмжлэлгүй агаарын хөлгөөр, далайн түвшнээс дээш 3000-4000 м (10000-13000 ft )-ийн өндөрт 30 минутаас дээш, эсхүл далайн түвшнээс дээш 4000 м (13000 ft)-ийн өндөрт нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь нислэгийн дээрх хугацаанд дараах зүйлсийг шаардана:
- (1) багийн гишүүд болон зорчигчид нэмэлт хүчилтөрөгч ашиглах;
  - (2) багийн гишүүд ажлын байрнаас холдох шаардлагатай үед хүчилтөрөгчийн баг, тохируулагч бүхий зөөврийн хүчилтөрөгч ашиглах.

(b) Битүүмжлэлтэй агаарын хөлгийн хувьд агаарын хөлгийн дарга:

- (1) бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр далайн түвшнээс дээш 3000 м (10000 ft)-ээс дээш байгаа бүх хугацаанд дараах зүйлсийг шаардана:
  - (i) багийн гишүүдийг нэмэлт хүчилтөрөгч ашиглах;
  - (ii) багийн гишүүд ажлын байрнаас холдох шаардлагатай үед хүчилтөрөгчийн багтай тохируулагч бүхий зөөврийн хүчилтөрөгч хэрэглэх;
- (2) нислэгийн цуваа 10700-12500 м (FL350-410)-ийн хооронд нислэг үйлдэх үед дараах зүйлсийг шаардана:
  - (i) дээрхи өндрийн хооронд нисч байхдаа аль нэг нисгэгч нь нэмэлт хүчилтөрөгч тогтмол хэрэглэх, эсхүл бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр далайн түвшнээс дээш 4000 м (13000 ft)-ээс хэтэрсэн үед автоматаар хангагддаг нэмэлт хүчилтөрөгчтэй байх; эсхүл
  - (ii) хоёр нисгэгч өөрсдийн ажлын байрнаас 5 секундын дотор багтай хүчилтөрөгч авч хэрэглэх боломжтой байх;
- (3) нислэгийн өндөр далайн түвшнээс дээш 12500 м (41000 ft)-ээс дээш үед нисгэгчийн суудалд үүрэг гүйцэтгэж буй аль нэг нисгэгч дээрх өндрөөс дээшхи нислэгийн бүх хугацаанд хүчилтөрөгч хэрэглэхийг шаардана.

(c) Битүүмжлэлтэй агаарын хөлгийн битүүмжлэлийн системд гэмтэл гарсны дараа уг агаарын хөлөг 4 минутын хугацаанд далайн түвшнээс дээш 4200 м (14000 ft) ба түүнээс доош өндөрт орж чадахгүй тохиолдолд бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь далайн түвшнээс дээш 4200 м (14000 ft)-ээс дээш байх хугацаанд бүх зорчигч нэмэлт багтай хүчилтөрөгч хэрэглэхийг агаарын хөлгийн дарга шаардана.

### **91.211. Зорчигчдод өгөх мэдээлэл**

(a) Ашиглагч нь зорчигч тээвэрлэж байгаа бол дараах мэдээллийг зорчигчдод өгсөн байна:

- (1) тамхи татаж болох нөхцөлийн талаар;
- (2) 91.121 болон 91.207-д заасан холбогдох шаардлагууд;
- (3) үндсэн хаалганууд болон аврах гарцуудын байрлал, тэдгээрийг ашиглах заавар;
- (4) энэ дүрмийн дагуу дараах төхөөрөмж суурилуулсан бол:
  - (i) зорчигчдод зориулсан авран хамгаалах болон онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх тоноглолын байрлал;



- (ii) усан дээгүүрх нислэгийн үед 91.525-д шаардсан хөвөгч төхөөрөмжийг хэрэглэх заавар;
  - (iii) зорчигчдод зориулсан агаарын хөлөгт суурилуулсан онцгой болон хэвийн үед хэрэглэх хүчилтөрөгчийн төхөөрөмжийн ашиглах заавар;
  - (5) онцгой нөхцөлд буулт үйлдэх үед мөрдөх журам;
  - (6) 91.7-д заасан зөөврийн цахим хэрэгслүүдийг ашиглах журам.
- (b) Энэ зүйлийн (a)-д заасан мэдээллийг:
- (1) агаарын хөлгийн дарга, эсхүл багийн гишүүн, эсхүл ашиглагчаас томилогдсон этгээд өгнө, эсхүл дүрс бичлэг ашиглан танилцуулж болно;
  - (2) нислэгийн цуваа 7600 м (FL250)-ээс дээш байх тохиолдолд хүчилтөрөгчийн төхөөрөмж ашиглах зааврыг танилцуулна;
  - (3) энэ дүрмийн дагуу шаардсан бол ослын үед аврах хантааз хэрэглэх заавар;
  - (4) шаардлагатай бол иргэний нисэхийн холбогдох дүрэмд шаардсаны дагуу гэрлэн тэмдэгтүүд болон багийн гишүүдээс өгч буй заавар, мэдээллийг бүх зорчигчид дагаж мөрдөх тухай журам;
  - (5) дараах зүйлсийг агуулсан танилцуулгыг зорчигч бүрт нэмэлт заавар болгон ашиглаж болно:
    - (i) аврах хаалгуудыг ашиглах аргачлалыг харуулсан зураг;
    - (ii) аврах тоног төхөөрөмжийг ашиглахад шаардлагатай бусад зааврууд.
  - (6) хэрэв агаарын хөлгий дарга бүх зорчигчид өгөх мэдээллийн агуулгын талаар зорчигчид мэдэж буй гэж үзвэл мэдээлэл өгөхгүй байж болно.
- (c) Энэ зүйлийн (b)-ийн (5)-д заасан заалтын дагуу танилцуулгыг ашиглах тохиолдолд тохиромжтой газарт байрлуулж, агаарын хөлгийн маяг, загварт тохирсон мэдээллүүд агуулагдсан байна.

### **91.213. Гар тээшийг байрлуулах**

Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлөг ашиглаж буй этгээд хөөрөлт, буултын үед зорчигчийн гар тээшийг дор дурьдсан газар байрлуулна:

- (1) гар тээш байрлуулах тавиурт; эсхүл
- (2) зорчигчийн суудал дор дараах байдлаар:
  - (i) ослын үед урагшаа гулсахгүйгээр; эсхүл
  - (ii) онцгой нөхцөл байдлын үед агаарын хөлгөөс зорчигчдыг яаралтай гаргахад саад болохгүйгээр.

### **91.215. Ачаа тээвэрлэх**

(a) Ашиглагч ачааг тээвэрлэхдээ:

- (1) ачааг суудал дээр, ачааны тавцан, эсхүл ачаа тээшний хэсэгт байрлуулна;
- (2) газрын болон нислэгийн хэвийн үйл ажиллгаанд ачааг хөдөлгөөнгүй байлгахуйц хамгаалалтын тор болон бусад хэрэгслээр бэхэлсэн байна;
- (3) зорчигчдод гэмтэл учруулахаас сэргийлэн ачааг баглаж боосон байна.

(b) Ачаа тээвэрлэх зөвшөөрөлтэй Ашиглагч дараах нөхцөлд агаарын хөлгөөр ачаа тээвэрлэхийг хориглоно:

- (1) тээвэрлэх ачааны жин агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт заасан суудал, тавцан, шалны даацын хязгаарлалтаас хэтэрсэн бол; эсхүл
- (2) агаарын хөлгийн хаалга болон аврах гарцыг ашиглах боломжийг хязгаарлаж, эсхүл зорчигч болон нисэх багийн тасалгаа хооронд байрлуулсан бол.

### **91.217. Нислэгийн өмнөх мэдээлэл**

Нислэг эхлэхийн өмнө агаарын хөлгийн дарга тухайн нислэгтэй холбогдсон, дараах мэдээлэлтэй бүрэн танилцсан байна:

- (1) бодит цаг агаарын мэдээлэл;
- (2) шаардлагатай түлшний хэмжээ;
- (3) төлөвлөгдсөн нислэгийг төгсгөх боломжгүй болсон тохиолдолд боломжит нөөц аэродромууд;
- (4) НХҮ-ний байгууллагаас мэдэгдсэн, эсхүл гарч болзошгүй агаарын хөдөлгөөний саатал;
- (5) нислэгт ашиглах холбоо, навигацийн тоног төхөөрөмжийн нөхцөл байдал;
- (6) нислэгт ашиглах аэродромын бодит нөхцөл байдал, хөөрч буух зурвасны урт;
- (7) нислэг ашиглалтын зааварт байх хөөрөлт, буултын зайны өгөгдөхүүн;
- (8) олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд:
  - (i) нэг хөдөлгүүр татгалзсан үеийн журам;
  - (ii) нэг хөдөлгүүр татгалзсан үеийн нислэгийн үзүүлэлтийн өгөгдөхүүн.

### **91.219. Үйл ажиллагааны хязгаарлалт, аврах тоног төхөөрөмжтэй танилцах**

Нислэг эхлэхийн өмнө нисгэгч бүр дор дурдсан зүйлстэй танилцсан байна:

- (1) тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын заавар;

- (2) агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс эсхүл ИНЕГ-ын даргын тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалтыг багтаасан тэмдэг, тэмдэглэгээ, жагсаалтууд;
- (3) тухайн агаарын хөлөгт суурилуулсан онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх тоног төхөөрөмж;
- (4) онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх тоног төхөөрөмжийг ажиллуулахаар томилогдсон багийн гишүүн;
- (5) онцгой нөхцөл байдлын үед зориулалтын тоног төхөөрөмжийг хэрэглэх журмууд.

#### **91.221. Нислэгийн тоног төхөөрөмж болон үйл ажиллагааны мэдээлэл**

(a) Агаарын хөлгийн дарга нисэх багийн бүх гишүүдийг дор дурдсан тоног төхөөрөмж болон хүчин төгөлдөр гарын авлага, мэдээллийг хэрэглэх нөхцөлөөр хангасан гэдгийг бататгана:

- (1) цаг хугацаа заах хэрэгсэл;
- (2) холбогдох агаарын навигацийн зураг;
- (3) хэрэглэлийн нислэгт зориулсан нисэн гарах, чиглэл, аэродром, ойртолт буултын үед ашиглагдах навигацийн зургууд;
- (4) шөнийн нислэгт зориулсан гар чийдэн (нисэх багийн гишүүн бүр).


(b) Энэ зүйлийн (a)-д зааснаас гадна, 5700 кг-аас дээш хөөрөлтийн жинтэй эсхүл 9-с дээш зорчигчтой агаарын хөлгийн дарга тухайн агаарын хөлгийн нислэг ашиглалтын зааварт заасны дагуу нислэгийн хэвийн болон онцгой нөхцөлийн үед хэрэглэх хяналтын хуудас нисэх багийн гишүүд ашиглаж буйг баталгаажуулна.

#### **91.223. Аэродром болон түүний ойролцоо нислэг үйлдэх**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аэродром болон түүний ойролцоо нислэг үйлдэж буй нисгэгч нь:

- (1) мөргөлдөхөөс сэргийлэх зорилгоор аэродромын орчны бусад агаарын хөлгийн хөдөлгөөнийг ажиглана;
- (2) НХУ-аас өгөгдсөн зааварчилга эсхүл зөвшөөрөл олгоогүй бол, аэродромын орчинд явагдаж буй бусад агаарын хөлгийн хайрцаг нислэгт нийцүүлэх буюу тэдгээрээс аюулгүй зайд ниснэ;
- (3) тухайн аэродромд Монгол улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP) өөрөөр заагаагүй бол дор дурдсанаар бусад нөхцөлд аэродромын хайрцаг нислэг үйлдэхэд зүүн гар тийш эргэн хөөрөлт, буулт гүйцэтгэнэ:
  - (i) НХУ-аас өгөгдсөн зааварчилга эсхүл зөвшөөрөл олгосон; эсхүл

- (ii) Монгол улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP) заасны дагуу тухайн аэродромын хэрэглэлийн нислэгийн журмын дагуу буулт, ойртолт үйлдэх эсхүл хөөрсний дараа баруун гар тийш эргэлт хийх хэрэглэлийн нислэгийн журам тогтоосон;
  - (4) тухайн аэродромд Монгол улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP) аэродромын хайрцаг нислэг үйлдэхэд баруун гар тийш эргэн хөөрөлт, буулт гүйцэтгэхээр заасан бол дор дурдснаас бусад нөхцөлд баруун гар тийш эргэнэ:
    - (i) НХУ-аас өгөгдсөн заавар болон зөвшөөрөл олгосон; эсхүл
    - (ii) Монгол улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP) заасны дагуу тухайн аэродромын хэрэглэлийн нислэгийн журмын дагуу буулт, ойртолт үйлдэх эсхүл хөөрсний дараа зүүн гар тийш эргэлт хийх хэрэглэлийн нислэгийн журам тогтоосон;
  - (5) НХУ-аас өгөгдсөн зааварчилга болон зөвшөөрөл олгоогүй бол нисгэгч ~~ИНД-93-т заасан~~ тухайн аэродромын тусгай хөдөлгөөний журмуудыг дагаж мөрдөнө.
- (b) Энэ зүйлийн (a)-ийн (3), (4) (5)-д заасан заалт 91.703-т заасны дагуу үзүүлэх нислэгт оролцож буй агаарын хөлгийн даргад хамаарахгүй.
- (c) Энэ зүйлийн (a)-ийн (3) болон (4)-т заасан заалтыг үл харгалзан, хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга аэродромд буухаар ойртолт үйлдэх болон хөөрсний дараа Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд (AIP) аль ч чиглэлд эргэлт хийж болно гэж заасан бол дор дурдсан шаардлагыг хангасан байна:
- (1) тухайн аэродром нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээгүй бол;
  - (2) тухайн зурвасны дагуу зураг 1-т заасан газрын тэмдэглэгээг байршуулсан байна;
  - (3) аэродромын бусад хөдөлгөөнтэй зөрчилдөөгүй бол.
- (d) Энэ зүйлийн (b), (c)-д хамааралтайгаар, нисдэг тэрэгний дарга энэ зүйлийн (a)-г дагаж мөрдөнө, эсхүл тухайн аэродромд хайрцаг нислэг үйлдэж буй онгоцонд саад болохгүйгээр нислэг гүйцэтгэнэ.



**Зураг 1.** Хөдөө аж ахуйн нислэг үйлдэгдэх аэродромын газрын тэмдэглэгээ

### 91.225. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй аэродромд нислэг үйлдэх

(a) Нислэгийн хөдөлгөөний хяналтын үйлчилгээтэй аэродромд болон түүний ойролцоо нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга:

- (1) НХУ-аас зөвшөөрөл олгоогүй бол, НХУ-тай тогтоосон давтамж дээр хоёр талын радио холбоо барина;
- (2) нислэгийн дор дурьдсан үе шатууд эхлэхээс өмнө уг хяналтын үйлчилгээнээс зөвшөөрөл авна:
  - (i) маневрлах талбайн аль нэг хэсэгт явгалах; эсхүл
  - (ii) тухайн аэродромын зурвас, нисдэг тэрэгний тайлбагаас хөөрөх, буух; эсхүл
  - (iii) удирдлагын бүсэд орох.

(b) Нислэгийн мэдээллийн үйлчилгээтэй аэродромд болон түүний ойролцоо нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга:

- (1) тухайн агаарын хөлөг радио холбоогоор тоноглогдсон бол мэдээллийн үйлчилгээний албатай тогтоосон давтамж дээр хоёр талын радио холбоо барина;
- (2) нислэгийн дор дурьдсан үе шатууд эхлэхээс өмнө, уг мэдээллийн үйлчилгээнд төлөвлөж буй үйлдлийнхээ талаар мэдэгдэнэ:
  - (i) маневрын талбайн аль нэг хэсэгт явгалах; эсхүл
  - (ii) тухайн аэродромын зурвас, нисдэг тэрэгний тайлбагаас хөөрөх, буух; эсхүл

(iii) тухайн аэродромын хайрцаг нислэгт орох.

(с) Радио холбоогоор тоноглогдоогүй агаарын хөлгөөр нислэгийн мэдээллийн үйлчилгээтэй аэродромд болон түүний ойролцоо нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нислэгийн дараах үе шатууд эхлэхээс өмнө тухайн аэродромын мэдээллийн үйлчилгээнд нислэгийн хөдөлгөөний талаар мэдэгдэнэ:

- (1) маневрлах талбайн аль нэг хэсэгт явгалах;
- (2) тухайн аэродромын хайрцаг нислэгт орох.

#### **91.227. Өөр агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэх**

Дараах тохиолдлуудад нисгэгч агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- (1) өөр агаарын хөлөгт хэт ойр, мөргөлдөх эрсдэл үүсгэж болзошгүй бол; эсхүл
- (2) групп (formation) нислэг үйлдэхээр бол нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга тус бүртэй урьдчилан тохиролцоогүй бол;
- (3) энэ зүйлийн 2)-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд хөлсөөр эсхүл урамшуулалттай зорчигч тээвэрлэх групп (formation) нислэгийн нисгэгч, шүхэр буулгах нислэг эсхүл ИНД-115-ийн дагуу Дарга олгосон гэрчилгээ эзэмшигч, групп (formation) сонирхогчийн нислэгээс бусад бол.

#### **91.229. Нислэгийн хөдөлгөөний давуу эрхийн дүрэм**

(a) Нисгэгч нь:

- (1) бусад агаарын хөлгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зорилгоор, ХНД эсхүл ИХНД-ын дагуу нислэг үйлдэж байгаагаас үл хамааран, цаг агаарын байдал боломжтой байвал ил харааны ажиглалт хийнэ;
- (2) давуу эрхтэй гээд хурд, чиглэлээ барих хэдий ч агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх системээс (ACAS) өгч буй анхааруулга, шийдвэрийг үндэслэн мөргөлдөхөөс зайлсхийх маневр (resolution advisory) үйлдэх үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөхгүй;
- (3) өөр агаарын хөлөг өнгөрөн гарах үед дагалдах хуйлралын нөлөөг харгалзан уг агаарын хөлгийн эгц урдаас, эсхүл түүний дээгүүр, эсхүл доогуур гарахаас зайлсхийж, зам тавьж өгнө.

(b) Өөр агаарын хөлөг эгц урдаас уулзах чиглэлээр ойртож буй үед нисгэгч чиглэлийг баруун гар тийш өөрчилнө.

(с) Өөр агаарын хөлөгтэй ижил өндөрт, нэг цэгт огтлолцох чиглэлээр нисэж буй агаарын хөлгийн нисгэгч баруун гар талдаа байгаа агаарын хөлөгт зам тавьж өгнө. Энэ заалт нь дараах нөхцөлүүдэд хамаарахгүй:

- (1) дирижабль, планер болон агаарын бөмбөлөг нь агаараас хүнд, хөдөлгүүрт агаарын хөлгөөс давуу эрхтэй;

- (2) планер, агаарын бөмбөлөг нь дирижаблиас давуу эрхтэй;
- (3) агаарын бөмбөлөг нь планераас давуу эрхтэй;
- (4) планер чирч яваа агаарын хөлөг нь хөдөлгүүрт агаарын хөлгөөс давуу эрхтэй;
- (5) шүхрээр бууж буй этгээд бүх төрлийн агаарын хөлгөөс давуу эрхтэй.

(d) Гүйцэж түрүүлж буй агаарын хөлөг нь өмнөө байгаа агаарын хөлгөөс зайлсхийх эргэлт хийх шаардлагатай тохиолдолд чиглэлийг баруун гар тийш өөрчилж, гүйцэж буй агаарын хөлгөөс бүрэн өнгөрч, саад болохооргүй гүйцэж түрүүлнэ.

(e) Энэ зүйлийн (г)-д хамрааралтайгаар, гүйцэж түрүүлж буй агаарын хөлөг гэж өмнөө байгаа агаарын хөлгийн ар талаас 70 градусаас бага өнцгөөр тэгш хэмт шугам үүсгэн ойртож байгаа агаарын хөлгийг хэлнэ.

(f) Агаарт эсхүл газарт байрлаж буй агаарын хөлгийн нисгэгч нь:

- (1) буултын эцсийн үе шатанд буюу буулт үйлдэж буй агаарын хөлөгт зам тавьж өгнө;
- (2) буулт хийхээр ойртолт үйлдэж буй хоёр буюу түүнээс дээш агаарын хөлгүүд нь нам өндөрт буй агаарын хөлөгт зам тавьж өгнө;
- (3) буултын эцсийн үе шатанд яваа агаарын хөлгийн урдуур өнгөрөх, эсхүл уг агаарын хөлгийг гүйцэж түрүүлэхэд энэ хэсгийн (2)-т заасан давуу эрхийг эдлэхгүй.

(g) Бусад агаарын хөлөгтэй мөргөлдөх илэрхий аюул байвал хөөрөлт үйлдэхийг хориглоно.

(h) Аэродромын маневарлах талбайд явгалж буй агаарын хөлгийн нисгэгч нь:

- (1) буулт, хөөрөлт үйлдэж буй болон хөөрөлт үйлдэх гэж буй агаарын хөлөгт зам тавьж өгнө;
- (2) өөр агаарын хөлөгтэй эгц урдаас, эсвэл хэт ойртож байгаа тохиолдолд зогсох, эсхүл аюулгүй зайд холдох хүртэл чиглэлийг баруун гар тийш өөрчилнө;
- (3) хоёр агаарын хөлгийн явгалах зам огтлолцож байвал, баруун гар талдаа байгаа агаарын хөлөгт зам тавьж өгнө;
- (4) гүйцэн түрүүлж буй агаарын хөлөг гүйцэж буй агаарын хөлгөөс аюулгүй зайг хангаж гүйцэж түрүүлнэ.

(i) Бүх агаарын хөлгийн нисгэгч нь аюулд учирсан агаарын хөлөгт зам тавьж өгнө.

### **91.231. Усан дээрх давуу эрхийн дүрэм**

Усан дээрх агаарын хөлгийн дарга Тэнгист мөргөлдөхөөс зайлсхийх олон улсын дүрмэнд (International Regulations for Preventing Collisions at Sea) тавигдсан шаардлагыг биелүүлнэ.

### **91.233. Агаарын хөлгийн гэрэл**

(a) Агаарын хөлгийн нисгэгч нь:

- (1) агаарын хөлгийн байрлалын (position) гэрлийг асаалгүйгээр шөнийн цагт нислэг үйлдэхгүй; эсхүл
- (2) тэнгист мөргөлдөхөөс зайлсхийх олон улсын дүрмэнд (International Regulations for Preventing Collisions at Sea) заасан гэрэлтүүлэх шаардлагыг мөрдөхгүйгээр усан дээр шөнө хөвөн явахгүй; эсхүл
- (3) энэ дүрмийн “E” Бүлэгт шаардсаны дагуу тухайн агаарын хөлөгт суурилуулсан мөргөлдөхөөс сэргийлэх гэрлийн систем нь ажиллагаагүй бол шөнийн цагаар нислэг үйлдэхгүй.

(b) Аливаа этгээд дараах тохиолдолд, аэродромын маневарлах талбайд шөнийн цагаар агаарын хөлгийг байрлуулах эсхүл шилжүүлэн байршуулахгүй:

- (1) агаарын хөлгийн гэрэл харагдахуйц тод биш; эсхүл
- (2) агаарын хөлгийн байрлалын (position) гэрэл асаагүй; эсхүл
- (3) агаарын хөлөг нь саадын гэрлэн тэмдэглэгээгүй талбайд байвал.

### **91.235. Агаарын хөлгөөс эд зүйл унагах**

Хүн эсхүл бусдын эд хөрөнгөнд гэмтэл, аюул учруулахгүй гэдгийг бататгаагүй бол нислэгийн үед агаарын хөлгөөс аливаа эд зүйлс унагахыг хориглоно.

### **91.237. Агаарын хөлгийн хурдны хязгаарлалт**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд дараах агаарын зайд агаарын хөлгөөр далайн дундаж төвшнээс дээш 3000 м (10000 ft) ба түүнээс доош өндөрт 460 км/ц (250 kts)-аас их хэрэглэлийн хурдтайгаар нисэхийг хориглоно:

- (1) D, E, F, эсхүл G ангиллын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж байвал; эсхүл
- (2) C, D, E, F эсхүл G ангиллын агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж байвал.

(b) Дараах тохиолдолд энэ зүйлийн (a)-д заасан заалт хамаарахгүй:



- (1) нислэгийн ашиглалтын зааварт агаарын хөлгийн аюулгүй хамгийн бага хурд нь 460 км/ц (250 kts)-аас их бөгөөд тухайн агаарын хөлөг аюулгүй хамгийн бага хурдаар нислэг үйлдэж буй бол; эсхүл
- (2) 91.703-т заасны дагуу тухайн агаарын хөлөг үзүүлэх нислэгт оролцож байвал.

### **91.239. Өндөр хэмжигчийг тохируулах**

(a) Нисгэгч өндөр хэмжигчийг агаарын хөлгийн нислэгийн үнэмлэхүй өндөр эсхүл нислэгийн өндрийн цувааг дараах байдлаар тогтоон зохицуулна:

- (1) тухайн аэродромд тогтоосон шилжих өндөр буюу түүнээс дээш нислэгийн өндөрт нисэх үед өндөр хэмжигчийг стандарт даралт 1013.25 гПа (760 мм.муб)-д шилжүүлнэ;
- (2) тухайн аэродромд тогтоосон шилжих өндрийн цуваа буюу түүнээс доош өндөрт нисэх үед тухайн аэродромын QNH эсхүл QFE даралтад шилжүүлнэ;
- (3) шилжих өндөр ба шилжих өндрийн цувааны хооронд нислэг үйлдэх үед НХУ-аас зөвшөөрсөн өндрийг хадгална.

(b) Өндөр авч буй эсхүл өндөр алдаж буй нисгэгч дараах байдлаар өндөр хэмжигчийг тохируулна:

- (1) шилжих өндрөөс дээш өндөр авч буй бол стандарт даралт 1013.25 гПа (760 мм.муб)-д шилжүүлнэ;
- (2) шилжих цуваанаас доош өндөр алдаж буй бол тухайн аэродромын QNH эсхүл QFE даралтад шилжүүлнэ.

### **91.241. НХУ-аас өгсөн зөвшөөрөл, зааврыг биелүүлэх**

(a) ИНД-71 дагуу тогтоогдсон хяналттай агаарын зайд агаарын хөлгөөр нисэж буй нисгэгч нь:

- (1) ACAS, GPWS, эсхүл TAWS-аас өгөгдсөн зааврын дагуу маневр (resolution advisory) хийгдсэнээс бусад тохиолдолд НХУ-аас өгсөн зөвшөөрөл, зааврыг биелүүлнэ;
- (2) агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс НХУ-аас өгсөн зөвшөөрөл, заавраасзөрөх бол энэ тухай НХУ-д аль болох хурдан хугацаанд мэдэгдэнэ.

(b) НХУ-ын зөвшөөрөл, заавар нь энэ дүрмийн заалтуудыг зөрчихөөр байвал нисгэгч тэдгээр зөвшөөрөл, зааврыг дагаж мөрдөх шаардлагагүй.

(с) Нисгэгч энэ зүйлийн (b)-д заасан НХУ-аас өгсөн заавар зөвшөөрлийг дагаж мөрдөөгүй бол энэ тухай НХУ-д нэн даруй мэдэгдэнэ.

### 91.243. НХУ-аас өгөх гэрлэн дохио

Хүснэгт 1-д заасан НХУ-аас өгсөн гэрлэн дохионы зөвшөөрөл, зааврыг нисгэгч бүр биелүүлнэ.

#### Хүснэгт 1. НХУ-аас өгөх гэрлэн дохионууд

Гэрлэн дохио	Агаарт байгаа онгоцонд	Газарт байгаа
Үргэлжилсэн ногоон	Буухыг зөвшөөрнө	Хөөрөхийг зөвшөөрнө
Үргэлжилсэн улаан гэрэл	Бусад агаарын хөлөгт зам тавьж өгөөд, тойрог нислэгийг үргэлжлүүл	Зогс
Анивчсан ногоон гэрэл	Буухаар буцаж эргэ (буух зөвшөөрлийг тухайн үед нь өгнө)	Явгалахыг зөвшөөрнө.
Анивчсан улаан гэрэл	Аэродром аюултай, бууж болохгүй	Ашиглаж буй буултын талбайгаас зайтай явгалалт үйлд
Анивчсан цагаан гэрэл	Энэ аэродром дээр буугаад, зогсоол руу оч	Аэродром дээрх гарааны цэг рүү буц
Улаан, ногоон гэрэл ээлжлэн анивчих	Анхаар, аюултай	Анхаар, аюултай.

### 91.245. Хяналттай агаарын зайд нислэг үйлдэх

(а) Энэ зүйлийн (е) болон (е)-д зааснаас бусад тохиолдолд, ИНД-71-ийн дагуу тогтоосон хяналттай агаарын зайд нэвтэрхийн өмнө агаарын хөлгийн дарга НХУ-аас зөвшөөрөл авна.

(b) А ангиллын агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга:

- (1) ХНД-ийн дагуу нислэг үйлдэнэ;
- (2) НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, тогтоосон давтамж дээр НХУ-тай хоёр талын радио холбоо барина;

(с) Дор заасан агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга тогтоосон давтамж дээр НХУ-тай хоёр талын радио холбоо барина:

- (1) В, С болон D ангиллын агаарын зайд;
- (2) ХНД-ээр Е ангиллын агаарын зайд.

(d) Өөр өөр ангиллын агаарын зай хэвтээ хилээр нийлж байвал (дээр дээрээсээ), нийлж буй өндөрт нисэж буй нисгэгч бага хязгаарлалттай ангилал бүхий агаарын зайн шаардлагыг дагаж мөрдөж болно.

(e) ИНД-71-т заасны дагуу E ангиллын хяналттай агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж буй нисгэгч НХУ-аас зөвшөөрөл авах шаардлагагүй.

(f) Хяналттай агаарын зайд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлээгүй тухайн цагуудад дээрх агаарын зай нь G ангиллын хяналтгүй агаарын зай болно.

#### **91.246. RNP агаарын зай дахь үйл ажиллагаа**

(a) Дараах шаардлагыг хангаагүй этгээд Монгол улсын бүртгэлтэй агаарын хөлгөөр RNP агаарын зайд нислэг үйлдэхгүй:

- (1) агаарын хөлөгт энэ дүрмийн дагуу батлагдсан тухайн агаарын хөлөг болон навигацийн системд тохирсон RNP нислэгийн журам, заавар (бүх нэмэлт өөрчлөлтүүдийг багтаасан) байлгах;
- (2) RNP агаарын зайд батлагдсан зааварт заасан журам, зааварчилга, хязгаарлалтын хүрээнд нислэг гүйцэтгэх;
- (3) RNP нислэгт ашиглах 91.519-д заасны дагуу шаардсан хэрэглэл болон тоног төхөөрөмжид батлагдсан хөтөлбөрийн дагуу техник үйлчилгээ хийж, үзлэг шалгалт хийгдсэн байх;
- (4) нисэх багийн гишүүн бүр дор заасан зүйлстэй танилцаж, тэдгээрийн талаар зохих мэдлэгтэй байх:
  - (i) тухайн агаарын хөлөг;
  - (ii) агаарын хөлгийн навигацийн систем;
  - (iii) урьдчилан төлөвлөгдөөгүй журмуудыг багтаасан нислэгт хэрэглэгдэх журам, горимууд;
- (5) төлөвлөсөн маршрут болон бусад нөөц маршрутаар нисэх RNP үзүүлэлтийг хангаж буйг болон RNP нислэгт ашиглагдах агаарын хөлөг болон түүний навигацийн системийг Дарга баталсан гэдгийг агаарын хөлгийн дарга баталгаажуулах;
- (6) ИКАО-ийн стандарт нислэгийн төлөвлөгөөний 10-р зүйлд дараах тэмдэглэгээг хийж зохих НХУ-ний байгууллагад хүргүүлсэн байх:
  - (i) RNP нислэгт зөвшөөрөгдсөн агаарын хөлөгт “R” тэмдэглэгээ;
  - (ii) зөвшөөрөгдсөн GNSS-ээр тоноглогдсон агаарын хөлөгт “G” тэмдэглэгээ.

(b) Ашиглагч хүчин төгөлдөр RNP нислэгийн журам заавар (түүний үндсэн ажиллагааг багтаасан) Дарга үзлэг, шалгалт хийхэд бэлэн байхаар агаарын хөлөгт байлгана.

(c) RNP нислэгийн мөрдөх зааврыг батлуулах эсхүл батлагдсан зааварт нэмэлт өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргаж буй этгээд уг заавар, эсхүл өөрчлөлтийн төслийг Даргад хүргүүлнэ.

(d) RNP нислэгт мөрдөх заавар эсхүл түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг Дарга батална.

(e) RNP нислэгт мөрдөх зааварт дараах зүйлс багтсан байна:

- (1) эзэмшигчийн нэр;
- (2) тухайн агаарын хөлгийн бүртгэл, хийц (make), загвар;
- (3) тухайн агаарын хөлгийн навигацийн системийн загвар, үйлдвэрлэгч, маяг;
- (4) дараах журмуудыг багтаасан техник үйлчилгээний хөтөлбөр:
  - (i) 91.519-д шаардсан RNP нислэгт тодорхой хугацаанд хийгддэг тоног төхөөрөмж болон хэрэглэлийн үзлэг, шалгалт хийгдэж буйг бататгасан;
  - (ii) техник үйлчилгээний бүртгэлд нисэн гарах, нисэн очих аэродром, огноо болон хэрэв тухайн RNP үйл ажиллагаа хэрэглэл эсхүл тоног төхөөрөмжийн дутагдлаас шалтгаалж үргэлжлүүлэх боломжгүй болсон бол шалтгаануудыг бүртгэж буйг;
- (5) дараах зүйлсэд хамаарах журам болон зааврууд:
  - (i) тоног төхөөрөмжийн дутагдал эсхүл ашиглалтын улмаас гарч болзошгүй навигацийн их хэмжээний алдааг багасгах аргачлал;
  - (ii) НХУ-ын зөвшөөрсөн маршрутаас санамсаргүй хазайхаас сэргийлэх үүднээс навигацийн алдаа гарсан эсэхийг тогтоох зорилгоор харьцуулан шалгах журмыг багтаасан нислэгийн үед мөрдөх журам;
  - (iii) RNP агаарын зайд шаардагдах RNP үзүүлэлтүүд хадгалагдаж буйг баталгаажуулсан навигацийн системийн шинэчлэл (update);
  - (iv) RNP агаарын зайн RNP системийн боломжит хамгийн их хазайлт;
  - (v) RNP шаардлагад нийцэх цагийн хязгаарлалтын тооцоолол;
  - (vi) хэрэглэл болон тоног төхөөрөмжийн гэмтлийг анхааруулах систем;
  - (vii) системийн гэмтэл, саатал;
  - (viii) найдвартай ажиллагааны болон өгөгдлийн үзүүлэлтүүдийг цуглуулах, хянах систем;
  - (ix) ИНЕГ-ын даргын шаардлагатай гэж үзсэн бусад журам, зааварчилгаа болон хязгаарлалтууд байж болно.

(f) Энэ зүйлийн (a), (b), (c) болон (e)-д шаардсан журмын заавар ИНД-119-ийн дагуу олгогдсон агаарын тээврийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт багтсан байж болно.

(g) Агаарын хөлгийн дарга нь:

- (1) НХУ-өөр зөвшөөрөл олгоогүй бол, хоёр хамааралгүй алсын зайн навигацийн системийн (LRNS) дараах нислэгийн үеүүдэд өндөр нарийвчлалтай ажиллаж буйг баталгаажуулна:
  - (i) тогтоосон RNP агаарын зайд орохоос 30 минутын өмнө;
  - (ii) тогтоосон RNP агаарын зайд орохын үед;
- (2) тогтоосон RNP агаарын зайд орохоос 30 минутын өмнө эсхүл уг агаарын зайд нислэг үйлдэж буй үед:
  - (i) RNP шалгуурыг хангаж чадахгүй болсон тохиолдолд шууд НХУ-д мэдэгдэх;
  - (ii) нэг алсын зайн навигацийн системтэй (LRNS) нислэг үйлдэж буй үед НХУ-д мэдэгдэх;
  - (iii) хэрэв НХУ-тай холбоо барих боломжгүй бол Бүс нутагт мөрдөх нэмэгдэл журмын (ICAO Regional Supplementary Procedures, Document 7030) дагуу ажиллана.

#### **91.247. Автомат хариулагч, өндрийг мэдээлэх төхөөрөмж ашиглах**

(a) Энэ зүйлийн (e)-д зааснаас бусад тохиолдолд, ИНД-71-т заасны дагуу автомат хариулагч зайлшгүй шаардлагатай агаарын зайд нисэж буй агаарын хөлгийн дарга, НХУ-аас өөр заавар, зөвшөөрөл олгогдоогүй бол:

- (1) автомат хариулагч нь:
  - (i) С эсхүл А горимд ажиллах; эсхүл
  - (ii) агаарын хөлөг нь S горимд ажиллах автомат хариулагчаар тоноглогдсон бол энэ зүйлийн (b)-д заасан заалтыг баримтална;
- (2) S горимд ажиллах төхөөрөмж энэ хэсгийн (3)-т зааснаас бусад тохиолдолд SSR код тохируулагч нь:
  - (i) тухайн нислэгт НХУ-аас өгсөн зохих кодыг тохируулсан; эсхүл
  - (ii) НХУ-аас код өгөгдөөгүй бол Хүснэгт 2-т заасны дагуу тохируулсан;
- (3) онцгой болон ноцтой байдал бий болсон нөхцөлд код тохируулагчийг Хүснэгт 3-т заасны дагуу тохируулна.

(b) Бүртгэсэн улсаас тухайн агаарын хөлөгт оноож S горимд ажиллах автомат хариулагчийн онцгой хаягийн код олгоогүй бол S горимд ажиллах автомат хариулагчаар тоноглогдсон агаарын хөлгөөр аливаа этгээд нислэг үйлдэхгүй.

(c) Автомат хариулагч шаардсан хяналттай агаарын зайд автомат хариулагчгүй нислэг үйлдэхээр төлөвлөсөн агаарын хөлгийн дарга тухайн НХУ-аас тусгай зөвшөөрөл авна.

(d) Автомат хариулагч шаардсан хяналттай агаарын зайд нислэг үйлдэх үед уг төхөөрөмжийн ажиллагаа доголдох эсхүл татгалзсан тохиолдолд агаарын хөлгийн дарга тухайн НХУ-д яаралтай мэдэгдэнэ.

(e) НХУ өөрөөр шаардаагүй бол, энэ зүйлийн (a)-д заасны дагуу групп нислэгт зөвхөн нэг агаарын хөлөг автомат хариулагч ашиглана.

## Хүснэгт 2. Хяналттай агаарын зайд автомат хариулагчид ашиглах кодууд

Нислэг үйлдэх дүрэм	Агаарын хөлгийн төрөл	Код
ИХНД	Гал түймэртэй тэмцэх болон хайгуул, судалгааны (reconnaissance) үүрэг гүйцэтэж буй агаарын хөлөг	0111
ХНД	Бүх	2000
ИХНД	Хяналттай агаарын зайд хайрцаг нислэг үйлдэж буй - Бүх	2200
ИХНД	Улсын агаарын хөлгөөс бусад - Бүх	1200
ИХНД	Планер эсхүл бөмбөлөг	1300
ИХНД	ЕЗН-ийн районд нислэг үйлдэж буй хөдөлгүүрт агаарын хөлөг	1400
ИХНД	Улсын нисдэг тэргээс бусад нисдэг тэрэг	1500
ИХНД	Улсын онгоц	6000
ИХНД	Улсын нисдэг тэрэг	6500

## Хүснэгт 3. Онцгой нөхцөл байдлын үед автомат хариулагчид ашиглах кодууд

Ашиглах нөхцөл	Код
Хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед	7500
Радио холбоо алдагдах үед	7600

Ослын болон яаралтай үед	7700
--------------------------	------

### 91.249. Агаарын хөлгийн дуудлага

(a) Хэрэв ИНБД-ийн дагуу холбоо барих шаардлагатай бол Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга дор дурдсан радио холбооны таних дуудлагыг хэрэглэнэ:

- (1) ИНЕГ-ын даргын олгосон тухайн Ашиглагчийн радио холбооны таних дуудлагын дараа нислэгийн дугаар буюу таних тэмдэг; эсхүл
- (2) ИНЕГ-ын даргын олгосон тухайн Ашиглагчийн радио холбооны таних дуудлагын дараа агаарын хөлгийн бүртгэлийн тэмдгийн сүүлийн 3 тоо, үсэг; эсхүл
- (3) агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн нэр, эсхүл агаарын хөлгийн загварын дараа агаарын хөлгийн бүртгэлийн тэмдгийн сүүлийн 3 тоо, үсэг.

(b) Энэ зүйлийн (a)-ийн (2)-ыг үл харгалзан, зохих НХҮ-ний албатай хоёр талын холбоо барьсны дараа, агаарын хөлгийн дарга тухайн агаарын хөлгийн бүртгэлийн тэмдгийн сүүлийн 3 тооноос бүрдсэн товчилсон дуудлагыг хэрэглэж болно.

(c) Энэ зүйлийн (a)-ийн (1) болон (2)-д заасан таних дуудлагыг Дарга дараах үйл ажиллагаанд хэрэглэх этгээдэд олгож болно:

- (1) ИНД-119 эсхүл ИНД-129-ийн дагуу олгогдсон гэрчилгээ эзэмшигч:
  - (i) агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа; эсхүл
  - (ii) эрэн хайх, авран туслах нислэг; эсхүл
  - (iii) эмнэлгийн тусламжийн нислэг;

(2) хууль хэрэгжүүлэгч байгууллагын зөвшөөрөлтэй уг байгууллагын нислэг.

(d) Таних дуудлагын нэр авах этгээд Даргад бичгээр өргөдөл гаргахаас гадна холбогдох төлбөрийн баримтаа авчирна.

### 91.251 Автомат бичлэг хийх төхөөрөмжийн ажиллагаа

Аливаа этгээд агаарын хөлөгт 91.509-ийн (b)-д заасны дагуу тоногдсон автомат бичлэг хийх төхөөрөмжийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

**Г Бүлэг. Ил харааны нислэгийн дүрэм****91.301. Ил харааны нислэгийн цаг агаарын хязгаарлалт**

(а) Энэ зүйлийн (b), (c) болон 91.303-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлгийн дарга дор дурдсан нөхцөлд ил харааны нислэгийн дүрмээр (цаашид ИХНД гэх) нислэг үйлдэхгүй:

- (1) алсын барааны харагдац Хүснэгт 4-т заасан агаарын зайн зохих ангилалд заасан хэмжээнээс бага бол; эсхүл
- (2) агаарын хөлгөөс үүл хүртэлх зай Хүснэгт 4-т заасан агаарын зайн зохих ангилалд заасан хэмжээнээс бага бол.

(b) 91.303-д зааснаас бусад тохиолдолд, алсын барааны харагдац, үүлний доод суурийн өндөр дараах хязгаарлалтаас бага бол агаарын хөлгийн дарга ИХНД-ээр хөөрөх, буух эсхүл аэродромын ойролцоо нислэг үйлдэхгүй:

- (1) удирдлагатай бүсийн аэродромд, Хүснэгт 5-д заасны дагуу;
- (2) удирдлагагүй бүсийн аэродромд, Хүснэгт 6-д заасны дагуу.

(c) Агаарын хөлгийн дарга нь дор дурдсан тохиолдолд нислэг үйлдэж болно:

- (1) нисдэг тэрэгний дарга аливаа саад болон бусад хөдөлгөөнтэй мөргөлдөхөөс зайлсхийх зорилгоор тэдгээрийг ажиглаж илрүүлэх бололцоотой хурдтайгаар маневр хийж буй бол G ангиллын агаарын зайд, алсын барааны харагдац 5 км-ээс бага үед;
- (2) хөдөө аж ахуйн зориулалттай нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга G ангиллын агаарын зайд, алсын барааны харагдац 5 км-ээс бага боловч 1500 м-ээс их үед;
- (3) ИНД-71-ийн дагуу нам өндрийн нислэгийн бүсэд нислэгийн сургалт, дадлага өгч буй тохиолдолд алсын барааны харагдац 5 км-ээс бага боловч 1500-м их үед.

**Хүснэгт 4. ИХНД-ийн цаг агаарын хязгаарлалт**

Агаарын зайн ангилал	Үүл хүртэлх зай	Алсын барааны
В	Үүлнээс гадуур	Далайн дундаж төвшнээс дээш
С, D болон E	Хэвтээ чиглэлд 2 км, босоо чиглэлд удирдлагагүй бүсэд 300 м	3000 м буюу түүнээс дээш



F болон N G	Далайн төвшнээс дээш 1000 м (3000 ft) эсхүл газрын гадаргуугаас дээш 300 м (1000ft)-ийн аль ихээр нь	Хэвтээ чиглэлд 2 км, босоо чиглэлд 300м (1000 ft)	өндөрт 8 км; Далайн дундаж төвшнөөс дээш 3000м-ээс
	Далайн төвшнээс доош 1000 м (3000 ft) эсхүл газрын гадаргуугаас дээш 300 м (1000ft)-ийн аль ихээр нь	Үүлнээс гадуур бол газрын гадаргуу харагдахуйц	5 км

**Хүснэгт 5. Удирдлагатай бүсийн аэродромын ИХНД-ийн цаг агаарын хязгаарлалт**

		Үүлний суурь	Алсын барааны харагдац
Бүх агаарын хөлөг	Өдөр болон шөнө	500 м (1500 ft)	5 км

**Хүснэгт 6. Удирдлагагүй бүсийн аэродромын ИХНД-ийн цаг агаарын хязгаарлалт**

		Үүлний суурь	Алсын барааны харагдац
Бүх агаарын хөлөг	Өдөр	200 м (600 ft)	1500 м
Бүх агаарын хөлөг	Шөнө	500 м (1500 ft)	8 км

**91.303. Тусгай ил харааны нислэгийн цаг агаарын хязгаарлалт**

91.301-д заасан цаг агаарын нөхцөлөөс доош тусгай ИХНД-ээр доорх нөхцлийг хангаж буй бол агаарын хөлгийн дарга нислэг үйлдэж болно.

- (1) үүлний суурь нь 200м (600 ft)-ээс доошгүй, алсын барааны харагдац 1500 м доошгүй; эсхүл нисдэг тэрэгний хувьд: саад болон бусад хөдөлгөөнтэй мөргөлдөхөөс зайлсхийх зорилгоор тэдгээрийг ажиглаж илрүүлэх бололцоотой хурдтайгаар нислэг үйлдэж буй бол үүлний суурь нь 200м (600 ft)-ээс доош, алсын барааны харагдац 1500 м доош;
- (2) тухайн агаарын хөлөг тогтоосон давтамж дээр НХУ-тай хоёр талын радио холбоотой байх;
- (3) зөвхөн өдрийн цагт, үүлнээс гадуур, НХУ-ын заавар, зөвшөөрлийг дагаж буй нөхцөлд.

**91.305. Ил харааны нислэгт шаардлагатай шатахуун**

(a) Цаг агаарын урьдчилсан мэдээллээр нислэг явагдах өндрийн салхийг тооцож төлөвлөсөн нислэгийн хурдтайгаар эхний буудалд нисэн очсоноос хойш дор дурдснаас багагүй хугацаанд нисэхэд хангалттай шатахуунгүй бол уг онгоцны дарга ИХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- (1) өдрийн цагт 30 минут; эсхүл
- (2) шөнийн цагт 45 минут; эсхүл
- (3) *тусгай ангилал – хязгаарлагдмал (limited)* НТЧ-ын гэрчилгээтэй эсхүл *тусгай ангилал – үзүүлэх (exhibition)* НТЧ-ын гэрчилгээтэй онгоцны хувьд, ИНД-47.55-ийн (c)-д заасны дагуу ашиглагчид тавигдсан нислэгийн цагт тохирох ИХНД-ийн хамгийн бага нөөц түлш.

(b) Цаг агаарын урьдчилсан мэдээллээр нислэг явагдах өндрийн салхийг тооцож төлөвлөсөн нислэгийн хурдтайгаар эхний буудалд нисэн очсоноос хойш дор дурдснаас багагүй хугацаанд нисэхэд хангалттай шатахуунгүй бол уг нисдэг тэрэгний дарга ИХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- (1) эхний цэгт нисэн очсоноос хойш 20 минутаас доошгүй хугацаанд нисэхэд хүрэлцэх шатахуунтай бол; эсхүл
- (2) нислэгийн үргэлжлэх хугацаа 20 минутаас бага бол нисэн очих эхний цэгээс хойш төлөвлөсөн нислэгийн цагтай тэнцэх хугацаанд нисэхэд хүрэлцэхүйц шатахуунтай бол; эсхүл
- (3) *тусгай ангилал – хязгаарлагдмал (limited)* НТЧ-ын гэрчилгээтэй эсхүл *тусгай ангилал – үзүүлэх (exhibition)* НТЧ-ын гэрчилгээтэй нисдэг тэрэгний хувьд, ИНД-47.55-ийн (c)-д заасны дагуу Ашиглагчид тавигдсан нислэгийн цагт тохирох ИХНД-ийн хамгийн бага нөөц түлш.

**91.307. Ил харааны нислэгийн төлөвлөгөө**

(a) ИХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга холбогдох НХҮ-ний байгууллагад мэдээллийн үйлчилгээ авах бол ил харааны нислэгийн төлөвлөгөө бөглөж өгнө.

(b) Энэ зүйлийн (a)-д зааснаас гадна, ИХНД-ээр үйлдэх бусад нислэгийн агаарын хөлгийн дарга холбогдох НХҮ-ний байгууллагад ил харааны нислэгийн төлөвлөгөө бөглөж өгч болно. (May submit)

(c) Энэ зүйлийн (a), (b)-д заасан ИХНД-ийн нислэгийн төлөвлөгөө нь дараах мэдээллийг агуулсан байна:

- (1) агаарын хөлгийн бүртгэлийн дугаар болон таних дуудлага:
- (2) агаарын хөлгийн маяг:

- (3) хөөрөх, буух аэродром болон маршрут, хэрэв завсрын буудалд буух бол тэдгээр аэродром, буугаад байх хугацаа болон нислэг бүрийн маршрут, нислэгийн цаг:
  - (4) авран хайх үйл ажиллагааг эхлүүлэх цаг (SARTIME):
  - (5) түлш зарцуулагдан дуусах хугацаа (fuel endurance):
  - (6) агаарын хөлөгт дахь нийт хүний тоо:
  - (7) агаарын хөлгийн даргын нэр утасны дугаар, холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл:
  - (8) агаарын хөлгийн эзэмшигч эсхүл Ашиглагчийн нэр:
  - (9) аврах хамгаалах үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах нэмэлт бусад мэдээлэл.
- (d) Энэ зүйлийн (a), (b)-ийн дагуу НХҮ-ний байгууллагад ИХНД-ийн нислэгийн төлөвлөгөө өгсөн тохиолдолд агаарын хөлгийн дарга:
- (1) хэрэв авран хайх үйл ажиллагааг эхлүүлэх цагт (SARTIME) өөрчлөлт орсон бол авран хайх үйл ажиллагааг эхлүүлэх цаг (SARTIME) эхлэхээс өмнө холбогдох НХҮ-ний байгууллагад мэдэгдэх;
  - (2) авран хайх үйл ажиллагааг эхлүүлэх цаг (SARTIME) эхлэхээс өмнө холбогдох НХҮ-ний байгууллагад нислэгийн төлөвлөгөө хааж буйг мэдэгдэнэ.

### **91.309. Байрлал илтгэх**

Ил хараагаар нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга удирдлагатай агаарын зайд нислэг үйлдэхэд НХУ-аас шаардсан, зайлшгүй илтгэх шаардлагатай тогтоосон цэгүүдийг нисэн өнгөрөхөд НХУ-д мэдээлнэ.

### **91.311. Ил харааны нислэгийн аюулгүй харьцангуй өндөр**

(a) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд, ИХНД-ээр нислэгийг үйлдэхгүй:

- (1) хүн ам шигүү суурьшсан хот, суурин дээгүүр, эсхүл хүмүүс олноор цугларсан бүс нутаг дээрхи агаарын зайд, тухайн агаарын хөлгөөс 600 метрийн хэвтээ радиус доторх хамгийн өндөр саадаас дээш 300 м-ээс (1000 ft) нам өндөрт; эсхүл
- (2) бусад аль нэг бүс нутгийн дээгүүр:
  - (i) газрын гадаргуугаас дээш 150 м-ээс (500 ft) нам өндөрт; эсхүл
  - (ii) ямарваа саад, машин механизм, барилга байгууламж, хүмүүсээс 150 метрийн хэвтээ радиус доторх 150 м-ээс (500 ft) нам өндөрт;

- (3) хөдөлгүүрт эвдрэл, гэмтэл гарсан үед газар дээр байгаа хүмүүс болон эд зүйлд аюул учруулахгүй буулт үйлдэхэд шаардагдах өндрөөс нам өндөрт.
- (b) Энэ зүйлийн (a)-д заасан өндөр дор дурдсан агаарын хөлгийн даргад хамаарахгүй:
- (1) хөөрөлт, буулт үйлдэж буй агаарын хөлөг; эсхүл
  - (2) хоёрдугаар тойрогт гарч буй, эсхүл ойртолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон; эсхүл
  - (3) явгалж буй.
- (c) Энэ зүйлийн (a)-гийн (2)-т заасан заалт дор дурдсан нөхцөлд *зайлшгүй шаардлагаар (bona fide)* нислэг үйлдэж буй агаарын хөлгийн даргад хамаарахгүй:
- (1) газар дээр буй хүмүүс болон эд зүйлд аюул учруулахгүйгээр үйлдэж буй бол;
  - (2) тухайн нам өндрийн нислэгийн үйл ажиллагаанд шууд холбогдох хүмүүсийг тээвэрлэж буй бол;
  - (3) тухайн нислэг үйлдэх өндрөөс доош өндөрт нисээгүй бол;
  - (4) машин механизм, барилга байгууламж, хүмүүсээс 150 м-ийн хэвтээ радиусын гадна байвал тухайн нислэгийн шаардлагаар тогтоосон өндрөөс доош орж болно.
- (d) Энэ зүйлийн (a)-гийн (2)-т заасан заалт дор дурдсан агаарын хөлгийн даргад хамаарахгүй:
- (1) ИНД-61-ийн дагуу багш нисгэгчийн хүчин төгөлдөр зэрэглэл эзэмшигч нь сургалт, дадлагын зорилгоор дор дурдсан нислэг үйлдэж байвал:
    - (i) газрын гадаргуугаас дээш 300 м-ээс (1000 ft) нам өндөрт хөөрөлтийн дараа хөдөлгүүрийн дууриамал гэмтэл, дутагдал өгч буй бол; эсхүл
    - (ii) газрын гадаргуугаас 300 м-ээс (1000 ft) дээш өндөрт хөдөлгүүрийн дууриамал гэмтэл, дутагдал өгч 91.131-д заасны дагуу нам өндрийн нислэгийн бүсэд 150 м-ээс (500 ft) доош өндөр алдалтыг гүйцэтгэж буй бол.
  - (2) ИНД-61-ийн дагуу хүчин төгөлдөр хэрэглэлийн нислэгийн зэрэглэл эзэмшигч нь ил харааны нөхцөлд ХНД-ээр сургалт, шалгалт, дадлагын нислэгийг 91.413, 91.423, 91.425-д заасны дагуу үйлдэж буй бол; эсхүл
  - (3) 91.131-т заасан нам өндрийн нислэгийн бүсэд нислэг үйлдэж буй бол; эсхүл
  - (4) 91.703-т заасан үзүүлэх нислэгт оролцож буй бол.

**91.313. Ил харааны нислэгийн үнэмлэхүй өндөр ба өндрийн цуваачлал**

(a) Монгол улсын агаарын зайд далайн төвшнөөс дээш 1000м (3000ft) эсхүл газрын гадаргуугаас дээш 300м (1000ft) (аль өндрөөр нь) ИХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга НХУ-ний байгууллагаас өөрөөр зөвшөөрөл олгоогүй бол, дор дурьдсан үнэмлэхүй өндөр буюу нислэгийн өндрийн цуваачлалыг баримтална:

- (1) шилжих үнэмлэхүй өндрөөс доош өндөрт:
  - (i) Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, 900 м-ээс эхлэн 600 м-ээр ихсэх шилжих өндөр хүртэл сондгой тоотой зуут бүхий нислэгийн өндөр (900, 1500, 2100 г.м.); эсхүл
  - (ii) Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, 1200 м-ээс эхлэн 600 м-ээр ихсэх шилжих өндөр хүртэл тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (1200, 1800, 2400 г.м ).
- (2) шилжих цуваа болон түүнээс дээш 6000 м хүртэлх өндрийн цуваанд:
  - (i) Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, 600 м-ээр ихсэх 5700м хүртэлх сондгой тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (1500, 2100, 2700 г.м); эсхүл
  - (ii) Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, 600 м-ээр ихсэх 6000м хүртэлх тэгш тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (1800, 2400, 3000 г.м ).

(b) Монгол Улсын агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь НХУ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол, аэродромын шилжих үнэмлэхүй өндөр болон шилжих цувааны хоорондох өндөрт чиг шулуун нислэг үйлдэхгүй.

**91.315. Цас, мөстэй үед тавигдах шаардлага**

Агаарын хөлгийн далавч, стабилизатор, эсхүл удирдлагын гадаргууд цас, мөс, цан тогтсон үед агаарын хөлгийн дарга ИХНД-ээр хөөрөлт үйлдэхийг хориглоно.

**Д Бүлэг. Хэрэглэлийн нислэгийн дүрэм****91.401. Нисэх багийн гишүүдийн тоо**

Агаарын хөлгийн дарга нь дараах тохиолдолд хамтран нисгэгчгүйгээр ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- (1) тухайн агаарын хөлгийн нислэг ашиглалтын зааварт зөвшөөрөөгүй;
- (2) агаарын хөлгийн жолоодлогоос хөндийрэхгүйгээр холбооны тоног төхөөрөмжийг нислэгийн үед ашиглах боломжгүй бол.

**91.403. Хэрэглэлийн нислэгийн үед шаардлагатай шатахуун**

Агаарын хөлгийн дарга ХНД-ээр нисэхэд (цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээлэлийг харгалзан) дор зааснаас бага шатахуунтайгаар агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- (1) нөөц аэродром шаардлагагүй үед:
  - (i) турбинт бус хөдөлгүүрт онгоцны хувьд, буулт үйлдэх аэродром хүртэл нисэн тухайн аэродромоос дээш 300 м-ийн (1500 ft) өндөрт хүлээх хурдтай (holding speed) 45 минут нисэх; эсхүл
  - (ii) турбинт хөдөлгүүрт онгоц болон нисдэг тэрэгний хувьд, буулт үйлдэх аэродром хүртэл нисэн тухайн аэродромоос дээш 300 м-ийн (1500 ft) өндөрт хүлээх хурдтай (holding speed) 30 минут нисэх.
- (2) 91.405-д заасны дагуу нөөц аэродром шаардлагатай бол, буулт үйлдэх аэродромоос нөөц аэродромруу нисэхээс гадна:
  - (i) турбинт бус хөдөлгүүрт онгоцны хувьд, нөөц аэродром хүртэл нисэн тухайн аэродромоос дээш 300 м-ийн (1500 ft) өндөрт хүлээх хурдтай (holding speed) 45 минут нисэх; эсхүл
  - (ii) турбинт хөдөлгүүрт онгоц болон нисдэг тэрэгний хувьд, нөөц аэродром хүртэл нисэн тухайн аэродромоос дээш 300 м-ийн (1500 ft) өндөрт хүлээх хурдтай (holding speed) 30 минут нисэх.

**91.405. ХНД-ээр үйлдэх нислэгийн нөөц аэродромд тавигдах шаардлага**

(a) Дор дурдсан нөхцөлд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нэгээс доошгүй нөөц аэродромыг сонгоно:

- (1) буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродром нь НМЭ-д хэрэглэлээр ойртолт, буулт үйлдэх стандарт журамгүй бол;
- (2) нислэгийн төлөвлөгөө өгөх үед цаг агаарын урьдчилсан мэдээ нь буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд нисэн очихоор тооцоолсон хугацаанаас нэг цагийн өмнө ба хойно дор дурдсан нөхцөлд тохирохгүй бол:
  - (i) нисэн очихоор төлөвлөж буй аэродром дээрх үүлний суурийн өндөр нь НМЭ-д заасан тухайн ойртолт үйлдэхээр төлөвлөсөн хязгаарлалтаас дээш 300 м-ээс (1000 ft) багагүй байх;
  - (ii) алсын барааны харагдац 5 км-ээс багагүй, эсхүл тухайн аэродромын НМЭ-д заасан алсын барааны харагдацын хязгаарлалтаас 2 км-ээр их байх тохиолдлын аль ихийг нь сонгоно.

(b) Нислэгийн төлөвлөгөө өгөх үед цаг агаарын урьдчилсан мэдээгээр энэ зүйлийн (a)-д заасан нөөц аэродром дахь үүлний суурийн өндөр, алсын барааны харагдац

нь уг аэродромд нисэн очих тооцоолсон цагт дор дурдсан цаг агаарын хязгаарлалтад тохирохгүй бол агаарын хөлгийн дарга уг аэродромыг нөөц аэродромоор сонгохгүй:

- (1) тухайн аэродромыг нөөц буудлаар сонгоход НМЭ-д заасан тухайн хэрэглэлийн ойртолт үйлдэхэд ашиглагдах тусгайлан тогтоосон цаг агаарын хязгаарлалтаас дээгүүр; эсхүл
- (2) нарийвчлалтай /ILS/ ойртолт, буултын хувьд үүлний суурийн өндөр 200 м (600 ft), эсхүл шийдвэр гаргах өндрөөс (DA/DH) 60м (200 ft)-ийн аль өндөр нь, алсын барааны харагдац 3000 м, эсхүл хязгаарлалтаас 1000м-ийн аль ихээр нь; эсхүл
- (3) нарийвчлалтай бус ойртолт, буултын хувьд, үүлний суурийн өндөр 250 м /800 ft/, эсхүл шийдвэр гаргах өндрөөс (MDA/MDH) дээш 60 м /200 ft/-ийн аль өндөр нь, алсын барааны харагдац 4000 м, эсхүл тогтоогдсон хязгаарлалтаас 1500 метрээр их байх тохиолдлын аль ихээр нь; эсхүл
- (4) НМЭ-д заасан тухайн нөөц аэродромд хэрэглэлийн нислэгээр ойртолт, буулт үйлдэх журам тогтоогоогүй бол 91.423-д заасан ХНД-ийн аюулгүй нам өндрөөс доош ИХНД-ээр өндөр алдахад энэ дүрмийн Г Бүлэгт заасан үүлний суурийн өндөр, алсын барааны харагдацын хязгаарлалтыг дагаж мөрдөнө.

(с) Энэ зүйлийн (а)-д заасан нөөц аэродром нь дараах төхөөрөмжийг хангах нөөц цахилгаан хангамжаар тоноглогдоогүй бол агаарын хөлгийн дарга тус аэродромыг нөөц аэродромоор сонгохгүй:

- (1) хэрэглэлийн ойртолт үйлдэх газрын навигацийн тоног төхөөрөмжид шаардагдах нөөц тэжээлгүй;
- (2) шөнийн нислэгт аэродромын гэрэлтүүлэггүй бол.

#### **91.407. Хэрэглэлийн нислэгийн төлөвлөгөө**

(а) Агаарын хөлгийн дарга:

- (1) ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга холбогдох НХҮ-ний байгууллагад хэрэглэлийн нислэгийн төлөвлөгөө бөглөж өгнө;
- (2) НХҮ-ний байгууллагаас өөрөөр шаардаагүй бол, нислэг эхлэхээс 30 минутын өмнө нислэгийн төлөвлөгөө бөглөж өгнө;
- (3) НХҮ-ний байгууллагаас өөрөөр шаардаагүй бол, ХНД-ийн нислэгийн төлөвлөгөө нь дараах мэдээллийг агуулсан байна:
  - (i) агаарын хөлгийн таних дуудлага;
  - (ii) тухайн агаарын хөлгийн маяг, түүний хуйлрах салхины ангилал (wake turbulence);

- (iii) тухайн агаарын хөлгийн радио холбоо, навигацийн болон ойртолт үйлдэх тоног төхөөрөмж;
  - (iv) хөөрөх цаг болон аэродромын нэр;
  - (v) чиг шулуун нислэгийн хурд, өндөр болон маршрут;
  - (vi) буух аэродром, тооцоот нислэгийн цаг болон 91.405-т шаардсан нөөц аэродромууд;
  - (vii) НХҮ-ний байгууллагаас шаардсан бусад нэмэлт мэдээлэл;
  - (viii) түлш зарцуулагдан дуусах хугацаа (fuel endurance);
  - (ix) агаарын хөлөг дахь нийт хүний тоо;
  - (x) тухайн агаарын хөлгийн авран хамгаалах болон онцгой байдлын үед ашиглах тоног төхөөрөмж;
- (4) хөөрөх цагаасаа 30 минутаас илүү хойшилсон бол, хойшлох тухай мэдэгдсэн даруйд нь холбогдох НХҮ-ний байгууллагад мэдэгдэнэ;
- (5) НХҮ-гүй аэродромд буусан бол нислэгийн төлөвлөгөөг буусан даруйд цуцлана.

(b) Энэ дүрэмд ашиглагдах агаарын хөлгийн хуйлрах салхины ангилалыг ICAO Doc 8643-т тодорхой заасан болно.

#### **91.409. Нислэгийн төлөвлөгөөг дагаж мөрдөх**

(a) Хэрэглэлийн нислэгийн төлөвлөгөөг хүргүүлсэн үед агаарын хөлгийн дарга дор дурьдсанаас бусад үед нислэгийн төлөвлөгөөг дагаж мөрдөнө:

- (1) өөрчлөлт оруулах тухай хүсэлт гарган (request), НХҮ-аас хүсэлтийн дагуу зөвшөөрөл олгосон бол; эсхүл
- (2) нислэгийн төлөвлөгөөнөөс гажих онцгой нөхцөл байдал бий болсон бол.

(b) ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга:

- (1) нисэхийн мэдээлэлийн эмхэтгэл (AIP)-д заасан агаарын замаар нисэхээр төлөвлөсөн бол уг тогтоосон агаарын зам дагуу нислэг үйлдэнэ; эсхүл
- (2) бусад агаарын замаар нислэг үйлдэхээр төлөвлөсөн бол навигацийн төхөөрөмж болон уг агаарын замын дагуух цэгүүдийг холбосон шугамаар нислэг үйлдэнэ; эсхүл
- (3) агаарын замтай зэрэгцээ шугамаар нислэг үйлдэхээр төлөвлөсөн бол, НХҮ-ний байгууллагын зөвшөөрлийн дагуу нислэг үйлдэнэ.

(c) Энэ зүйлийн (a)-гийн (2)-т заасны дагуу нислэгийн төлөвлөгөөнөөс гажсан бол агаарын хөлгийн дарга холбогдох НХҮ-ний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.



**91.411. Нислэгийн төлөвлөгөө өөрчлөгдөх**

ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нислэгийн төлөвлөгөөнөөс дараах тохиолдолд гажсан бол НХҮ-ний байгууллагад нэн даруй мэдээлж, боломжтой бол буцаад замдаа орно:

- (1) маршрутаас гажсан аливаа өөрчлөлт;
- (2) нислэгийн төлөвлөгөөнд өгөгдсөн жинхэнэ хурдны (true airspeed) 5%, эсхүл тоогоор илэрхийлэгдэх дууны хурд (Mach) тоо  $\pm 0.01$  ба түүнээс илүү гарсан өөрчлөлт;
- (3) нисэн өнгөрөх тооцоот цагаас 2 минутаас их өөрчлөлт гарсан бол шинэ тооцоот цагийг НХҮ-ний байгууллагад мэдээлнэ.

**91.413. ХНД-ээр хөөрөх, буух**

(a) **Аэродромд хэрэглэлээр ойртолт үйлдэх.** Аливаа аэродромд ХНД-ийн дагуу ойртолт үйлдэх шаардлагатай бол агаарын хөлгийн дарга НМЭ-д тогтоосон тухайн аэродромд ойртолт, буулт үйлдэх хэрэглэлийн нислэгийн стандарт журмыг ашиглана.

(b) **Зөвшөөрөгдсөн DA, DH, эсхүл MDA.** Энэ зүйлийн (a)-д заасан ХНД-ийн дагуу ойртолт үйлдэх журамд шийдвэр гаргах үнэмлэхүй өндөр (DA), шийдвэр гаргах харьцангуй өндөр (DH), эсхүл доошилж болох хамгийн бага үнэмлэхүй өндрүүдийн (MDA) аль нэгийг ашиглах агаарын хөлгийн дарга дор дурдсан DA, DH, эсхүл MDA -ийн аль ихийг нь ашиглана:

- (1) тухайн аэродромд ХНД-ээр ойртолт үйлдэх журамд тогтоосон DA, DH, MDA; эсхүл
- (2) агаарын хөлгийн тухайн даргад тогтоосон DA, DH, MDA; эсхүл
- (3) тухайн агаарын хөлгийн тоног төхөөрөмжид тогтоосон DA, DH эсхүл MDA.

(c) **DA, DH эсхүл MDA-аас доош үйлдэх нислэг.** Агаарын хөлгийн дарга дор дурдснаас бусад нөхцөлд энэ зүйлийн (b)-д заасан DA, DH-аас эсхүл MDA-аас доош өндөрт нислэгийг үргэлжлүүлэхгүй:

- (1) агаарын хөлөг нь хэвийн маневраар, хэвийн босоо хурдтайгаар өндөр алдаж, ХБЗ-ны газардах бүсэд бууж болохоор буй бол;
- (2) НМЭ-д тухайн ХНД-ийн дагуу ойртолт үйлдэх журамд тогтоосон алсын барааны харагдацаас бодит алсын барааны харагдац багагүй бол;
- (3) CAT II буюу CAT III-аар нарийвчлалтай ойртолт, буулт үйлдэх журмаас бусад тохиолдолд уг аэродромд ил харааны баримжаа авахад зориулсан дараах тэмдэгтүүдийн аль нэг нь нисгэгчид тод харагдаж танигдахгүй бол:
  - (i) ойртолтын гэрлүүд; эсхүл

- (ii) босгоны тэмдэглэгээ; эсхүл
- (iii) босгоны гэрлүүд; эсхүл
- (iv) зурвасны төгсгөлийн гэрлүүд; эсхүл
- (v) ойртолтын налууг ил хараагаар тодорхойлох гэрэл /VASI, PAPI/; эсхүл
- (vi) газардах бүс буюу газардах бүсийн тэмдэглэгээ; эсхүл
- (vii) газардах бүсийн гэрлүүд; эсхүл
- (viii) хөөрч буух зурвас эсхүл түүний тэмдэглэгээ; эсхүл
- (ix) хөөрч буух зурвасны гэрлүүд.

(d) **Буулт.** НМЭ-д тухайн ХНД-ийн дагуу ойртолт үйлдэх журамд тогтоосон алсын барааны харагдацаас бодит алсын барааны харагдац бага бол агаарын хөлгийн дарга буулт үйлдэхгүй.

(e) **2-р тойрогт гарах журам.** Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд НМЭ-д заасан 2-р тойрогт гарах журмыг дагаж мөрдөнө:

- (1) энэ зүйлийн (c)-д заасан шаардлага хангагдаагүй бол:
  - (i) агаарын хөлөг MDA-ээс доош өндөрт нисэх үед; эсхүл
  - (ii) 2-р тойрогт гарах цэгт (MAP) ирэх үед болон шийдвэр гаргах өндөрт (DA, DH) ирэхэд, мөн түүний дараа газардах хүртэл аль ч хугацаанд; эсхүл
- (2) MDA буюу түүнээс дээш өндөрт эргэлтийн маневр (circling manoeuvre) хийж байхад уг аэродромын тодорхой хэсгүүд нисгэгчид ил, тод харагдахгүй болбол.

(f) **Хөөрөлтийн цаг агаарын хязгаарлалт.** Энэ зүйлийн (ж)-д зааснаас бусад тохиолдолд болон цаг агаарын дараах нөхцөл бүрдээгүй бол агаарын хөлгийн дарга ХНД-ээр хөөрөлт үйлдэж болохгүй:

- (1) цаг агаарын нөхцөл нь НМЭ-д тухайн аэродромын ХНД-ээр хөөрөлт үйлдэх журамд заасан цаг агаарын хязгаарлалтаас дээш байх; эсхүл
- (2) хэрэв ХНД-ээр хөөрөлт үйлдэхэд тохирох цаг агаарын хязгаарлалтыг НМЭ-д тухайн аэродромд тогтоогоогүй бол, үүлний өндөр 100 м-ээс (300 ft) доошгүй, алсын барааны харагдац 1500 м-ээс багагүй байх.

(g) **Хөөрөлтөд багасгасан цаг агаарын хязгаарлалт хэрэглэх.** Дараах нөхцөл бүрдсэн үед агаарын хөлгийн дарга аль нэгэн аэродромоос үүлний өндрийг үл харгалзан алсын барааны харагдац 800 м буюу түүнээс дээш байхад ХНД-ээр хөөрөлт үйлдэж болно:

- (1) хөөрч буух зурвасны голын шугам нь тэмдэглэгээ эсхүл гэрэлтүүлэгтэй бол;

- (2) хөөрч буух зурвасны голын шугамны тэмдэглэгээ эсхүл гэрэлтүүлгийг ажигласны үндсэн дээр агаарын хөлгийн дарга алсын барааны харагдацыг баталгаажуулсан бол;
- (3) НМЭ-д тухайн хөөрч буух зурвасанд хөөрөлтийн багасгасан хязгаарлалт хэрэглэхийг зөвшөөрсөн бол;
- (4) хөөрөлтийн нислэгийн замд байгаа саадыг харгалзан үзсэн бол;
- (5) хэрэв сэнст хоёр хөдөлгүүртэй онгоц бол, автофлюгерийн ажиллагаа бүхий системээр тоноглогдсон бол.

#### **91.415. CAT II болон CAT III-аар нарийвчлалттай ойртолт үйлдэх журам**

(а) Аливаа этгээд дор дурдсан зүйлсийг хангаагүй тохиолдолд CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхгүй:

- (1) нисэх багийн гишүүн бүр тухайн агаарын хөлөг болон түүний ажиллах журмын талаар зохих мэдлэгтэй, тэдгээртэй бүрэн танилцсан бол;
- (2) агаарын хөлгийг удирдаж буй нисгэгчийн өмнөх хэрэглэл нь тухайн нислэгийг хянах тохирсон системтэй бол (flight-control guidance system);
- (3) агаарын хөлгийн даргад тухайн ХБЗ-ны дагуух харагдац (RVR) өгөгдсөн.

(b) Дарга өөрөөр зөвшөөрөөгүй бол, тухайн нислэгийн үйл ажиллагаанд шаардагдах газрын болон агаарын хөлгийн тоног төхөөрөмжүүд суурилуулаагүй, эсхүл ажиллагаагүй бол аливаа этгээд CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхгүй.

(c) Энэ зүйлийн (г)-д хамааралтайгаар, нарийвчлалттай ойртолт үйлдэх журамд DH ашиглах шаардлагатай бол дор дурдсан зөвшөөрөгдсөн DH-ийн аль ихийг авна:

- (1) тухайн аэродромд ХНД-аар ойртолт үйлдэх журамд тогтоосон DH; эсхүл
- (2) агаарын хөлгийн тухайн даргад тогтоосон DH; эсхүл
- (3) тухайн агаарын хөлгийн тоног төхөөрөмжид тогтоосон DH.

(d) Дарга өөрөөр зөвшөөрөөгүй бол, DH ашиглах шаардлагатай CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэж буй нисгэгч дор дурдсан шаардлагыг хангаагүй бол зөвшөөрөгдсөн DH-аас доош ойртолтыг үргэлжлүүлэхгүй:

- (1) агаарын хөлөг нь хэвийн маневраар, хэвийн босоо хурдтайгаар өндөр алдаж, ХБЗ-ны газардах бүсэд бууж болохоор буй бол;
- (2) ХБЗ-ны дор дурдсан ил харааны баримжаа тогтоох тэмдэгтээс аль нэг нь нисгэгчид тод харагдаж, танигдахуйц бол:
  - (i) хөөрч буух зурвасны босго;
  - (ii) хөөрч буух зурвасны босгоны тэмдэглэгээ;

- (iii) хөөрч буух зурвасны босгоны гэрэлтүүлэг;
- (iv) хөөрч буух зурвасны газардах бүс эсхүл газардах бүсийн тэмдэглэгээ;
- (v) хөөрч буух зурвасны газардах бүсийн гэрэлтүүлэг.

(е) Дарга өөрөөр зөвшөөрөөгүй бол, CAT II эсхүл CAT III нарийвчлалтай ойртолт үлдэж буй нисгэгч энэ зүйлийн (г)-д заасан шаардлагыг газардахаас өмнө хангаагүй бол шууд 2-р тойрогт гарна.

(f) CAT III нарийвчлалттай ойртолтыг DH-гүй үйлдэж буй агаарын хөлгийн нисгэгч Даргаас олгосон зөвшөөрөлгүй тохиодолд газардаж болохгүй.

#### **91.417. CAT II болон CAT III хязгаарлалтаар ойртолт үйлдэх заавар**

(a) Дор дурдсан нөхцөлд Монгол улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр аливаа этгээд CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхгүй:

(1) уг агаарын хөлөгт дараах зааврууд байхгүй бол:

- (i) тухайн онгоцны 91.419-т заасны дагуу баталсан CAT II нарийвчлалтай ойртолт үйлдэх хүчин төгөлдөр заавар; эсхүл
- (ii) тухайн онгоцны 91.419-т заасны дагуу баталсан CAT III нарийвчлалтай ойртолт үйлдэх хүчин төгөлдөр заавар;

(2) батлагдсан зааварт тусгасан журам, хязгаарлалт, зааварчилгааны дагуу CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэнэ;

(3) батлагдсан зааварт тусгасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхэд шаардлагатай хэрэглэл, тоног төхөөрөмжид үзлэг, үйлчилгээ хийгдсэн.

(b) Дарга шаардсан үед үзлэг шалгалтын явцад CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэх Ашиглагч, үйл ажиллагаа явуулж буй үндсэн байрандаа батлагдсан зааврын хүчин төгөлдөр хувийг хадгалж, бэлэн байлгана.

(c) Энэ зүйлийн (a) болон (b)-д заасны дагуу шаардсан зааврыг ИНД-119-ийн дагуу Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны заавартай нэгтгэж болно.

#### **91.419. CAT II болон CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэх зааврыг батлах**

(a) CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэх зааврыг батлуулахаар болон батлагдсан зааварт нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөдөл гаргаж буй этгээд уг заавар болон өөрчлөлтийн төслийг Даргад хүргүүлнэ.

(b) Хэрэв өргөдөл гаргагч CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үзүүлэх нислэг үйлдэн дүгнэлт (Evaluation Programm) гаргуулах бол өргөдөлд дараахь зүйлсийг тусгасана:

- (1) агаарын хөлгийн байршил, үзүүлэх нислэг үйлдэх газар;
- (2) үзүүлэх нислэг эхлэх өдөр.

(c) CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэх зааварт дор дурдсан зүйлсийг тусгасан байна:

- (1) тухайн зааварт хамаарагдах агаарын хөлгийн бүртгэл, маяг, загвар;
- (2) дараахь үйл ажиллагааны журмыг багтаасан Техник үйлчилгээний хөтөлбөр:
  - (i) CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхэд хэрэглэгдэх бүх хэрэглэл, тоног төхөөрөмжид 3 сар тутам хийх үзлэг, шалгалт;
  - (ii) CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхэд хэрэглэгдэх бүх хэрэглэл, тоног төхөөрөмжид 12 сар тутам хийх лабораторийн шалгалт (Bench Testing);
  - (iii) ИНД-43-т заасны дагуу бүх статик даралтын системд 12 сар тутам хийх үзлэг, шалгалт;
  - (iv) хэрэглэл эсхүл тоног төхөөрөмжийн алдааны улмаас CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үргэлжлэх боломжгүй болсон талаарх техник үйлчилгээний бүртгэлд огноо, нисэх буудал, шалтгааныг тэмдэглэсэн бүртгэл;

(3) дараах зүйлсэд хамаарах журам, зааварчлагууд:

- (i) шийдвэр гаргах харьцангуй өндрийг мэдэх (Recognition of DH);
- (ii) зурвасны дагуух харагдацын (RVR) мэдээллийг ашиглах;
- (iii) ойртолтыг хянах;
- (iv) шийдвэр гаргах бүсэд ILS-ын заалтад зөвшөөрөгдсөн хазайлтын хамгийн их хязгаар;
- (v) 2-р тойрогт гарах;
- (vi) нам өндрийн ойртолтын нислэгийн тоног төхөөрөмжийг ашиглах;
- (vii) автопилотыг ашиглахад зөвшөөрөгдөх аюулгүй нам өндөр;
- (viii) хэрэглэл болон тоног төхөөрөмжийн алдааг анхааруулах систем;
- (ix) хэрэглэлийн эвдрэл, гэмтэл;
- (x) Дарга шаардлагатай гэж үзсэн бусад журам, заавар, хязгаарлалт.

(d) Энэ зүйлийн (c)-ийн 2.1-ийг үл харгалзан, нислэгт шалгах ажиллагаа нь үзлэг, шалгалтын бусад хувилбарыг орлож болох ба энэ тохиолдолд техник

үйлчилгээний хөтөлбөрт уг нислэгэнд шалган гүйцэтгэх журам болон энэ талаарх хийгдэх бүртгэл, тэмдэглэлийг багтаасан байна.

#### **91.421. Мөстөлттэй үед нислэг үйлдэх**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга дор дурдсан нөхцөлд тухайн агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

(1) хөөрөлт үйлдэхэд:

- (i) сэнс, цонхны урд шил, хөдөлгүүрийн агаар орох хэсэг, эсхүл хурд болон өндрийн хэрэглэлд хамаарах систем, өндөр авах босоо хурд, авиагоризонтын системд цас, мөс тогтсон эсхүл цантсан бол; эсхүл
- (ii) далавч, стабилизатор, удирдлагын гадаргууд цас, мөс тогтсон эсхүл цантсан бол;

(2) тухайн агаарын хөлөг нь мөстөлтөөс хамгаалах төхөөрөмжгүй бол, мэдэгдэж буй эсхүл урьдчилсан мэдээгээр мөстөлттэй гэж өгөгдсөн бүсэд.

(b) Тухайн агаарын хөлөг цас, мөс, цанталттай байх үед үйлдвэрлэгчийн нарийвчилсан нислэгийн заавар, эсхүл зааварчилганы дагуу хөөрөлт үйлдэх бол агаарын хөлгийн дарга хөөрөлт үйлдэж болно.

(c) Цаг агаарын урьдчилсан мэдээллээр нислэг мөстөлттэй нөхцөлд явагдах байсан боловч цаг агаарын өөрчлөлтийн улмаас тухайн нислэг эхлэхийн өмнө мөстөлтийн нөхцөл бий болохгүй тухай нислэгийн өмнөх цаг агаарын сүүлчийн мэдээллийг агаарын хөлгийн дарга авсан бол, урьдчилсан нөхцөлд үндэслэсэн энэ зүйлийн (a)-ийн (2)-т заасан хязгаарлалт хамаарахгүй.

#### **91.423. ХНД-д мөрдөх аюулгүй нам өндөр**

Хөөрөлт, буулт үйлдэхээс бусад тохиолдолд, агаарын хөлгийн дарга дор дурдсан өндрөөс доош өндөрт ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

(1) НМЭ-д заасан аюулгүй нам өндрөөс доош; эсхүл

(2) хэрэв НМЭ-д аюулгүй нам өндрийг заагаагүй бол:

- (i) НМЭ-д тогтоосон уулархаг бүсэд тухайн агаарын хөлгөөс 5 км-ийн радиус дахь хамгийн өндөр саадаас дээш 600 м (2000 ft); эсхүл
- (ii) тухайн агаарын хөлгөөс 5 км-ийн радиус дахь хамгийн өндөр саадаас дээш 300 м (1000 ft).

### 91.425. ХНД-ийн чиг шулуун нислэгийн үнэмлэхүй өндөр болон өндрийн цуваачлал

(а) НХУ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол, Монгол улсын хяналттай агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь дор дурдсан үнэмлэхүй өндөр буюу нислэгийн өндрийн цуваачлалыг хэрэглэнэ:

- (1) шилжих үнэмлэхүй өндрөөс доош өндрийн цуваанд:
  - (i) Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, 600 м-ээр ихсэх шилжих өндөр хүртэл сондгой тоотой зуут бүхий нислэгийн үнэмлэхүй өндөр (900, 1500, 2100 г.м.); эсхүл
  - (ii) Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, 600 м-ээр ихсэх шилжих өндөр хүртэл тэгш тоотой зуут бүхий үнэмлэхүй өндөр (1200, 1800, 2400 г.м.); эсхүл
- (2) шилжих цуваа болон түүнээс дээш 12500 м (FL410) хүртэлх өндрийн цуваанд:
  - (i) Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, шилжих цуваанаас эхлэн 600 м-ээр ихсэх сондгой тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (2100, 2700 г.м.); эсхүл
  - (ii) Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, шилжих цуваанаас эхлэн 600 м-ээр ихсэх тэгш тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (2400, 3000 г.м.); эсхүл
- (3) нислэгийн цуваа 12500 м-ээс дээш өндөрт:
  - (i) Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, 13700м (FL450)-ийг оролцуулан 1200м-ээр ихсэх сондгой тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа; эсхүл
  - (ii) Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, 13100м (FL430)-ийг оролцуулан 1200 м-ээр ихсэх тэгш тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа.

(b) НХУ-аас зөвшөөрөөгүй бол Монгол Улсын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь аэродромын шилжих үнэмлэхүй өндөр болон шилжих цувааны хоорондох аливаа өндөрт чиг шулуун нислэг үйлдэхгүй.

(c) Монгол Улсын хяналтгүй агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь дараах тохиолдолд шилжих үнэмлэхүй өндөр болон шилжих цувааны хоорондох өндөрт чиг шулуун нислэг үйлдэж болно:

- (1) шилжих үнэмлэхүй өндөр эсхүл шилжих цувааны хооронд чиг шулуун нислэг үйлдэхээс аргагүй байдалд хүрсэн;
- (2) тухайн өндөрт нисэж буй бусад агаарын хөлөгт саад болохгүй гэдгийг бататгасан;

- (3) хамаарах НХУ-ний байгууллагад нислэг үйлдэх өндрийн талаар урьчилан мэдэгдсэн бол.

#### **91.427. ХНД-ийн үед радио холбоо барих**

(a) НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга:

- (1) тухайн холбоо барьж буй давтамж дээр тогтмол сонсож байна;
- (2) дараахь мэдээллийг холбоо барьж буй НХУ-д аль болох хурдан хугацаанд мэдээлнэ:
  - (i) илтгэл өгөх тогтоосон замын цэгүүдийг нисэн өнгөрч буй цаг, нислэгийн өндөр, эсхүл НХУ-аас онцолж заасан мэдээлэл өгөх замын цэгүүд;
  - (ii) нислэгийн аюулгүй байдалд хамаарах бусад мэдээлэл.

(b) Энэ зүйлийн (a)-ийн (2)-т заасан заалтыг үл харгалзан, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга радиолокаторын хяналтанд байх үед НХУ-аас тусгайлан хүссэн илтгэл өгөх цэгүүдийн өнгөрөлтийг мэдээлнэ.

#### **91.429. ХНД-ийн үед радио холбоо алдагдах**

(a) НХУ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол, ил хараагаар нисэх цаг агаарын нөхцөлд (VMC) ХНД-ээр нислэг үйлдэж байх хугацаанд радио холбоо алдагдсан, эсхүл радио холбоо алдагдсаны дараа ил харааны нислэгийн цаг агаарын нөхцөлд (VMC) шилжсэн бол уг агаарын хөлгийн дарга нислэгийг ИХНД-ээр үргэлжлүүлж, хамгийн ойрын тохиромжтой аэродромд бууна.

(b) НХУ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол, хэрэглэлээр нисэх цаг агаарын нөхцөлд (IMC), эсхүл ил харааны нислэгийн цаг агаарын нөхцөл (VMC) нь цаашид хадгалагдахгүй үед ХНД-ээр нислэг үйлдэж байх хугацаанд радио холбоо алдагдсан бол агаарын хөлгийн дарга тухайн нислэгийг нислэгийн төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлж, энэ хугацаанд дор дурдсан арга хэмжээг авна:

- (1) хэрэв хөөрөлтийн дараа радио холбоо алдагдсан бол сүүлд зөвшөөрөгдсөн нислэгийн өндрийг тухайн цэг хүртэл хадгалж дараа нь нислэгийг төлөвлөгөөний дагуу үйлдэнэ;
- (2) хэрэв хөөрөлтийн дараа радиолокаторын хяналтанд НХУ-аас өгсөн курсээр нисэж буй үед радио холбоо алдагдсан бол уг курсыг хоёр минутын турш хадгалж (аливаа саадаас аюулгүй) дараа нь нислэгийг төлөвлөгөөний дагуу үйлдэнэ;
- (3) хэрэв радио холбоо чиг шулуун нислэгийн үед алдагдвал:



- (i) НХУ-аас тусгайлан өгсөн, эсхүл тодорхой цэг өгөгдөөгүй бол хэрэглэлийн ойртолт эхлэх цэг дээр хамгийн сүүлд заагдсан өндөрт очно;
  - (ii) хэрэв шаардлагатай бол нисэн буухаар тооцоолсон цагт эсхүл түүнээс хойш, эсхүл ойртолт эхлүүлэх цагт өндөр алдаж хүлээх тойрогт орж хэрэглэлийн ойртолтын журмын дагуу ойртолтыг эхлүүлнэ;
- (4) хэрэв ойртолт үйлдэх эхний үе шатанд НХУ-аас ойртолт үйлдэх зөвшөөрөл өгөгдөөгүй үед радио холбоо алдагдсан бол, ойртолтыг үргэлжлүүлэх, зөвшөөрсөн өндөр хүртэл доошилж, шаардлагатай бол хүлээх тойрог хийж ойртолтыг үргэлжлүүлэх сүүлийн үе шатны өндөрт орсны дараа ойртолт үйлдэх журмыг мөрдөн үргэлжлүүлнэ;
- (5) хэрэв радиолокаторын хяналтанд НХУ-ын өгсөн курсээр нисэж буй үед ойртолтын эхний болон дунд үе шатанд радио холбоо алдагдсан бол сүүлийн зөвшөөрсөн өндрийг хадгалан ойртолтын сүүлийн үе шатанд орсны дараа ойртолт үйлдэх журмыг мөрдөн үргэлжлүүлнэ;
- (6) хэрэв тухайн ойртолт үйлдэх хязгаарлалт хэтэрснээс шалтгаалан хүлээх бүсэд нисэж буй үед эсхүл аэродром ямар нэгэн шалтгаанаар хаагдсан үед радио холбоо алдагдсан бол:
- (i) НХУ-аас чиглэлээ өөрчлөх (divert) тогтоож өгсөн хугацааг дуустал хүлээх тойрогт нисэн;
  - (ii) нислэгийн төлөвлөгөөнд өгөгдсөн бэлтгэл аэродром руу нисэн;
  - (iii) хэрэглэлийн ойртолт үйлдэх зааврыг мөрдөнө;
- (7) 2-р тойрогт гарч буй үед радио холбоо алдагдсан бол дараагийн ойртолт үйлдэх өгөгдсөн цаг эсхүл тооцоот буух цагийн аль сүүлчийнхээс хойш 30 минутын дотор ойртолт үйлдэх бөгөөд 30 минутын хугацаанд буух боломжгүй бол нислэгийн төлөвлөгөөнд өгөгдсөн нөөц аэродромруу нисэн хэрэглэлийн ойртолтын журмын дагуу нислэгийг үргэлжлүүлэн бууна.

#### **91.431. Төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг мэдэгдэх**

(a) ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нисэхийн аливаа холбооны төхөөрөмж эвдэрч гэмтсэн тохиолдолд нэн даруй НХУ-д мэдэгдэнэ.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан мэдээлэлд дор дурдсан зүйлсийг багтаана:

- (1) агаарын хөлгийн маяг;
- (2) агаарын хөлгийн бүртгэл, нислэгийн дугаар;
- (3) агаарын хөлгийн даргын нэр;
- (4) Ашиглагчийн нэр;

- (5) агаарын хөлгийн байрлал, өндөр;
- (6) нислэгийн үе шат;
- (7) эвдэрч гэмтсэн төхөөрөмж;
- (8) эвдрэл, гэмтлийн талаарх товч мэдээ;
- (9) нислэгт үзүүлсэн нөлөө.

## **Е Бүлэг. Хэрэглэл болон тоног төхөөрөмжид тавигдах шаардлага**

### **91.501. Ерөнхий зүйл**

Аливаа этгээд дор зааснаас бусад нөхцөлд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- (1) энэ бүлгээр шаардсан тухайн маягийн болон дараах тоо бүхий хэрэглэл, тоног төхөөрөмж агаарын хөлөгт суурилуулсан байх;
- (2) тухайн агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл, тоног төхөөрөмж нь дор дурдсан бичиг баримтад тусгасан тодорхойлолт (specification) болон НТЧ-ын загварын стандартыг хангасан байх:
  - (i) энэ дүрмийн Хавсралт А:
  - (ii) ИНД-21-ийн Хавсралт В:
  - (iii) ИНД-26:
  - (iv) Дарга баталсан бусад НТЧ-ын загварын стандартууд эсхүл Дарга баталсан бусад загварын тусгай ангилалын НТЧ-ын гэрчилгээтэй онгоц;
- (3) тухайн агаарын хөлгийн хэрэглэл, тоног төхөөрөмжийг уг агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс өгсөн зааварчилгаа, эсхүл Дарга хүлээн зөвшөөрсөн бусад зааврын дагуу суурилуулсан байх;
- (4) 91.537-д зааснаас бусад тохиолдолд тухайн агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл, тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагаатай байх.

### **91.503. Хэрэглэл, тоног төхөөрөмжийн байрлал**

Ашиглагч бүр дор дурдсан зүйлсийг баталгаажуулсан байна:

- (1) нэг нисгэгчтэй агаарын хөлгийн аливаа хэрэглэл, тоног төхөөрөмж уг нисгэгчийн суудлын хэвийн байрлалаас харагдахуйц, ажиллуулах боломжтой;
- (2) хоёр нисгэгчтэй агаарын хөлгийн аливаа дан (нэг) хэрэглэл, тоног төхөөрөмж нь нисгэгч бүрийн суудлын хэвийн байрлалаас харагдахуйц, ажиллуулах боломжтой байна.

### **91.505. Суудал, хамгаалах бүс**

(a) Энэ зүйлийн (b)-д заасан заалт болон агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлөгт дор дурьдсан суудал, хамгаалах бүсийг суурилуулсан байна:

- (1) агаарын хөлөгт байх бүх хүмүүст зориулсан суудал;
- (2) суудал бүрийн хамгаалах бүс;
- (3) зориулалтын мөрөвчтэй хамгаалах бүсийг:
  - (i) уран жолоодлогын нислэг үйлдэж буй агаарын хөлгийн суудал бүрт;
  - (ii) 10 буюу түүнээс дээш суудал бүхий агаарын хөлгийн багийн бүх гишүүдийн суудал бүрт;
- (4) зориулалтын мөрөвчтэй хамгаалах бүс, эсхүл ташуу даруулгыг:
  - (i) нисдэг тэрэгний нисэх багийн гишүүн бүрийн суудал бүрт;
  - (ii) сургалтын онгоцны нисэх багийн гишүүн бүрийн суудал бүрт;
  - (iii) 91.311-ийн (c)-д заасны дагуу үйл ажиллагаа явуулж буй онгоцны багийн гишүүдийн суудал бүрт.

(b) Энэ зүйлийн (a)-ийн (1), (2)-т заасан заалтыг үл харгалзан, дараах тохиолдолд суудал, хамгаалах бүсийг шаардахгүй:

- (1) 91.207-гийн (г)-гийн (1)-д заасны дагуу агаарын хөлөгт сууж буй хүүхэд;
- (2) шүхрээр буух этгээдэд.

### **91.507. Зорчигчдод мэдээлэх тэмдэглэгээ**

Агаарын бөмбөлөгөөс бусад 10 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлгийн зорчигчийн тасалгаа нь нисэх багийн бүхээгээс тусгаарлагдсан бол агаарын хөлгийн үйлчлэгч болон зорчигчдод зориулсан дараах мэдээлэл, таних тэмдгийг харагдахуйц газар байрлуулсан байх ба тэдгээрийг нисэх багийн бүхээгээс ажиллуулах боломжтой байна:

- (1) тамхи татахыг хориглох тэмдэг;
- (2) хамгаалах бүс хэрэглэх тэмдэг.

### **91.509. Зайлшгүй шаардлагатай хэрэглэл ба тоног төхөөрөмж**

(a) Хөдөлгүүрт планераас бусад НТЧ-ын гэрчилгээтэй хөдөлгүүрт агаарын хөлөг бүрийг дараах зүйлсийг заах хэрэглэлээр тоногловсон байна:

- (1) нислэгийн хурд заагч;
- (2) нислэгийн ашиглалтын зааварт хурдны хязгаарлалтыг М (Mach) тоогоор илэрхийлсэн бол М (Mach) тоо заагч;

- (3) метр эсхүл футээр илэрхийлсэн өндөр хэмжигч;
  - (4) соронзон чиглэл заагч;
  - (5) нэмэгдэл бакнаас бусад, түлшний хэмжээ заагч;
  - (6) хөдөлгүүр бүрийн эргэлт заагч;
  - (7) тосолгооны системтэй хөдөлгүүр бүрийн тосны даралт заагч;
  - (8) шингэн хөргөлттэй хөдөлгүүрийн хөргөлтийн хэм заагч;
  - (9) 250-иас дээш морины хүчний чадалтай хөдөлгүүр бүрийн тосны хэм заагч;
  - (10) поршинт хөдөлгүүр бүрийн насосоос гарах түлшний даралт заагч;
  - (11) 250-иас дээш морины хүчний чадалтай, агаараар хөрдөг поршинт хөдөлгүүр бүрийн цилиндрийн халуун заагч;
  - (12) флапны байрлалыг нисэх баг харж тодорхойлох боломжгүй бол, флапны байрлал заагч;
  - (13) хэрэв агаарын хөлөг эвхэгддэг хөл ангитай бол хөл ангийн байрлал заагч;
  - (14) цахилгаан үүсгүүрийн хэвийн ажиллагааг хянах самбар;
  - (15) хэрэв агаарын хөлгийн бүхээг нь хөдөлгүүрээс гарах халуун хийн халаагуур, эсхүл дотоод шаталтын халаагч ашигладаг бол бүхээг дэх нүүрсхүчлийн хэт ислийн хэмжээг заагч.
- (b) Энэ зүйлийн (c)-д хамааралтайгаар, Монгол улсад бүртгэлтэй, НТЧ-ын гэрчилгээтэй дор дурдсан агаарын хөлгүүд нислэгийн цаг (time-in-service) бүртгэх автомат төхөөрөмжөөр тоноглогсон байна:
- (1) ИНД-137-гийн дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж буй нисдэг тэрэг;
  - (2) ИНД-135-ын дагуу ашиглагдаж буй нисдэг тэрэг;
  - (3) тусгай ангиллын туршилтын НТЧ-ын гэрчилгээтэй, эсхүл сонирхогчийн бүтээсэн тусгай ангиллын НТЧ-ын гэрчилгээтэйгээс бусад, аливаа зориулалтаар ашиглагдаж буй нисдэг тэрэг;
  - (4) ИНД-137-гийн дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж буй онгоц.
- (c) Энэ зүйлийн (b)-д заасан шаардлагыг мөрдөж эхлэх өдрийг салбар хариуцсан сайд тусгайлан мэдэгдэнэ.
- (d) Агаарын хөлөг нь зорчигчийн болон ямар нэг тасалгаа руу нэвтрэн орох хаалгатай бөгөөд тэдгээр нь түгжигддэг бол нисэх багийн гишүүд түгжээг онгойлгох хэрэгслээр тоноглогсон байна.

### **91.511 Шөнийн ИХНД-ээр нисэх агаарын хөлгийн хэрэглэл болон тоног төхөөрөмж**

(a) 91.509-ийн дагуу тоноглогдсон НТЧ-ын гэрчилгээтэй хөдөлгүүрт агаарын хөлөг шөнийн цагаар ИХНД-ээр нислэг үйлдэх бол дараах зүйлсээр тоноглогдсон байна:

- (1) энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд эргэлт болон хальтиралт заагч (turn and slip indicator);
- (2) байрлалын (position) гэрэл;
- (3) мөргөлдөхөөс сэргийлэх гэрэл;
- (4) зайлшгүй шаардлагатай хэрэглэл болон заагчуудыг гэрэлтүүлэх гэрэл.

(b) Тэнхлэгийн аль ч тал руу  $360^{\circ}$  эргэлдэхийг заах чадвар бүхий гуравдагч авиагоризонт заагчтай бол эргэлт болон хальтиралт заагч (turn and slip indicator) шаардлагагүй.

### **91.513 ИХНД-д шаардлагатай холбооны төхөөрөмж**

(a) Радио холбоогүйгээр ИХНД-ээр нисэх зөвшөөрөл НХУ-аас нисгэгчид олгоогүй бол, ИНД-71-д заасны дагуу тодорхойлсон А, В, С, D ангиллын хяналттай агаарын зайд, эсхүл E ангиллын агаарын зайд шөнийн цагаар ИХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг зохих НХУ-тай хоёр талын радио холбоог тасралтгүй барих боломжтой, энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан 1-р эсхүл 2-р түвшингийн стандартад нийцсэн радио холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

(b) Хяналтгүй агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг НХУ-тай холбоо барих шаардлагатай бол энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан заасан 1-р эсхүл 2-р түвшингийн стандартад нийцсэн радио холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

### **91.515 Нөөц**

### **91.517 ХНД-д шаардлагатай хэрэглэл, төхөөрөмж**

91.509 болон 91.511-ийн дагуу тоноглогдсон НТЧ-ын гэрчилгээтэй хөдөлгүүрт агаарын хөлөг ХНД-ээр нислэг үйлдэх бол дараах зүйлсээр тоноглогдсон байна:

- (1) гироскоп эсхүл инерциал хэлбэрээр ажиллах авиагоризонт;
- (2) гироскоп эсхүл инерциал хэлбэрээр ажиллах соронзон чиглэл заагч;
- (3) гироскоп хэрэглэлийн цахилгаан тэжээлийн хангалттай байдал;
- (4) гектопаскаль /милибар/-аар тохируулсан метр /ft/-ээр илэрхийлэх барометрийн өндөр хэмжигч;

- (5) гаднах агаарын хэм хэмжигч;
- (6) цаг, минут, секундээр илэрхийлэх цаг;
- (7) конденсаци, мөстөлтөөс сэргийлэх хэрэгсэл бүхий км/цагаар (knots) илэрхийлэх хурд хэмжигч;
- (8) босоо хурд заагч.

#### **91.519 ХНД-ийн үед шаардлагатай холбоо, навигацийн төхөөрөмж**

(a) ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг зохих НХУ-ний нэгж буюу аэронавигацийн болон холбооны төхөөрөмжтэй хоёр талын радио холбоог тасралтгүй барих боломжтой, энэ дүрмийн хавсралтын А9-д заасан 1-р түвшингийн стандартад нийцэх холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

(b) ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг дараах навигацийн системээр тоноглогдсон байна:

- (1) энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан 1-р түвшингийн стандартад нийцсэн байх;
- (2) дараах шаардлагын дагуу нисэх чадвартай агаарын хөлөг:
  - (i) 91.407-ийн дагуу шаардсан нислэгийн төлөвлөгөөний дагуу;
  - (ii) зохих тогтоосон RNP агаарын зайд;
  - (iii) НХУ-ын шаардлагын дагуу.

(c) RNP үзүүлэлтийн шаардлагын дагуу RNP агаарын зайд болон холбогдох RNP замд үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлөг болон агаарын хөлгийн навигацийн системийг Дарга хүлээн зөвшөөрсөн байна.

(d) ICAO Doc 7030-д заасны дагуу тогтоосон MNPS бүхий агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг:

- (1) маршрутын аль ч үед (хөөрөхөөс эхлэн нислэгийн бүх хугацаанд) замаас хазайхад нисэх багийн гишүүдэд хазайлтын талаар мэдээлж байх навигацийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
- (2) MNPS нислэгийн үйл ажиллагааг Дарга хүлээн зөвшөөрсөн байна.

(e) Нислэгийн цуваа 8900м (FL290)-ээс дээш өндөрт 300 м (1000 ft)-ийн багасгасан босоо зайчлалын хязгаарлалт (RVSM)-ыг ашиглаж буй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийг:

- (1) Дарга хүлээн зөвшөөрсөн байх;
- (2) дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байна:
  - (i) нислэгийн цувааг заах өндөр заагч;
  - (ii) нислэгийн сонгосон цувааг автоматаар хадгалагч;

- (iii) сонгосон нислэгийн цуваанаас 60 м (200 ft)-ээр гажсан тохиолдолд нисэх багт дуут болон гэрлэн дохио өгөгч;
  - (iv) энэ зүйлийн (е)-д заасан автомат өндөр хэмжигчийн аль нэг рүү шилжин ажиллах чадвар бүхий өндөр хэмжигч.
- (f) Энэ зүйлийн (е)-ийн 2.1-д шаардсан өндөр хэмжих төхөөрөмж нь хоёроос доошгүй системээс бүрдсэн байна.
- (g) RNP эсхүл MNPS агаарын зайд нисэх агаарын хөлгийн холбоо, навигацийн системд гэмтэл гарсан тохиолдолд үлдсэн төхөөрөмж нь агаарын хөлгийн нислэгийг энэ зүйлийн (а), (b), (г)-д заасан шаардлагын дагуу үргэлжлүүлэх боломжийг хангасан, (а), (b), (г)-ийн (1)-д шаардсан бие даасан ажиллагаа бүхий тоног төхөөрөмж байна.

### **91.521. CAT II болон CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэхэд шаардлагатай төхөөрөмж**

(а) 91.509, 91.511, 91.517-д заасны дагуу тоноглогдсон CAT II эсхүл CAT III нарийвчлалттай ойртолт үйлдэх агаарын хөлөг дараах зүйлсээр тоноглогдсон байна:

- (1) курс (localiser) болон глиссадын (glideslope) дохиолол хүлээн авагч хоёр тусдаа систем нь:
  - (i) нисгэгч бүрийн суудлаас хянах ILS-ийн үндсэн заалт;
  - (ii) курсын болон глиссадын радиомаяжийн дохиолол хүлээн авах тус бүр нэгээс доошгүй антеннтай;
- (2) агаарын хөлгийн холбооны төхөөрөмжийн ажиллагаанд үл нөлөөлөх энэ зүйлийн (1)-д заасан ILS систем нэгээс доошгүй;
- (3) холын болон дундын (outer and middle) чиглүүлэх радиостанцын дохиоллыг дуугаар болон гэрлээр хянах маркерын хүлээн авагч;
- (4) гироскоп эсхүл инерциал ажиллагаатай, авиагоризонт хоёр ширхэг;
- (5) гироскоп эсхүл инерциал ажиллагаатай, соронзон чиглэл заагч хоёр ширхэг;
- (6) конденсац, мөстөлтөөс сэргийлэх хэрэгсэл бүхий км/цагаар (knots) илэрхийлэх хурд хэмжигч хоёр ширхэг;
- (7) метр /ft/-ээр тохируулсан, тус бүртээ агаарын хөлгийн дугуйны өндрөөс шалтгаалсан алдааг засварладаг таблицаар үзүүлсэн зурагтай (placarded) өндөр хэмжигч хоёр;
- (8) өндөр авах болон алдах босоо хурд заагч хоёр ширхэг;
- (9) дараах зүйлсээс бүрдсэн нислэгийг удирдан чиглүүлэх систем: болон

- (i) ILS-ийн курсын чиглүүлэгчийн дохиололтой харьцуулан автоматаар жолоодон ойртолт, буулт хийх хүчин чадал бүхий автопилот нэгээс доошгүй байх; эсхүл
  - (ii) ILS-ийн курс болон глиссадын дохиоллыг хүлээн авч тооцоолсон мэдээллээ дэлгэц болон нислэгийн хэрэглэл дээр харуулан заалтыг харьцуульж чиглэл болон глиссадын налууг тохируулан команд өгөх нислэгийн удирдлагын систем;
- (10) шийдвэр гаргах өндөр нь 50м /150 ft/-ээс доош нислэгт:
- (i) ойрын (inner) чиглүүлэх радиостанцын дохиоллыг дуугаар болон гэрлээр хянах маркерын хүлээн авагч; эсхүл
  - (ii) радио өндөр хэмжигч;
- (11) нисгэгчид системийн алдаа, доголдлыг анхааруулах системийн хувьд дор дурдсан хэрэглэлд:
- (i) энэ хэсгийн (1), (4), (5), 9/-д заасан зүйлс;
  - (ii) CAT III нарийвчлалттай ойртолтод ашиглахаар суурилуулсан бол, радио өндөр хэмжигч болон хөдөлгүүрийн хүчийг автоматаар удирдах систем;
- (12) бүрэн ажиллагаатай хос удирдлага;
- (13) гадна орчинтой холбогдсон, нөөц эх үүсвэр бүхий статик даралтын систем;
- (14) газардах болон буултын дараа аль ч нисгэгчийн талаас гадагш харах нөхцөлийг хангах шил арчигч, эсхүл түүнтэй адилтгах хэрэгсэл.
- (b) Энэ зүйлийн (a)-гийн (4)-с 8/-д шаардсан хэрэглэл, төхөөрөмжийн тоонд 91.517-д заасан ХНД-ийн үед шаардагдах хэрэглэл, төхөөрөмжийг багтаасан байна.

### **91.523. Ослын үед хэрэглэх төхөөрөмж**

- (a) 10 буюу түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлөг дараах хэрэглэлээр тоноглогдсон байна:
- (1) нислэгийн үед өвдөх, хөнгөн бэртэж гэмтэхэд анхны тусламж үзүүлэхэд агаарын хөлгийн бүх тасалгаанд хүснэгт 7-д заасан эмнэлгийн анхны тусламжийн хэрэгслүүдийг байрлуулсан;
  - (2) Хүснэгт 8-д заасан тоо бүхий, тасалгаануудад байрлуулсан авч хэрэглэхэд бэлэн зөөврийн гал унтраагч.
- (b) 20 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлөг багийн гишүүд ашиглахад зориулагдсан аврах сүхээр тоноглогдсон байна.



(с) 60-аас дээш зорчигчийн суудалтай агаарын хөлөг дараах шаардлагыг хангасан зайгаар ажилладаг зөөврийн чанга яригчаар тоногдсон байна:

(1) зорчигчдыг яаралтай гаргахаар томилогдсон агаарын хөлгийн үйлчлэгчийн суудалд ойр, авч ажиллуулахад хялбар дөхөмтэй байх;

(2) хүснэгт 9-д заасны дагуу байрлуулсан байх.

(д) Энэ зүйлийн (а)-гийн (2) болон (с)-д заасан төхөөрөмжүүд нь тэдгээрийг ажиллуулах аргачлалыг заасан зааварчилгатай байна.

(е) Энэ зүйлийн (а)-д заасан хэрэглэлийг тусгай саванд хийж, жагсаалтыг тэмдэглэсэн байна.

(ф) Энэ зүйлийн (с)-ийн заалт нь зорчигчийн аль нэгэн тасалгааг ачаа тээвэрлэх зорилгоор бүхэлд нь өөрчилж, зөвхөн ачаа тээвэрлэх үед үл хамаарна.

### **Хүснэгт 7. Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл**

<i>Зорчигчийн</i>	<i>Анхны тусламжийн хэрэгслийн тоо</i>
1 -ээс 100	1
101 -ээс 200	2
201 -ээс 300	3
301 -ээс 400	4
401 -ээс 500	5
501 -ээс 600	6
601 -ээс дээш	7

### **Хүснэгт 8. Зөөврийн гал унтраагч**

<b>Байрлал</b>	<b>Тоо</b>
Багийн гишүүд хэрэглэхэд хялбар А, В, Е карго тасалгаа бүрийн орох хэсэгт	1
Нислэгийн бүхээгт эсхүл түүний ойролцоо нисэх багийн гишүүд хэрэглэхэд хялбар байрлалд	1
Гал тогооны тасалгаанд (galley)	1
Зорчигчийн тасалгаа бүрийн гал тогоонд (galley) хэрэглэхэд хялбар	1
<b>Зорчигчийн тоо</b>	
1-ээс 30	1
31-ээс 60	2
61-ээс 200	3
201-ээс 300	4
301-ээс 400	5
401-ээс 500	6
501-ээс 600	7
601-ээс дээш	8

**Хүснэгт 9. Чанга яригч**

Суудлын багтаамж	Хуваарилалт	
	Урд талд	Ард талд
61–ээс 99		1
100 буюу түүнээс дээш	1	1

**91.525. Усан дээгүүрх нислэг**

(a) Усан дээгүүр нисэх агаарын хөлөгт дараах тохиолдолд хүн бүрт суудлаасаа авч хэрэглэх боломжтой аврах хантааз байрлуулсан байна:

- (1) нэг хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд хөдөлгүүр татгалзсны дараа агаарын хөлөг өөрөө гулган эрэгт хүрэх зайнаас хол зайд нислэг үйлдэх бол; эсхүл
- (2) олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд нэг хөдөлгүүр татгалзсны дараа далайн төвшнээс дээш 300 м (1000 ft) өндрийг хадгалах боломжгүй болон агаарын хөлөг өөрөө гулган эрэгт хүрэх зайнаас хол зайд нислэг үйлдэх бол; эсхүл
- (3) олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд нэг хөдөлгүүр татгалзсны дараа далайн төвшнээс дээш 300 м (1000 ft) өндрийг хадгалж, эргээс 90 км-ээс (50 nm) цааш зайд нислэг үйлдэх бол.

(b) Нэг эсхүл олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд, нэг хөдөлгүүр татгалзсны дараа далайн төвшнээс дээш 300 м /1000 ft/ өндрийг хадгалах боломжгүй болон эргээс 185 км-ээс (100 nm) алс зайд нислэг үйлдэх бол дараах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- (1) тухайн агаарын хөлгөөр зорчиж буй бүх хүмүүсийг багтаан хөвөх чадвартай аврах завь /хангалттай хэмжээгээр/;
- (2) аврах хантааз бүр дээр байрлал тодорхойлох гэрэл;
- (3) тухайн маршрутад тохирох завь бүрт суурилуулсан авран туслах хэрэгслүүд (survival kit);
- (4) завь тус бүрт нэгээс доошгүй гялалзсан дохионы хэрэгсэл;
- (5) ослын үед байрлал дамжуулагч / ELT/ нэг эсхүл EPIRB нэг.

(c) Олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд нэг эсхүл түүнээс дээш хөдөлгүүр татгалзсны дараа нислэгээ цааш үргэлжлүүлэх боломжтой болон эргээс 370 км-ээс (200 nm) алс зайд нислэг үйлдэх тохиолдолд энэ зүйлийн (b)-д заасан төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

(d) Эргээс 370 км-ээс (200 nm) цааш зайд нисэх 5700 кг-аас илүү хөөрөлтийн жинтэй агаарын хөлөгт энэ зүйлийн (b)-д заасан тоноглол болон нэмэлт ELT эсхүл EPIRB тоногдсон байна.

(e) Усан дээгүүр нисэх агаарын бөмбөлгийн хувьд дараах тохиолдолд хүн бүрт хэрэглэх боломжтой аврах хантааз байрлуулсан байна:

- (1) тухайн нислэг аливаа нуур, тэнгисийн эрэг орчим эсхүл түүн дээгүүр нисэх бол; эсхүл
- (2) тухайн нислэгийн хөөрөх болон ойртолтын зам нь усан дээгүүр байгаад аливаа золгүй явдлаас болж усан дээр бууж болзошгүй тохиолдолд; эсхүл
- (3) аливаа нуур, тэнгисээс 1 н.м-ийн дотор хөөрөх болон тухайн эрэг дээрх салхи 3 м/с (5knots) их байх үед.

(f) Энэ зүйлийн (a)-аас (e)-д заасан аврах завь, хантааз болон дохионы хэрэгслүүдийг нүдэнд харагдах газар байрлуулж, усан дээр ослын буулт хийх үед тэдгээрийг хэрэглэхэд бэлэн байх ёстой.

#### **91.527 Усан дээрх үйл ажиллагаа**

Усан дээр үйл ажиллагаа явуулах аливаа агаарын хөлөг дараах зүйлсээр тоноглогдсон байна:

- (1) хүн бүрт суудлаасаа авч хэрэглэх боломжтой аврах хантааз;
- (2) 5700 кг-аас илүү хөөрөлтийн жинтэй агаарын хөлөг бүрт нэг зангуу.

#### **91.529. Ослын байршил дамжуулагч /ELT/**

(a) ИНД-121.353-ийн (b), ИНД-129.109 болон энэ зүйлийн (b), (г), (e)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг бүрт автомат ELT-ийг суурилуулсан байна.

(b) Зорчигч тээвэрлээгүй тохиолдолд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны үндсэн байрлалаас, автомат ELT суурилуулах газар руу ELT-гүй нислэг үйлдэж болно.

(c) 91.501-ийн (4) болон энэ зүйлийн (a)-д заасан заалтыг үл харгалзан дараах тохиолдолд автомат ELT ажиллагаагүй байж болно:

- (1) ажиллагаагүй ELT-ийг засварлах эсхүл солих боломжгүй тухайн байрлаж буй газраас засварлах, солих боломжтой газар руу нислэг үйлдэх бол;
- (2) зорчигч тээвэрлээгүй бол.

(d) 91.501-ийн (4) болон энэ зүйлийн (а)-д заасан заалтыг үл харгалзан тухайн агаарын хөлөгт буй аливаа этгээд хэрэглэх боломжтой ELT эсхүл PLB байрлуулсан бол 7 хоногоос ихгүй хугацаанд автомат ELT-гүй нислэг үйлдэж болно.

(е) Энэ зүйлийн (а)-д заасан зүйл дараах агаарын хөлөгт хамаарахгүй:

- (1) 1-ээс илүүгүй суудалтай агаарын хөлгийн нисгэгч нь ELT, эсхүл PLB-тэй бол:
- (2) планер болон хэт хөнгөн агаарын хөлгийн 1-ээс доошгүй зорчигч нь ELT, эсхүл PLB-тэй бол:
- (3) планер, хөдөлгүүрт агаарын хөлөг эсхүл хэт хөнгөн агаарын хөлөг нь 2-оос илүүгүй суудалтай, хөөрөх аэродромоос 28 км (10nm)-ийн дотогш нислэг үйлдэх бол:
- (4) нисгэгчтэй чөлөөт агаарын бөмбөлөг.

(f) Монгол улсад бүртгэлтэй агаарын хөлөгт суурилуулсан 406 Мгц -ийн автомат ELT, эсхүл авч явах ELT, EPIRB, PLB нь дор заасны дагуу кодлогдоогүй бол тухайн агаарын хөлгөөр Монгол улсад нислэг үйлдэхгүй:

- (1) автомат ELT-ийн хувьд улсын Олон улсын цахилгаан холбооны нийгэмлэгээс Монгол улсад өгсөн код болон дараах зүйлсийн аль нэг:
  - (i) ELT - ийн серийн дугаар:
  - (ii) агаарын хөлгийн 24 bit-ийн хаяг:
  - (iii) тухайн тээвэрлэгчийн ICAO-гоос өгөгдсөн заагч болон тухайн Ашиглагчид өгөгдсөн серийн дугаар:
  - (iv) агаарын хөлгийн улсын бүртгэлийн дугаар;
- (2) EPIRB эсхүл PLB-ийн хувьд:
  - (i) Олон улсын цахилгаан холбооны нийгэмлэгээс Монгол улсад өгсөн код;
  - (ii) тухайн EPIRB эсхүл PLB-ийг тодорхойлох онцгой код;
- (3) бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч дараах мэдээллийг авран хайх төв (онцгой байдлын ерөнхий газар) мэдэгдэнэ:
  - (i) тухайн онгоцонд суурилуулсан эсхүл авч явж буй ELT, EPIRB, PLB-ийн энэ зүйлийн (е)-ийн (1) эсхүл (2)-т заасан код;
  - (ii) Ашиглагчийн онцгой тохиолдолд холбогдох хүмүүсийн нэрс болон утас.

(g) Гадаад Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт суурилуулсан 406 Мгц -ийн автомат ELT, эсхүл авч явах ELT, EPIRB, PLB нь дор заасны дагуу кодлогдоогүй бол тухайн агаарын хөлгөөр Монгол улсад нислэг үйлдэхгүй:

- (1) автомат ELT-ийн хувьд улсын Олон улсын цахилгаан холбооны нийгэмлэгээс Монгол улсад өгсөн код болон дараах зүйлсийн аль нэг:
  - (i) ELT - ийн серийн дугаар:
  - (ii) агаарын хөлгийн 24 bit-ийн хаяг:
  - (iii) тухайн тээвэрлэгчийн ICAO-гоос өгөгдсөн заагч болон тухайн Ашиглагчид өгөгдсөн серийн дугаар:
  - (iv) агаарын хөлгийн улсын бүртгэлийн дугаар.

### **91.531. Хүчилтөрөгчийг заах хэрэгсэл**

Далайн төвшнээс дээш 3900 м /13000 ft/-ээс дээш өндөрт, эсхүл 3000-3900 м /10000-13000ft/-ийн хооронд 30 минутаас дээш хугацаагаар нислэг үйлдэх агаарын хөлөг бүрийг дараах хэрэгслээр тоноглогсон байна:

- (1) нисэх багийн гишүүдэд:
  - (i) хүчилтөрөгчөөр хангагч нь хангалттай хэмжээний хүчилтөрөгчтэй болон зохих хэсэгт хүчилтөрөгч хуваарилагдаж буй эсэхийг заагчтай;
  - (ii) битүүмжлэл бүхий агаарын хөлгийн бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь далайн төвшнээс дээш 3000 м /10000 ft/-ээс их болсон үед дуун болон харагдах анхааруулах төхөөрөмж;
- (2) хүчилтөрөгч хэрэглэгч тус бүрт хангалттай хэмжээний хүчилтөрөгч байгаа болон хуваарилах хэсэгт хүчилтөрөгч очиж буй эсэхийг шалгагч заагчтай.

### **91.533. Битүүмжлэлгүй агаарын хөлгийн нэмэлт хүчилтөрөгч**

(a) Далайн төвшнээс дээш 3000 м-ээс (10000 ft) дээш өндөрт нисэх, битүүмжлэлгүй агаарын хөлөг дараах хэрэгслээр тоноглогдсон байна:

- (1) 3900м /13000 ft/ хүртэлх өндөрт:
  - (i) 30 минутаас дээш хугацаанд багийн бүх гишүүд болон зорчигчийн 10%-ийг байнга хангах нэмэлт хүчилтөрөгч;
  - (ii) зорчигчийн 3-аас доошгүй хувь нь тогтмол хэрэглэхүйц эмчилгээний хүчилтөрөгч;
- (2) далайн төвшнээс дээш 3900м-7600м /13000ft-25000ft/-ийн хоорондох өндөрт:
  - (i) багийн бүх гишүүд болон зорчигчид тогтмол хэрэглэх нэмэлт хүчилтөрөгч;
  - (ii) зорчигчийн 1-ээс доошгүй хувь нь тогтмол хэрэглэх эмчилгээний хүчилтөрөгч;

- (iii) бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр 3000 м-ээс (10000 ft) хэтрэх үед байнга хэрэглэх боломжтой 120 л-ээс багагүй хүчилтөрөгч агуулсан зөөврийн төхөөрөмж.

(b) Эмчилгээний хүчилтөрөгчийг нэмэлт хүчилтөрөгчтэй ижил хэмжээгээр эсхүл нэмэлт хүчилтөрөгчийг эмчилгээний хүчилтөрөгчтэй ижил хэмжээгээр орлуулснаар энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг хангаж болно.

### **91.535. Битүүмжлэл бүхий агаарын хөлгийн нэмэлт хүчилтөрөгч**

#### **Далайн дундаж төвшнөөс дээш 3000 м-7600 м /10000 ft - 25000 ft/-ийн өндөрт үйлдэх нислэг**

(a) Далайн дундаж төвшнөөс дээш 3000 м-7600 м /10000 ft-25000 ft/-ийн өндөрт нислэг үйлдэх, битүүмжлэлтэй агаарын хөлөг дараах хэрэгслээр тоноглогдсон байна:

- (1) даралтын системд гэмтэл гарсны улмаас бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр 3000 м-ээс (10000 ft) хэтрэх үед нисэх багийн гишүүд бүрийн суудалд ойр авч хэрэглэхэд хялбар нэмэлт хүчилтөрөгчөөр тасралтгүй хангаж чадах, нисэх багийн гишүүд шаардлагатай үе хэрэглэх хүчилтөрөгчийн баг;
- (2) агаарын хөлгийн үйлчлэгчийн суудалд ойр авч хэрэглэхэд хялбар дараах төхөөрөмж:
  - (i) зорчигчийн хүчилтөрөгчийн баг;
  - (ii) бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр 3000 м-ээс (10000 ft) хэтрэх үед байнга хэрэглэх боломжтой 120 л-ээс багагүй хүчилтөрөгч агуулсан зөөврийн төхөөрөмж;
- (3) байрлал хамаарахгүйгээр, багийн бүх гишүүдийг хүчилтөрөгчөөр яаралтай хангах хангалттай тооны нөөц хүчилтөрөгчийн баг эсхүл зөөврийн төхөөрөмж;
- (4) энэ зүйлийн (b)-д хамааралтайгаар, нэмэлт хүчилтөрөгчийн хамгийн бага хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байна:
  - (i) нисэх багийн гишүүд бүрийг 45 минутын хугацаанд хангах;
  - (ii) агаарын хөлгийн үйлчлэгч болон зорчигч бүрийг 12 минутын хугацаанд хангах;
- (5) энэ зүйлийн (b)-д хамааралтайгаар, дараах тохиолдолд нэмэлт, эсхүл эмчилгээний хүчилтөрөгч шаардаж болно:
  - (i) хэрэв тухайн агаарын хөлөг 4 минутанд далайн дундаж төвшнөөс дээш 4200 м (14000 ft)-ээс доош өндөр алдах боломжтой бол, бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь далайн дундаж

төвшнөөс дээш 10000 ft (3000 м)-ээс их байх бүх үед зорчигчийн 10%-ийг хангах хүчилтөрөгч:

- (ii) хэрэв агаарын хөлөг нь 4 минутын хугацаанд далайн дундаж төвшнөөс дээш 4200 м (14000 ft)-ээс доош өндөр алдаж чадахгүй бол, бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь далайн дундаж төвшнөөс дээш 4200 м (14000 ft)-ээс их байх үед бүх зорчигчийг хангах хүчилтөрөгч:
- (iii) зорчигчдын 10 хувийг 30 минутын хугацаанд хангах хүчилтөрөгч:
- (iv) зорчигчдын 1 хувийг тогтмол хангах хүчилтөрөгч.

(b) Битүүмжлэлийн системд гэмтэл гарсан тохиолдолд энэ зүйлийн (a)-ийн (4) болон (5)-д заасан хүчилтөрөгчийн хэмжээг тооцоолохдоо дараах зүйлсийг харгалзан үзнэ:

- (1) онцгой тохиолдлын үед яаралтай өндөр алдан, аюулгүй өндөрт шулуун нислэгт орох шаардлагатай хугацаа;
- (2) буухаас өмнөх үе шатанд даралтын өндрөөр 3000 м (10000 ft)-ээс дээш нисэх бол энэхүү хугацаа.

**Далайн дундаж төвшнөөс дээш 7600 м-9100 м /25000 ft - 30000 ft/-ийн өндөрт үйлдэх нислэг**

(c) Далайн дундаж төвшнөөс дээш 7600 м-9100 м (25000 ft-30000 ft)-ийн өндөрт нислэг үйлдэх, битүүмжлэлтэй агаарын хөлөг энэ зүйлийн (a)-д заасан болон дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- (1) нисэх багийн гишүүд бүрийн суудалд ойр авч хэрэглэхэд хялбар нэмэлт хүчилтөрөгчөөр тасралтгүй хангаж чадах, нисэх багийн гишүүд шаардлагатай үе хэрэглэх хүчилтөрөгчийн баг ;
- (2) дараах гишүүдийг нэмэлт хүчилтөрөгчөөр хангах хүчилтөрөгчийн баг:
  - (i) агаарын хөлгийн үйлчлэгч болон бүх зорчигчийг;
  - (ii) угаалгын болон ариун цэврийн тусгаарлагдсан өрөө бүрийг;
- (3) энэ зүйлийн (a)-ийн 5.3-т заасан хүчилтөрөгчөөс гадна зорчигчдын 10 хувийг 15 минутаас багагүй хугацаанд хангах эмчилгээний хүчилтөрөгч.

**Далайн дундаж төвшнөөс дээш 9100 м (30000 ft)-ийн өндөрт үйлдэх нислэг**

(d) Далайн дундаж төвшнөөс дээш 9100 м (30000 ft)-ээс дээш өндөрт нислэг үйлдэх, битүүмжлэлтэй агаарын хөлөг энэ зүйлийн (a), (c)-д заасан болон дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- (1) зорчигчийн бүхээг, угаалгын болон ариун цэврийн өрөөний хүчилтөрөгчийн багуудын нийт тоо нь зорчигчийн суудлын тооноос хамгийн багадаа 10%-иар илүү байна:

- (2) нэмэгдэл хүчилтөрөгч агаарын хөлөгт жигд байрлуулна:
- (3) бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь 4200 м (14000 ft)-ээс илүү болох үед, зорчигчдийн бүхээг дэх агаарын хөлгийн үйлчлэгч болон зорчигчдын хүчилтөрөгчийн баг автоматаар бууна:
- (4) автомат систем гэмтсэн тохиолдолд хүчилтөрөгчийн багийг гар ажиллагаагаар буулгахад шаардлагатай хэрэгслээр нисэх багийн гишүүд тоноглогдсон байна.

#### **91.537. Ажиллагаагүй хэрэглэл болон тоног төхөөрөмж**

(a) Дараах тохиолдолд ажиллагаагүй хэрэглэл эсхүл тоног төхөөрөмж суурилуулсан агаарын хөлгөөр нислэг үйлдэж болно:

- (1) 91.539-д заасны дагуу тухайн агаарын хөлгийн MEL-д зөвшөөрсөн бол;
- (2) ИНД-43-ын дагуу ажиллагаагүй байж болох хэрэглэл эсхүл тоноглолтой агаарын хөлгийг нислэгт гаргахыг (release-to-service) зөвшөөрсөн бол;
- (3) тухайн агаарын хөлөг MEL-д заасан бүх нөхцөл, хязгаарлалтын дагуу нислэг үйлдэх бол.

(b) Дараах тохиолдолд ажиллагаагүй хэрэглэл болон төхөөрөмжтэйгээр тухайн агаарын хөлгийн хөөрөлтийн нийт жин нь 5700 кг-аас ихгүй бөгөөд 91.539-д заасан MEL-гүй бол нислэг үйлдэж болно:

- (1) ажиллагаагүй хэрэглэл болон төхөөрөмж нь:
  - (i) тухайн агаарын хөлгийн маягийн гэрчилгээний дагуу НТЧ-ын холбогдох шаардлагад нийцсэн, өдрийн цагт ИХНД-ээр нисэхэд шаардагдах хэрэглэл, төхөөрөмж биш бол;
  - (ii) энэ бүлгийн дагуу тодорхой үйл ажиллагаанд шаардлагатай биш бол;
  - (iii) НТЧ-ын удирдамж (AD)-ийн дагуу ажиллагаатай байх нөхцөл шаардаагүй бол;
- (2) ИНД-43.107-ын дагуу ажиллагаагүй хэрэглэл эсхүл тоноглолтой агаарын хөлгийг техник үйлчилгээнээс гаргахыг зөвшөөрсөн бол.

(c) Энэ дүрмийн (a) эсхүл (b)-д заасан шаардлагыг хангаагүй агаарын хөлөг ИНД-21-ийн И бүлгийн дагуу *тусгай нислэгийн зөвшөөрөлтэй* бол тухайн агаарын хөлгөөр нислэг үйлдэж болно.

#### **91.539. MEL-ийг батлах**

(a) MEL батлуулахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын холбогдох маягтыг бөглөн өргөдлийн хураамжийн хамт Даргад ирүүлнэ.



(b) MEL-д дараах зүйлсийг багтаасан байна:

- (1) ашиглах агаарын хөлгийн маяг, загвар;
- (2) хэсэгчлэн эсхүл огт ажиллагаагүй үед ашиглаж болох хэрэглэл болон тоног төхөөрөмжийн дараах жагсаалт:
  - (i) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс баталсан; эсхүл
  - (ii) тухайн агаарын хөлөгт маягийн гэрчилгээ олгосон Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас баталсан; эсхүл
  - (iii) Дарга тухайн агаарын хөлгийн ажиллагаагүй хэрэглэл болон тоног төхөөрөмж нь агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэж хүлээн зөвшөөрсөн.

(c) MEL-д дараах тоног төхөөрөмжийг багтаахгүй:

- (1) агаарын хөлгийн маягийн гэрчилгээний дагуу НТЧ-ын шаардлагад тусгайлан шаардаж буй төхөөрөмж; эсхүл
- (2) энэ бүлгийн дагуу тодорхой үйл ажиллагаанд шаардагдах төхөөрөмж; эсхүл
- (3) НТЧ-ын удирдамж (AD)-ын дагуу ажиллаж байх шаардлагатай төхөөрөмж.

(d) Дарга нисэхийн аюулгүй ажиллагааны үүднээс зайлшгүй гэж үзвэл MEL-д тавих хязгаарлалт, нөхцлүүдийг тодорхой зааж өгч болно.

#### **91.541. Автомат хариулагч болон өндөр мэдээлэх төхөөрөмж**

(a) 91.247-ийн (c) болон (e)-д зааснаас бусад тохиолдолд, ИНД-71-т заасны дагуу автомат хариулагчи шаардлагатай агаарын зайд нисэх агаарын хөлөг дараах автомат хариулагчаар тоноглогдсон байна:

- (1) НХУ-аас онцлон заасан кодонд (3)А горимд хариулах хүчин чадалтай (3)А 4096 автомат хариулагч;
- (2) 30 м (100 ft)-ийн нарийвчлалттай нислэгийн өндрийг дамжуулж, С горимд хариулах хүчин чадалтай С горимд ажиллах автомат хариулагч.

(b) S горимд ажиллах чадвартай автомат хариулагчаар тоноглогдсон агаарын хөлгийн автомат хариулагч нь дараах зүйлст хариулах чадвартай байна:

- (1) НХУ-аас заасан кодыг дамжуулж (3)А горимд хариулах;
- (2) завсрын горим;
- (3) S горимд хариулагч.

**91.543. Тийрэлтэт хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн өндөр дохиологч систем ба төхөөрөмж**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд тийрэлтэт хөдөлгүүрт агаарын хөлөг бүр өндрийг дохиологч дараах систем, эсхүл төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- (1) өндөр авах эсхүл өндөр алдах аль ч үед, урьдчилан сонгосон өндөрт ойртох үед нисгэгчид дохио өгөх дараах төхөөрөмж:
  - (i) хангалттай хугацааны өмнө, урьдчилан сонгосон өндөрт чиг шулуун нислэгийг тогтоох сонсогдох эсхүл харагдах дохиолол өгөх; эсхүл
  - (ii) хангалттай хугацааны өмнө, урьдчилан сонгосон өндөрт чиг шулуун нислэгийг тогтоох сонсогдох эсхүл харагдах дохиолол өгөх бөгөөд урьдчилан сонгосон өндрөөс дээш, эсхүл доош өөрчлөлт гарах үед дуут дохиолол өгөх;
- (2) тухайн онгоцонд далайн төвшнөөс дээш зөвшөөрөгдсөн хамгийн их өндөр хүртэл шаардлагатай дохио өгөх;
- (3) урьдчилан сонгосон өндрийн өсөлтийг тухайн онгоц нисэх өндөрт зохицуулан ашиглах боломж олгосон байх;
- (4) дохиологчийн зохистой ажиллагааг тусгай төхөөрөмжгүйгээр шалгалт (test) хийн тодорхойлж болохуйц (may be tested);
- (5) уг систем эсхүл төхөөрөмж барометрийн даралтаар ажиллах боломжтой бол, барометрийн даралтын тохируулгатай байх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан зүйлс нь дараах үйл ажиллагаанд хамаарахгүй:

- (1) НТЧ-ын хязгаарлагдмал (restricted) эсхүл тусгай гэрчилгээтэй онгоцны нислэгийн үйл ажиллагаа; эсхүл
- (2) дараах зорилгоор ашиглах онгоцны нислэгийн үйл ажиллагаа:
  - (i) шинээр авсан онгоцыг түүний үндсэн байрлалаас өндөр дохиолох систем, эсхүл төхөөрөмж суурилуулах байрлал руу нисгэх; эсхүл
  - (ii) тухайн агаарын хөлгийн НТЧ-ыг шалгах нислэг явуулах; эсхүл
  - (iii) тухайн агаарын хөлгийг гадаад улсад бүртгүүлэхээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс нисгэх; эсхүл
  - (iv) тухайн агаарын хөлгийг худалдах зорилгоор үзүүлэх нислэг үйлдэх; эсхүл
  - (v) тухайн агаарын хөлгийг гадаад улсад бүртгүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрээс нисгэхээс өмнө уг нислэгт оролцох гадаадын нисэх багийн сургалтын нислэг үйлдэх.

### **91.545. Тогтоосон өндрийг заагч**

(а) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, ХНД-ээр нислэг үйлдэх онгоц өндөр дохиолох систем, төхөөрөмжөөр тоноглогдоогүй бол, түүнийг НХУ-аас тогтоосон өндрийг заах хэрэглэлээр тоноглогсон байна.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан өндөр заах хэрэгсэл нь:

- (1) аль ч нисгэгчийн суудлаас тохируулгыг хялбар хийж болох байрлалд байна;
- (2) тогтоосон өндрийг хянах үүрэг бүхий нисэх багийн бүх гишүүдэд хэрэглэл, дэлгэц дээр тодорхой харагдахаар байна;
- (3) урьдчилан сонгосон өндрийн өсөлтийг тухайн онгоц нисэх өндөрт зохицуулан ашиглах боломж олгосон байна.

(с) *Тусгай ангилал-үзүүлбэр эсхүл тусгай ангилал-хязгаарлагдмал* НТЧ-ын гэрчилгээтэй онгоцноос өндрийг заах хэрэглэл шаардахгүй.

### **91.547 Гадагшлуулах суудал болон тэсрэх төхөөрөмж**

Тэсрэх төхөөрөмжийг гадагшлуулах суудал эсхүл агаарын хөлгөөс гаргах төхөөрөмж нь 91.501-ийн 2-т заасан тусгай ангиллын НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт хамаарна.

## **Ж Бүлэг. Техник үйлчилгээнд тавигдах шаардлага**

### **91.601. Үйлчлэх хүрээ**

(а) Энэ бүлгээр Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад болон гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй агаарын хөлгийн техник үйлчилгээнд тавигдах шаардлагыг тогтооно.

(б) Энэ бүлгийн дараах шаардлагууд нь ИНД-103-т заасан хэт хөнгөн агаарын хөлөгт хамаарахгүй:

- (1) 91.605-ийн (е)-ийн (2) (хэт хөнгөн агаарын SSR автомат хариулагчтай бол автомат өндрийн даралт мэдээлэгч системийн үзлэг, шалгалт):
- (2) 91.605-ийн (е)-ийн (3) (SSR автомат хариулагч):
- (3) 91.605-ийн (е)-ийн 8/ (хөвөгч төхөөрөмж):
- (4) 91.616 (техник үйлчилгээний дэвтэр - ангилал 2 хэт хөнгөн агаарын хөлөг):
- (5) 91.617 (техник үйлчилгээний бүртгэл - ангилал 2 хэт хөнгөн агаарын хөлөг):
- (6) 91.621 (техник үйлчилгээний бүртгэл шилжүүлэх):
- (7) 91.623 (бүртгэл хадгалах).

(с) Энэ бүлгийн дараах шаардлагууд нь ИНД-104-т заасан планерт хамаарахгүй:

- (1) 91.605-ийн (е) (хэрэглэл болон тоног төхөөрөмжийн техник үйлчилгээ):
- (2) 91.613 (үйл ажиллагааны нислэгийн шалгалт):
- (3) 91.615 (НТЧ-ын жил бүрийн үзлэг):
- (4) 91.616 (техник үйлчилгээний дэвтэр):
- (5) 91.617 (техник үйлчилгээний бүртгэл):
- (6) 91.621 (техник үйлчилгээний бүртгэл шилжүүлэх):
- (7) 91.623 (бүртгэл хадгалах).

### **91.602 Нислэгийн өмнөх техник үйлчилгээний шаардлага**

(а) Энэр зүйлийн (b) болон 91.611-д зааснаас бусад тохиолдолд, 91.603, 91.605, 91.615-д заасан шаардлагуудыг биелүүлээгүй аливаа этгээд агаарын хөлөг ашиглахгүй.

(b) Энэ бүлгийн (а) заалт нь ИНД-21-ийн дагуу агаарын хөлөг ашиглах *тусгай нислэгийн зөвшөөрөлтэй* этгээдэд хамаарахгүй.

### **91.603. Техник үйлчилгээний ерөнхий шаардлагууд**

(а) Ашиглагч дараах зүйлсийг бататгана:

- (1) агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалагдаж буйг;
- (2) ИНД-39-д заасан шаардлагын дагуу холбогдох бүх НТЧ-ын удирдамж (AD) мөрдөгдөж буйг;
- (3) энэ бүлэгт заасны дагуу агаарын хөлөг шалгагдаж буйг;
- (4) 91.537-д заасан ажиллагаагүй ашиглаж болох хэрэглэл болон тоног төхөөрөмж биш бол нислэгийн өмнө аливаа дутагдал засагдаж буйг;
- (5) 91.537-д заасан ажиллагаагүй ашиглаж болох аливаа хэрэглэл, эд анги, тоног төхөөрөмжийг тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу хийгдэх дараагийн үзлэг, шалгалтын үеэр зассан, сольсон, буулгасан эсхүл үзлэг шалгалт хийгдэж буйг;
- (6) агаарын хөлгийн техник үйлчилгээ ИНД-43, энэ дүрмийн дагуу болон холбогдох бусад дүрэмд заасны дагуу хийгдэж буйг;
- (7) агаарын хөлөгт хийгдсэн аливаа техник үйлчилгээний дараа ИНД-43-ын шаардлагын дагуу нислэгт гаргах (release-to-service) баталгаажилт хийгдэж буйг;

(8) энэ бүлгийн Е бүлэгт шаардсан агаарын хөлгийн бүхээгт нүүрсхүчлийн хэт исэл буйг илрүүлэн заагч систем бүр ажиллагаатай болон дуусах хугацаа хэтрээгүйг баталгаажуулж буйг.

(b) Үйлдвэрлэгч улсын НТЧ-ын хариуцсан байгууллагаас гаргасан НТЧ-ын хязгаарлалтыг дагаж мөрдөж буйг тухайн Ашиглагч бататгана.

(c) Энэ зүйлийн (г), (е) болон (е)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн Ашиглагч дараах зүйлсийг бататгана:

(1) үйлдвэрлэгчээс тогтоосон их засварыг (overhaul) хугацаанд нь хийгдэж буйг;

(2) *тусгай ангилал – үзүүлбэрийн (exhibition)* НТЧ-ын гэрчилгээ эсхүл *тусгай ангилал – хязгаарлагдмал* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгийн хувьд техник үйлчилгээний хөтөлбөрт заасан хугацаат эд ангиудыг сольж буйг.

(d) ИНД-119, ИНД-115-ийн дагуу батлагдсан, эсхүл 91.607-гийн дагуу баталсан техник үйлчилгээний хөтөлбөрт их засвар хийгдэх хугацааг уртасгах журамтай бол үйлдвэрлэгчээс тогтоосон их засварын хоорондох хугацаанд тавигдах техник үйлчилгээний шаардлагаас аливаа эд ангийг цааш ашиглаж болно.

(e) Энэ зүйлийн (г)-г үл харгалзан, поршинт хөдөлгүүрт онгоц урамшуулал, эсхүл хөлсөөр нислэг үйлдээгүй болон Дарга зөвшөөрсөн их засвар хийгдэх хугацааг уртасгасан хөтөлбөрийн дагуу хөдөлгүүрийн техник үйлчилгээ хийгдэж буй бол үйлдвэрлэгчээс тогтоосон их засварын хоорондох хугацаанд тавигдах техник үйлчилгээний шаардлагаас цааш ашиглаж болно.

(f) Энэ зүйлийн (г)-г үл харгалзан, сэнст онгоц агаарын тээвэрт (air operations) нислэг үйлдээгүй болон Дарга зөвшөөрсөн аргачлалын дагуу 5 жилийн завсартай сэнсэнд үзлэг хийгдэж, мөн үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу сэнсэнд их засвар хийгдэх хугацаа (hours) заагаагүй бол үйлдвэрлэгчээс тогтоосон их засварын хоорондох хугацаанд тавигдах шаардлагаас цааш ашиглаж болно.

#### **91.605. Техник үйлчилгээний хөтөлбөр ба төлөвлөгөө**

(a) Энэ зүйлийн (b), (c), болон (г)-д хамааралтайгаар, Ашиглагч, агаарын хөлгийн техник үйлчилгээг дараах зүйлсийн дагуу гүйцэтгэнэ:

(1) ИНД-115-ийн хүрээнд батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу; эсхүл

(2) ИНД-119-ийн хүрээнд батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу; эсхүл

(3) 91.607-ийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу; эсхүл

- (4) үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний хуваарийн дагуу; эсхүл
- (5) поршинт хөдөлгүүрт, хөөрөлтийн зөвшөөрөгдөх дээд жин нь 2730 кг-аас бага агаарын хөлөг бол, Дарга зөвшөөрсөн техник үйлчилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг багтаасан байна:
  - (i) холбогдох дүрмийн шаардлагын дагуу агаарын хөлгийн техник үйлчилгээний стандарт болон үүрэг хариуцлагыг тодорхойлсон;
  - (ii) нислэгийн өмнөх үзлэгийг дэлгэрэнгүй тодорхойлсон;
  - (iii) техник үйлчилгээний үзлэг, шалгалтын хуваарийг дэлгэрэнгүй тодорхойлсон.

(b) Ашиглагч нь:

- (1) ИНД-119-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч бол ИНД-119-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэнэ; эсхүл
- (2) ИНД-115-ийн дагуу сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч бол ИНД-115-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэнэ; эсхүл
- (3) тусгай ангилалын НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч бол 91.607-гийн дагуу батлагдсан агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээнд тусгасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэнэ.

(c) Хэрэв үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарь энэ зүйлийн (a)-гийн (4)-т заасны дагуу хийгдэх болон агаарын хөлгийн ашиглалт жилд 100 цаг хүрэхгүй бол Ашиглагч нь үйлдвэрлэгчийн 100 цагийн үзлэг, эсхүл түүнтэй адилтгах үзлэгийг 12 сар тутам хийж гүйцэтгэнэ.

(d) Хэрэв энэ зүйлийн (a)-гийн (4)-т заасан, үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний хуваарийг хангалтгүй гэж үзвэл Дарга тухайн Ашиглагчийг 91.607-ийн дагуу техник үйлчилгээний хөтөлбөрийг батлуулахаар ирүүлэхийг шаардаж болно.

(e) Ашиглагч нь 91.611 болон энэ зүйлийн (e)-д зааснаас бусад дараах тохиолдолд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- (1) энэ дүрмийн E бүлгийн дагуу суурилуулсан ХНД-н нислэгт ашиглах холбооны төхөөрөмж нь ИНД-43-ын Хавсралт Б-ийн дагуу 24 сар тутмын үзлэг хийгдээгүй бол;
- (2) агаарын хөлөгт суурьлуулсан автомат хариулагч эсхүл энэ дүрмийн E бүлгийн дагуу суурилуулсан статик даралтын систем, өндөр хэмжигч,

өндөр мэдээлэх төхөөрөмж нь ИНД-43-ын Хавсралт Г-ийн дагуу дараах шаардлагад нийцүүлэн шалгаж баталгаажуулаагүй бол:

- (i) 24 сар тутамд;
  - (ii) нөөц статик даралтын системийн цоргыг юүлэхээс бусад статик даралтын системийг задалж угсарсны дараа;
  - (iii) автомат хариулагч системд техник үйлчилгээ хийсэн эсхүл шинээр суурилуулсны дараа;
- (3) энэ дүрмийн Е бүлгийн дагуу суурилуулсан автомат хариулагч нь ИНД-43-ын Хавсралт Д-ийн дагуу 24 сар тутмын үзлэг, шалгалт хийгдэж баталгаажуулаагүй бол;
- (4) энэ дүрмийн Е бүлгийн дагуу суурилуулсан аливаа ослын байршил дамжуулагч (ELT) нь:
- (i) ИНД-43-ын Хавсралт Е-гийн дагуу 12 сар эсхүл агаарын хөлгийн нислэгийн 100 цагийн нислэг аль түрүүлж болсноор нь үзлэг, шалгалт хийгдэж баталгаажуулаагүй бол; эсхүл
  - (ii) 12 сараас ихгүй, тодорхой хуваарьтай, ИНД-119.63-ын дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу үзлэг, шалгалт хийгдэж баталгаажуулаагүй бол;
  - (iii) үйлдвэрлэгчээс гаргасан зааварчилгааны дагуу 24 сар тутамд шалгаагүй бол;
  - (iv) үйлдвэрлэгчээс гаргасан зааварчилгааны дагуу зай хураагуурын баталгаат хугацаа нь дуусахад солиогүй бол;
- (5) энэ дүрмийн Е бүлгийн дагуу суурилуулсан луужин бүрийг дараах шаардлагын дагуу тохируулна:
- (i) 24 сар тутамд;
  - (ii) үйлдвэрлэгч өөрөөр заагаагүй бол тохируулга хийх шаардлага гарсан тохиолдол бүрт;
- (6) энэ дүрмийн Е бүлгийн дагуу суурилуулсан эмнэлгийн анхны түргэн тусламжийн хэрэгслийг:
- (i) 12 сар тутамд зохих тоо хэмжээг нь шалгаж, хугацаа нь дуусах зүйлсийг сольж хийгээгүй бол;
  - (ii) ашигласан зүйлээ нөхөж хийгээгүй бол;
- (7) энэ дүрмийн Е бүлгийн дагуу суурилуулсан зөөврийн гал унтраагуурыг үйлдвэрлэгчээс гаргасан, эсхүл адилтгах Дарга хүлээн зөвшөөрсөн зааварчилгааны дагуу 12 сар тутам шалгаж баталгаажуулаагүй бол;

- (8) энэ дүрмийн Е бүлгийн дагуу суурилуулсан хөвөгч төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс гаргасан, эсхүл адилтгах ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн зааварчилгааны дагуу 12 сар тутам шалгаж баталгаажуулаагүй бол;
- (9) агаарын хөлгийн хийцийн жин болон төвлөрөлтийг дараах тохиолдолд дахин тодорхойлно:
- (i) агаарын хөлгийн хийцийн жин болон төвлөрөлтөд нөлөөлж болох өөрчлөлт хийгдсэн; эсхүл
  - (ii) нислэгийн зааварт буй мэдээллийн нарийвчлал алдагдсан байж болох сэжиг таамаг бий болсон бол; .
- (10) зөвшөөрөгдөх суудлын тоо 4 болон түүнээс дээш, хөдөлгүүрт агаарын хөлгийн хийцийн хоосон жинг 10 жилийн хугацаанд дахин тодорхойлоогүй бол.
- (f) Хэрэв Ашиглагч энэ зүйлийн (а)-гийн (1), эсхүл (2)-т заасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэхдээ энэ зүйлийн (е)-д заасан шаардлагатай ижил үзлэг шалгалт хийгдсэн бол, энэ зүйлийн (е)-д заасан заалтыг гүйцэтгэхгүй байж болно.
- (g) Ашиглагч дараах үүрэгтэй:
- (1) агаарын хөлөгт энэ зүйлийн (а)-д заасны дагуу техник үйлчилгээ хийгдсэнийг техник үйлчилгээний дэвтэрт тэмдэглэх;
  - (2) хэрэв Техник үйлчилгээний хөтөлбөр нь ИНД-119, эсхүл 91.607-гийн дагуу батлагдсан бол Техник үйлчилгээний хөтөлбөрт техник үйлчилгээний хуваарийг тусгасан эрх бүхий этгээдтэй байх;
  - (3) техник үйлчилгээний хөтөлбөрт, эсхүл энэ зүйлийн (ж)-гийн (1)-д заасан өөрчлөлтийг (а) заалтын өөр хөтөлбөрт сольж хийгдэх болбол агаарын хөлгийн НТЧ-ыг хадгалах зорилгоор шинээр хөтөлбөр, эсхүл хуваарь боловсруулсан байх;
  - (4) Дарга хүссэн үед, тухайн агаарын хөлөгт техник үйлчилгээ гүйцэтгэж буй этгээд холбогдох техник үйлчилгээний хөтөлбөр, эсхүл хуваарийн хуулбарыг хүргүүлсэн байх.
- (h) Дараах тохиолдолд, энэ зүйлийн (е)-ийн (1), (е)-ийн 2.1, (е)-ийн (3)-ийн үзлэг, шалгалт болон энэ зүйлийн (е)-ийн 4.1-т заасан 12 сар тутмын үзлэг, шалгалтыг гүйцэтгэх шаардлагагүй:
- (1) ИНД-21-ийн дагуу өмнөх 12 сард НТЧ-ын гэрчилгээ олгох үзлэг хийгдсэн бол;
  - (2) Холбогдох тоног төхөөрөмж суурилагдсны дараа энэ зүйлийн (1)-д заасан үзлэг хийгдсэн бол.



### 91.607. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах

(a) 91.605-ын (a)-гийн (2)-т заасан техник үйлчилгээний хөтөлбөр батлуулахаар хүсэлт гаргаж буй этгээд энэ зүйлийн (b)-д шаардсан баримт бичиг, өргөдлийн маяг, төлбөрийн баримтыг Даргад ирүүлнэ.

(b) Даргад ирүүлэх техник үйлчилгээний хөтөлбөрт дараах бичиг баримтыг багтаасан байна:

- (1) техник үйлчилгээний хөтөлбөрийн тайлбар;
- (2) техник үйлчилгээнд хяналт тавих журам;
- (3) техникийн лавлах материал болон бүртгэл, тайлангийн мэдээлэл цуглуулах, хадгалалтын журам;
- (4) шаардлагатай үзлэг, шалгалтыг багтаасан, тухайн агаарын хөлгийн маяг бүрт гүйцэтгэх техник үйлчилгээний заавар, журам;
- (5) дараах зүйлсийг харгалзан үзлэгийн хуваарийг гаргана:
  - (i) үйлвэрлэгчээс гаргасан зөвлөмж;
  - (ii) ашиглагчийн техник үйлчилгээ гүйцэтгэх дадал туршлага;
  - (iii) тухайн агаарын хөлгөөр үйлдэх нислэгийн үйл ажиллагааны төрөл;
- (6) үзлэг хоорондын хугацааг 91.611-ийн дагуу сунгах журам (шаардлагатай бол);
- (7) хөдөлгүүр, сэнсний эд ангийг их засварт орох үзлэг хоорондын хугацааг өөрчлөх журам (шаардлагатай бол);
- (8) хэрэв шаардлагатай бол техник үйлчилгээний дадлага туршлагын улмаас үзлэг хоорондын хугацааг өөрчлөх журам;
- (9) үзлэг шалгалтанд ашиглагдах загвар маягтууд;
- (10) үйл ажиллагаанд ашиглагдах загвар тайлан, бүртгэл.

(c) Дараах зүйлсийг хангасан гэж үзвэл Дарга өргөдөл гаргагчийн техник үйлчилгээний хөтөлбөрийг баталж болно:

- (1) энэ зүйлийн (b)-д заасан хөтөлбөрийн шаардлагыг;
- (2) нисэхийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэж үзвэл.

(d) *Тусгай ангилал – үзүүлбэр (exhibition)* эсхүл *тусгай ангилал – хязгаарлагдмал (limited)* НТЧ-ын гэрчилгээтэй техник үйлчилгээний хөтөлбөр батлуулахаар өргөдөл гаргагч энэ зүйлийн (b)-д заасан шаардлагаас гадна дор дурдсан зүйлсийг Даргад ирүүлнэ:

- (1) тухайн агаарын хөлгийн өдрийн эхний нислэгийн өмнөх үзлэгийн дэлгэрэнгүй;

- (2) үйлдвэрлэгч эсхүл цэргийн байгууллагаас шаардсан бол нислэгийн дараах үзлэгийн дэлгэрэнгүй;
- (3) жил тутмын техник үйлчилгээний үзлэгийн дэлгэрэнгүй;
- (4) хэрэв шаардлагатай бол, дараах этгээдүүдийн тодорхойлсон хугацаат эд ангиудыг солих хугацаа:
  - (i) агаарын хөлгийн үйлдвэрлэгч; эсхүл
  - (ii) Дарга хүлээн зөвшөөрсөн цэргийн байгууллага; эсхүл
  - (iii) Дарга;
- (5) НТЧ-ыг хангаж буйг бататгасан заалт;
- (6) дараах зүйлсийг харгалзсан нэмэлт үзлэг:
  - (i) үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу;
  - (ii) үйлчилгээ хийх дадал туршлага (үүнд: цэргийн үйл ажиллагааг оролцуулна);
  - (iii) тухайн агаарын хөлгөөр үйлдэх нислэгийн үйл ажиллагааны төрөл;
  - (iv) тухайн агаарын хөлгийн төвөгтэй байдал (complexity).

(e) Энэ зүйлийн (г)-д заасан 91.605-ийн (b)-ийн (2)-т заасан техник үйлчилгээний хөтөлбөрт их бие, хөдөлгүүр, сэнс, ротор, тоноглол, авран туслах хэрэгсэл болон ослын үед хэрэглэх төхөөрөмжийг оруулна.

(f) 91.609-д заасны дагуу Дарга өөрчлөлт шаардаж болохтой хамааралтайгаар, энэ зүйлийн (с)-д заасны дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөртэй агаарын хөлгийн *тусгай ангилалын* НТЧ-ын гэрчилгээ нь ИНД-47.65-д заасан бүртгэлийн гэрчилгээний хугацаанд хүчинтэй.

### **91.609. Техник үйлчилгээний хөтөлбөр болон хуваарьт өөрчлөлт оруулах**

(a) Ашиглагч нь техник үйлчилгээний *хөтөлбөр эсхүл хуваарьт* өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг бичгээр гаргаж, Дарга тухайн агаарын хөлгийн НТЧ-ыг үргэлжлүүлэн хадгалахад шаардлагатай гэж үзвэл техник үйлчилгээний хөтөлбөрийг эсхүл хуваарийг өөрчилнө.

(b) 91.607-гийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийг түр зогсоож буй ашиглагч нь:

- (1) хөтөлбөрийг түр зогсоохоор төлөвлөсөн өдрөөс 7 хоногийн өмнө энэ тухай ИНЕГ-т бичгээр мэдэгдэнэ;
- (2) батлагдсан техник үйлчилгээний өөр хөтөлбөрөөр сольж байвал, тухайн агаарын хөлгийн сүүлд хийсэн техник үйлчилгээний хугацаанаас үргэлжлүүлэн шинэ хуваарийг хийнэ.

### 91.611. Төлөвлөсөн үзлэг сунгах

(a) Дүрмээр тусгайлан хориглоогүй бол үйлдвэрлэгчээс гаргасан зөвлөмж, НТЧ-ын удирдамжийн дагуу 91.605-д шаардсан үзлэг хоорондын хугацааг 10% хүртэл сунгаж болно.

(b) Хэрэв энэ зүйлийн (a)-д заасан заалтыг агаарын хөлөгт хэрэгжүүлэх бол:

- (1) шинээр сунгасан огноо, эсхүл агаарын хөлгийн нийт ниссэн цаг, эсхүл циклийн аль тохирохыг нь техник үйлчилгээний дэвтэр, эсхүл техникийн бүртгэлд тэмдэглэсэн бол;
- (2) дараагийн үзлэгийн эхлэх хугацааг сунгалт хийгдсэн хугацаанаас давхардуулахгүй байхаар төлөвлөснийг бататгана.

### 91.613. Шалгах нислэг

(a) ИНД-43-ын (a)-ийн 4.1-т заасны дагуу техник үйлчилгээнээс гарсан агаарын хөлөгт шалгалтын нислэг үйлдэх этгээд нь:

- (1) зохих маягийн зэрэглэл эзэмшсэн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;
- (2) техник үйлчилгээ хийгдсэний улмаас агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлтэд нөлөөлөхгүй гэдгийг шалгах;
- (3) шалгах нислэгийн явцад гарсан дутагдлыг техникийн бүртгэлд тэмдэглэх.

(b) Энэ зүйлийн (a)-гийн дагуу шалгах нислэг үйлдэх нисгэгч нь тухайн шалгах нислэгт биечлэн оролцох үүрэг хүлээсэн этгээдээс өөр хүн нислэгт хамт авч явахгүй.

### 91.615. Жил тутмын НТЧ-ын үзлэг

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд дараах шаардлагыг хангаагүй аливаа этгээд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- (1) ИНД-43-ын Хавсралт Г-д заасны дагуу өмнөх 365 хоногийн дотор, эсхүл *тусгай ангилалын* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгөөр хөлсөөр эсхүл урамшуулалтай нислэг үйлдээгүй бол өмнөх 730 хоногийн дотор тус агаарын хөлөгт НТЧ-ын жил тутмын үзлэг хийсэн; эсхүл
- (2) өмнөх 365 хоногийн дотор ИНД-21-ийн дагуу олгогдсон НТЧ-ын гэрчилгээтэй байх.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан заалт ИНД-119-ийн дагуу гэрчилгээ эзэмшсэн дараах агаарын тээвэрлэгчид хамаарахгүй:

- (1) ИНД-121-ийн дагуу үйл ажиллагаа явуулдаг;
- (2) ИНД-125-ийн дагуу үйл ажиллагаа явуулдаг;

(3) ИНД-135-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг нь 135.415-ийн (а)-д заасны дагуу техник үйлчилгээний үзлэг хийгдсэн бол.

(с) Аливаа этгээд энэ зүйлийн (а)-гийн (1) -д заасны дагуу жил тутмын үзлэгийн хугацаа дууссанаас хойш дараах тохиолдолд нислэг үйлдэж болно:

(1) дараагийн техник үйлчилгээг төлөвлөхтэй хамааралтайгаар, жил тутмын НТЧ-ын үзлэгийг техникийн бүртгэлд тэмдэглэсэн дуусах өдрөөс хойш 36 хоногийн дотор бол; эсхүл

(2) НТЧ-ын үзлэг хийх зорилготой нислэг үйлдэж буй бол.

#### **91.616. Техник үйлчилгээний дэвтэр**

Хэт хөнгөн онгоцноос бусад Ашиглагч дараах үүрэгтэй:

(1) агаарын хөлөг бүрт техник үйлчилгээний дэвтэртэй байх;

(2) техник үйлчилгээний дэвтрийг онгоцонд авч явахгүй байх.

#### **91.617. Техник үйлчилгээний бүртгэл**

(а) 1-р ангиллын хэт хөнгөн онгоцноос бусад Ашиглагч нь тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан их засвар хоорондох хугацаа (ТВО) эхсүл тодорхой хугацаат их бие, эд анги, бусад тоноглолуудын ашиглалтын нийт цаг (total time-in-service), циклийг техник үйлчилгээний дэвтэрт тодорхой тэмдэглэнэ.

(b) 1-р ангиллын хэт хөнгөн онгоцноос бусад Ашиглагч нь эд анги, тоноглолууд ИНД-43-т заасны дагуу техник үйлчилгээ хийгдсэн тэмдэглэл хийгдэж, хадгалагдаж буйг бататгана.

(с) Ашиглагч нь аливаа осолд орсон бол тухайн ослын нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй болон агаарын хөлөгт учирсан гэмтлийн талаар дэлгэрэнгүй тайлбар техник үйлчилгээний дэвтэрт хийгдэж буйг баталгаажуулна.

(d) Энэ зүйлийн (а), (b), болон (с)-д заасан шаардлагуудыг энгийн өгүүлбэрээр, эсхүл кодлон тэмдэглэсэн бол кодны задаргаа нь мөн байна.

#### **91.619. Техникийн бүртгэл**

(а) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд Ашиглагч нь агаарын хөлгийн техникийн бүртгэл (борт журнал)-д дараах зүйлсийг тэмдэглэнэ:

(1) тээвэрлэгчийн нэр:

(2) агаарын хөлгийн бүртгэл, төрөл, маяг:

(3) техник үйлчилгээ хийгдсэн агаарын хөлгийн 91.605-ын (а)-д заасан техник үйлчилгээний хөтөлбөр эсхүл хуваарьт заасан ажил:

- (4) агаарын хөлгийн техник үйлчилгээний талаарх тайлан:
- (i) дараагийн хуваарьт үзлэгийн төрөл болон хийгдэх үзлэгийн төлөвлөсөн огноо эсхүл нислэгийн цаг;
  - (ii) ИНД-43-ын (а)-ийн 4.1-ийн дагуу техник үйлчилгээнээс гаргасан агаарын хөлгийг шалгах нислэг хийгдсэн талаар дэлгэрэнгүй:
- (5) дараагийн хуваарьт үзлэгээс өмнө өөр техник үйлчилгээ хийх шаардлагатай огноо, эсхүл нислэгийн цаг:
- (6) жил тутмын НТЧ, эсхүл техник үйлчилгээний дараагийн үзлэг хийх шаардлагатай өдөр:
- (7) өдөр тутмын нислэгийн цаг:
- (8) ашиглалтын нийт цаг:
- (9) хэрэв шаардлагатай бол:
- (i) өдөр тутмын цикл;
  - (ii) нийт цикл:
- (10) нислэгийн өмнөх үзлэгийн үед, нислэгийн үед, эсхүл нислэгийн дараа илрүүлсэн аливаа дутагдал:
- (11) хуваарьт үзлэгүүдийн хооронд гарсан дутагдлуудыг зассан тухай, тэдгээр дутагдлуудыг арилган нислэгэнд гарахыг зөвшөөрсөн тэмдэглэл:
- (12) 91.537-д заасны дагуу ажиллагаагүй хэрэглэл, төхөөрөмжийг оролцуулсан аливаа дутагдлын засварыг хойшлуулсан тухай нарийвчилсан тэмдэглэл.
- (b) Ашиглагч энэ зүйлийн (а)-д заасан мэдээллийг техникийн бүртгэлд тэмдэглэн, уг мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулна.
- (c) ИНД-119-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь Дарга зөвшөөрсөн бол техникийн бүртгэлээс өөр хэлбэрээр дараах мэдээллийг тэмдэглэж болохоос гадна агаарын хөлгийн дарга шаардсан үед дараах мэдээллийг бэлэн байлгана:
- (1) дараагийн техникийн үзлэг явуулах огноо болон цаг:
  - (2) дараагийн хуваарьт техникийн үзлэг хийгдэхээс өөр бусад техник үйлчилгээ хийгдэх бол түүний огноо болон цаг:
  - (3) ашиглалтын нийт цаг:
  - (4) нийт цикл.

### **91.621. Техник үйлчилгээний бичиг баримтыг шилжүүлэх**

ИНД-47-гийн дагуу өөр этгээдэд бүртгэл шилжүүлж буй Монгол Улсын агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь бүртгэл шилжүүлэх тухайн хугацаанд дараах зүйлсийг шилжүүлнэ:

- (1) 91.617-гийн (b)-д заасан бүртгэл, тэмдэглэл;
- (2) энэ зүйлийн (1)-ийн дагуу шилжүүлж буй бүртгэлд хамрагдаагүй 91.617-гийн (a)-д заасан бүртгэл, тэмдэглэл.

### **91.623. Бичиг баримтыг хадгалах**

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд Ашиглагч 91.617-д заасан баримт бичгийг тухайн агаарын хөлгийн эд ангиудыг ашиглалтаас хассанаас хойш 12 сарын хугацаанд хадгална.

(b) ИНД-43.69-ийн (a)-гийн (1)-д заасан бичиг баримтын бүртгэлийг техник үйлчилгээг давтагдах, ижил цар хүрээ бүхий өөр ажлаар орлуулах, эсхүл тухайн ажлыг гүйцэтгэж дууссанаас хойш 5 жил буюу эдгээр хугацааны аль нэг нь эхэлж тохиох хүртэл хадгална.

(c) Ашиглагч 91.619-д шаардсан техникийн бүртгэлийг сүүлчийн бүртгэл хийгдсэнээс хойш 12 сарын хугацаанд хадгална.

## **3 Бүлэг. Тусгай нислэгийн үйл ажиллагаа**

### **91.701. Уран жолоодлогын нислэг**

(a) Энэ зүйлийн (e)-д зааснаас бусад тохиолдолд, дор дурдсан бүсэд аливаа этгээд уран жолоодлогын нислэг үйлдэхгүй:

- (1) хот, тосгон буюу суурин газрын дээгүүр 600 метрийн /2000 ft/ хэвтээ зайд; эсхүл
- (2) хүн ам задгай агаарт байрласан бүсийн дээгүүр 600 метрийн /2000ft/ хэвтээ зайд; эсхүл
- (3) НХУ-аас зөвшөөрөл олгоогүй бол, аливаа хяналттай агаарын зайд.

(b) Энэ зүйлийн (c) болон (e)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд харьцангуй өндөр нь 900 метр /3000 ft/-ээс нам үед уран жолоодлогын нислэг үйлдэхгүй.

(c) Нисгэгч дараах тохиолдолд харьцангуй өндөр нь 900 метр /3000 ft/-ээс нам үед уран жолоодлогын нислэг үйлдэж болно:

- (1) хэрэв ИНД-61-ийн дагуу олгогдсон уран жолоодлогын зэрэглэлтэй бол газрын гадаргуугаас 450 метр /1500 ft/-ээс дээш өндөрт;

(2) хэрэв дараах нөхцлийг хангасан бол газрын гадаргуугаас 450 метр /1500 ft/-ээс нам өндөрт:

- (i) ИНД-61-ийн дагуу, уран жолоодлогын нислэгт зөвшөөрөгдсөн зэрэглэл эзэмшсэн;
- (ii) уран жолоодлогын зэрэглэлд зөвшөөрөгдсөн өндрөөс доош нисэхгүй бол;
- (iii) үзүүлэх нислэгт оролцож байвал.

(d) Агаарын хөлгөөр уран жолоодлогын нислэгт аливаа этгээдийг дор зааснаас бусад тохиолдолд тээвэрлэхгүй:

- (1) ИНД-61-ийн дагуу олгогдсон уран жолоодлогын зэрэглэлтэй бол;
- (2) нислэгийг газрын гадаргуугаас 900 метр /3000ft/-ээс дээш өндөрт гүйцэтгэх бол.

(e) Энэ дүрмийн 91.703-д заасны дагуу үзүүлэх нислэгт оролцож буй нисгэгч үзэгчдээс 600 метрээс дотогш зайд нислэг үйлдэж болно.

(f) ИНД-61-ийн дагуу олгогдсон уран жолоодлогын зэрэглэлгүй боловч харьцангуй өндөр нь 900 метр /3000 ft/-ээс нам өндөрт гэхдээ 300 метр /1000 ft/-ээс дээш бол планераар уран жолоодлогын эргэлттэй (spin) нислэг гүйцэтгэж болно.

### **91.703. Үзүүлэх нислэг**

(a) Дарга зөвшөөрөл олгоогүй бол, аливаа этгээд үзүүлэх нислэг зохион байгуулах, эсхүл үзүүлэх нислэгт оролцохгүй.

(b) Үзүүлэх нислэг зохион байгуулах зөвшөөрөл авахаар өргөдөл гаргаж буй этгээд уг арга хэмжээг эхлэхээс 90-аас доошгүй хоногийн өмнө төлөвлөгөөгөө Даргад ирүүлнэ.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан төлөвлөгөөнд:

- (1) төлөвлөж буй ага хэмжээнийхээ талаар дараах мэдээллийг агуулсан байна:
  - (i) зохион байгуулагчийн нэр, албан тушаал, хаяг;
  - (ii) зохион байгуулах газар, огноо, цаг;
  - (iii) арга хэмжээний хэлбэр;
  - (iv) зохион байгуулалтын талаарх нарийвчилсан мэдээлэл болон арга хэмжээнд хяналт тавих этгээд;
  - (v) нислэгийн хөтөлбөрийн талаарх нарийвчилсан мэдээлэл;
  - (vi) энэ зүйлийн (г)-д заасан шаардлагыг хангаж буйг илэрхийлэх арга хэмжээ зохиогдох газрын талаарх нарийвчилсан төлөвлөгөө болон танилцуулга;

- (vii) арга хэмжээг сонирхогчдын аюулгүй байдгыг хангаж буй талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
  - (viii) аваарын болон шуурхай үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.
- (2) Дарга хүлээн зөвшөөрсөн байна.
- (d) Үзүүлэх нислэгт оролцож буй агаарын хөлгийн дарга нь:
- (1) хөдөө аж ахуйн эсхүл нисдэг тэрэгний нислэгээс бусад, харуулах (display) нислэгт газрын гадаргуугаас дээш 30 метр /100ft/-ээс доошгүй өндөрт ниснэ;
  - (2) аливаа этгээд эсхүл эд хөрөнгөд аюулгүй гэдгийг бататгасан хангалттай зайд харуулах нислэг гүйцэтгэнэ;
  - (3) аливаа этгээдийг тээвэрлэхгүй;
  - (4) үзэгчийн талбай дээгүүр нислэг үйлдэхгүй;
  - (5) хамгаалалтын шугам болон үзэгчийн талбайн хооронд ямар нэгэн маневр үйлдэхгүй;
  - (6) дүүжин нислэг үйлдэж байгаа эсхүл явгалж буй нисдэг тэрэгнээс бусад тохиолдолд, үзэгчдийн талбайн ойролцоо ямар нэгэн маневр үйлдэхгүй.
- (e) Энэ зүйлийн (a)-д заасан зүйлс дараах үзүүлэх нислэгэнд хамаарахгүй:
- (1) 500-аас бага үзэгчтэй бол; эсхүл
  - (2) 3-аас бага оролцогч агаарын хөлөгтэй бол; эсхүл
  - (3) групп нислэг үйлдэж буй бол.

#### **91.705. Шүхэр буулгах нислэг**

- (a) Шүхэрчид буулгах нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга ИНД-61-ийн дагуу олгогдсон шүхэр буулгах тусгай зэрэглэлтэй байна.
- (b) Шүхэрчид буулгах нислэг үйлдэх Ашиглагч нь дараах зүйлсийг баталгаажуулсан байна:
- (1) шүхэрчид буулгах нислэг үйлдэж буй тухайн агаарын хөлөг НТЧ-ын стандарт ангиллын хүчин төгөлдөр гэрчилгээтэйг;
  - (2) тухайн агаарын хөлгийн бүтэц, тоноглол нь шүхэр буулгах нислэгт тохирсон;
  - (3) тухайн агаарын хөлөг нь шүхэрчдэд тохирсон шаардлага хангасан тасалгаа, хаалгатай;
  - (4) тухайн агаарын хөлөгт шүхэр задлах эсхүл шүхэрчинг хаалгаар гарах үед санамсаргүйгээр шүхэр задалж болзошгүй бариул, дэгээ байхгүйг;



- (5) агаарын хөлгөөс шүхрийг албадан задлах уяаг бэхлэх төхөөрөмж байрлуулах боломжтой;
- (6) тухайн агаарын хөлгийн нислэг ашиглалтын зааварт, нислэгийн үед хаалгыг салгах эсхүл нээх үйлдлийг зөвшөөрсөн;
- (с) Шүхэрчид буулгах нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нь дараах зүйлсийг баталгаажуулсан байна:
- (1) шүхэрчдээс бусад этгээд нь:
- (i) хөөрөх, буух үед суудалдаа сууж, хамгаалах бүсийг бэхэлсэн;
  - (ii) аврах эсхүл нөөц шүхрийг зүүсэн;
  - (iii) аврах эсхүл нөөц шүхрийг ашиглах талаар сургалтанд хамрагдсан;
  - (iv) онцгой нөхцлийн үед агаарын хөлөгт дагаж мөрдөх ерөнхий журмын (агаарын хөлгөөс гарах аргачлалыг оролцуулсан) талаар мэдээлэл авсан;
- (2) шүхрээр буух этгээдүүд нь:
- (i) агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд ноцтой нөлөөлж болох байрлалд суугаагүй;
  - (ii) онцгой нөхцлийн үед агаарын хөлөгт дагаж мөрдөх ерөнхий журмын (агаарын хөлгөөс гарах аргачлалыг оролцуулсан) талаар мэдээлэл авсан байна.
- (d) Шүхэрчид буулгах нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь дараахиас бусад тохиолдолд аливаа этгээдийг агаарын хөлгөөс шүхрээр буулгахгүй:
- (1) шүхрээр буух этгээд нь төлөвлөсөн буултын талаарх мэдээллийг агаарын хөлөг хөөрөхөөс өмнө нисгэгчид өгөөгүй бол; эсхүл
- (2) нисгэгч нь шүхрээр буух этгээдийг дараах шаардлага хангасныг баталгаажуулсан байна:
- (i) шүхэрчдийн байгууллагаас (Parachute Organization) зөвшөөрөл олгосон; эсхүл
  - (ii) хэрэв тухайн гэрчилгээ нь шүхрээр буух зөвшөөрөл олгодог бол, ИНД-115-ийн дагуу олгосон сонирхогчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигчээс зөвшөөрөл авсан бол; эсхүл
  - (iii) Дарга зөвшөөрсөн бол.

### **91.707. Нөөц шүхэр**

Агаарын хөлгийн дарга, онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх нөөц шүхэр нь доорх шаардлагыг хангаагүй бол түүнийг нислэгт ашиглахыг зөвшөөрөхгүй:

- (1) шүхэр нь энэ дүрмийн Хавсралт 25-д заасан шаардлагыг хангаагүй бол;

- (2) шүхрийг хийсэн материалд сөрөг нөлөө үзүүлж болох аливаа нөхцөл эсхүл бодисоос тэдгээрийг зохих ёсоор хамгаалаагүй бол;
- (3) үйлдвэрлэгчээс өгсөн зааврын дагуу хадгалж, өмнөх календарын жилд дараах этгээд эвхэж боогоогүй бол:
  - (i) шүхрийн байгууллагаас зөвшөөрсөн шүхэртэй харьцах тусгай эрх эзэмшигч; эсхүл
  - (ii) тухайн шүхрийг үйлдвэрлэгч; эсхүл
  - (iii) улсын агаарын хөлгийн шүхэртэй харьцах тусгай эрх эзэмшигч; эсхүл
  - (iv) Даргаас эрх олгогдсон этгээд;
- (4) тухайн шүхрийг хадгалж байсан эсхүл эвхэж боосон этгээдээс хэвийн ажиллаж буйг гэрчлэх бичиг баримтыг дагалдуулж ирүүлээгүй бол.

### **91.709. Планер чирэх**

(a) ИНД-61-ийн дагуу олгогдсон планер чирэх зэрэглэлгүй бол аливаа этгээд планер чирэхийг хориглоно.

(b) Дараах шаардлага хангасан тохиолдолд аливаа этгээд планер чирэх нислэг үйлдэнэ:

- (1) чирэх агаарын хөлөг нь планерын ашиглалтын зааварт заасан зөвшөөрөгдөх хамгийн их хурдаас доош хурдтай нислэг үйлдэх боломжтой;
- (2) чирэх ачаалал нь агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт тусгасан хамгийн их ачааллын хэмжээнээс хэтрээгүй байх;
- (3) тухайн этгээд нь планер чирэх дэгээ, холбоосыг нислэг эхлэхийн өмнө шалгасан байх;
- (4) тухайн этгээд нь планерын байгууллагаас тогтоосон хөөрөлт, планерыг суллах журам, нислэгийн хурд, аваарын дохиоллуудыг хэрэглэсэн байх;
- (5) планер чирэн 15 метр /50 ft/ хүртэл өндөр аван саад өнгөрөх зай нь ХБЗ-ны хөөрөлтийн боломжит уртын /TORA/ 85%-иас хэтрэхгүй байх;
- (6) планер чирч буй агаарын хөлөг аэродромоос дээш 300 метрийн /1000ft/ өндөр хүртэл 1м/сек-ээс (200ft/мин) доошгүй босоо хурдтай өндөр авах чадвартай байх.

(c) Аливаа этгээд дараах нөхцөлд планер чирэх нислэг үйлдэхгүй:

- (1) агаарын хөлөгт дараах зүйлсээр тоноглогдоогүй бол:
  - (i) чирэх дэгээ, холбох хэрэгсэл;

- (ii) чирэх дэгээнээс нисгэгчийн тусламжтайгаар чирэх холбоосыг хурдан тайлагч механизм;
- (2) энэ дүрмийн Хавсралт 26-д заасан шаардлагыг хангасан чирэх холбоосгүй бол;
- (3) хэрэв 1-ээс олон планер чирэх бол чирэх холбоос нь:
  - (i) планер тус бүрд нэг байх;
  - (ii) планер болон чирч буй агаарын хөлгийн хооронд 50 м-ээс доошгүй зайтай байх;
  - (iii) бүх планерын хооронд 30 м-ээс доошгүй зайтай байх;
  - (iv) агаарын хөлгөөс салгаж болох чирэх нэг цагирагт холбогдсон байх.
- (d) Энэ зүйлийн (a), (b) болон (c)-д заасан заалт дүүжин планерын (hang glider) нислэгт хамаарахгүй.

#### **91.711. Планераас бусад зүйлийг чирэх**

- (a) Аливаа этгээд дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд планераас бусад зүйлсийг чирэхгүй:
  - (1) тухайн этгээд нь:
    - (i) ИНД-61-ийн дагуу олгогдсон хувийн нисгэгчийн үнэмлэхтэй бөгөөд планер чирэх нислэгийн зэрэглэлтэй бол; эсхүл
    - (ii) ИНД-61-ийн дагуу олгогдсон коммерийн нисгэгчийн үнэмлэхтэй бол; эсхүл
    - (iii) ИНД-61-ийн дагуу олгогдсон агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэхтэй бол;
  - (2) агаарын хөлөг нь:
    - (i) хурдан тайлагддаг мехнизм бүхий чирэх дэгээ болон бусад туслах хэрэгслээр тоноглогдсон бол; бол
    - (ii) нислэг үйлдэх тухайн өндөрт өндөр авах чадвартай бол.
- (b) Планераас бусад зүйл чирэх агаарын хөлгийн нисгэгч аливаа этгээдийг зорчигчоор тээвэрлэхгүй.

## **И Бүлэг. Гадаадад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа болон монгол улсын агаарын зайн гадна нислэг үйлдэж буй монгол улсад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа**

### **91.751. Үйлчлэх хүрээ**

Энэ бүлгээр Монгол Улсын агаарын зайн гадна нислэг үйлдэж буй Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг болон Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж буй гадаадад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

### **91.753. Монгол Улсын агаарын зайн гадна нислэг үйлдэж буй Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа**

Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэх аливаа этгээд дор дурьдсан бичиг баримтад заасан шаардлагыг биелүүлнэ:

- (1) удаан хугацаагаар үргэлжлэх усан дээгүүр нислэг үйлдэх бол Чикагогийн конвенцийн Хавсралт 2-т заасан шаардлага;
- (2) гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэх бол тухайн улсын нислэгийн дүрэмд заасан шаардлага;
- (3) тухайн нислэг үйлдэж буй улсын холбогдох дүрэм, эсхүл Чикагогийн конвенцийн 2-т заасан шаардлага тохиромжгүй бол энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

### **91.755. Гадаадын агаарын хөлгийн үйл ажиллагааны тусгай дүрмүүд**

(a) **Ерөнхий зүйл.** Гадаадад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх этгээд нь энэ дүрэм болон үүнд холбогдох бусад шаардлагуудыг дагаж мөрдөнө.

(b) **ИХНД.** Тухайн агаарын хөлгийн нисэх багийн гишүүдээс нэгээс доошгүй этгээд нь нислэгийн хугацаанд НХУ-аас шаардсан хэл дээр хоёр талын радио холбоо барих боломжгүй байвал, энэ дүрэмд заасан хоёр талын радио холбоо шаардсан агаарын зайд ИХНД-ээр нисэхгүй.

(c) **ХНД.** Дараах нөхцөлд ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- (1) агаарын хөлөг нь:
  - (i) хяналттай агаарын зайд нисэхэд НХУ-ний байгууллагатай хоёр талын радио холбоо барих радио төхөөрөмжгүй бол;
  - (ii) нислэгийн төлөвлөгөөнд заасны дагуу тухайн нислэгийг үргэлжлүүлэхэд ашиглах навигацийн төхөөрөмжөөр тоноглогдоогүй бол.
- (2) нисгэгч нь:

- (i) Монгол Улсаас, эсхүл ICAO-гийн гишүүн улсаас олгосон хэрэглэлийн нислэгийн зэрэглэлгүй бол;
  - (ii) Монгол Улсын НМЭ-д заасан агаарын замын, хүлээх бүсийн, ойртолтод хамаарах нислэгийн холбогдох журмуудтай танилцаагүй бол;
- (3) тухайн агаарын хөлгийн нисэх багийн гишүүдээс нэгээс доошгүй этгээд нь, ХНД-ээр нисэх хугацаанд хоёр талын радио холбоог НХУ-аас шаардсан хэл дээр харилцах боломжгүй бол.

## **К Бүлэг. Дуу чимээний хязгаарлалт**

### **91.801. Зорилго**

Энэ бүлгээр иргэний агаарын хөлгийн дуу чимээний болон хөдөлгүүрээс гарах хорт утааны хязгаарлалтыг тогтооход оршино.

### **91.803. Агаарын хөлгийн дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ**

(a) Аливаа этгээд дараах шаардлагыг хангаагүй бол агаарын хөлгөөр аливаа аэродромоос болон аэродром руу нислэг үйлдэхгүй:

- (1) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, ИНД-21-ийн Хавсралт В-д заасан шаардлагыг Дарга биелүүлсэн гэж үзвэл;
- (2) гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг Чикагогийн конвенцийн Хавсралт 16-гийн 1-р хэсэгт (ICAO Annex 16, Vol I) заасан стандартын дагуу бүртгэлтэй улсаасаа гэрчилгээжсэн эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан заалтыг үл харгалзан, Монгол Улсад аливаа этгээд дуунаас хурдтай тийрэлтэт хөдөлгүүрт онгоцоор Чикагогийн конвенцийн Хавсралт 16-гийн 1-р хэсгийн Дэд бүлэг 3-д (ICAO Annex 16, Vol I, Chapter 3) заасан дуу чимээний стандартын дагуу гэрчилгээжээгүй бол нислэг үйлдэхгүй.

### **91.805. Агаарын хөлгийн дууны хурдны долгион**

(a) Дарга аливаа этгээдэд тусгай зөвшөөрөл (үүнд хавсаргасан нөхцөл, хязгаарлалт) олгогдоогүй бол агаарын хөлгөөр дууны хурдад харьцуулсан М тоогоор 0.92-оос их хурдтайгаар нислэг үйлдэхгүй.

(b) Агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөгдөх боломжит хурд нь дууны хурдад харьцуулсан М тоогоор 0.92-оос их боловч Монгол Улсын агаарын зайд дууны хурдны долгион нь газрын гадаргууд хүрэхгүйг агаарын хөлгийн дарга бататгаж, нислэгийн хязгаарлалтад орсон бол нислэг үйлдэж болно.

(с) Энэ зүйлийн (b)-д заасан нислэгийн хязгаарлалтыг, дууны хурдад харьцуулсан М тоогоор 0.92-оос их хурдтай нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга биелүүлнэ.

#### **91.807. Хөдөлгүүрээс гарах хорт утааны зөвшөөрөгдөх хэмжээ**

Аливаа этгээд дараах шаардлагыг хангаагүй бол тийрэлтэт хөдөлгүүрт агаарын хөлгөөр Монгол улсад аливаа аэродромоос болон аэродром руу нислэг үйлдэхгүй:

- (1) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг ИНД-21-ийн Хавсралт В-д заасан шаардлагыг Дарга биелүүлсэн гэж үзвэл;
- (2) гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг нь Чикагогийн конвенцийн Хавсралт 16-гийн 2-р (ICAO Annex 16, Vol II) хэсэгт заасан эсхүл үүнтэй ижил стандартын дагуу бүртгэлтэй улсаас гэрчилгээжсэн эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн.

## Хавсралт А. Хэрэглэл болон тоног төхөөрөмжийн шаардлага

Энэ дүрмийн Е Бүлэгт шаардсан хэрэглэл, тоног төхөөрөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

### A1. Тэмдэглэгээ болон зурагт хуудас

(a) Агаарын хөлөгт байрлуулах шаардлагатай тэмдэглэгээ, зурагт хуудасны үсэг арилах, ойлгомжгүй байх, хэлбэр дүрсээ алдах, юмны цаагуур далд орох магадлалыг аль болох багасгасан байх бөгөөд ил харагдах газар байрлуулна.

(b) Тэмдэглэгээ, зурагт хуудсанд хэрэглэж буй хэмжих нэгж нь холбогдох хэрэглэл эсхүл нислэгийн зааварт хэрэглэж буй нэгжтэй ижил байна.

### A2. Шатахуун ба тосны тэмдэглэгээ

(a) **Шатахуун ба тосны хэмжүүр.** Ашиглагч, үйлдвэрлэгчид захиалсан хувилбараас хамаарч шатахуун ба тосны хэмжүүр нь кг, литр, метр, фунтээр тохируулсан, тохируулгыг тухайн нэгжээр хийсэн гэдгийг харагдахаар, ойлгомжтой тэмдэглэсэн байна.

(b) **Шатахуун ба тосны зурагт хуудас.** Агаарын хөлгийн бүх шатахуун болон тосны савны (бөглөөний) болон шүүлтүүрийн дэргэд түлшний ангилал, тосны сорт, тодорхойлолтыг тусгасан зохих зурагт хуудсыг наасан байна.

### A3. Суудал

Бүх суудал буюу түшлэгтэй сандал нь холбогдох АНУ-ын техникийн стандарт TSO C25, эсхүл TSO C39-д заасан шаардлагыг хангасан байна.

### A4. Хамгаалах бүс

(a) Бүх хамгаалах бүс нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) АНУ-ын техникийн стандарт TSO C22; эсхүл

(i) ISO/FIA 8853; эсхүл

(ii) FIA 8854; эсхүл

(iii) цэргийн зориулалтаар ашиглаж байсан агаарын хөлгийн хувьд, цэргийн зураглал болон захиалгын дугаар эсхүл бусад холбогдох цэргийн тэмдэглэгээ эсхүл тусгайлсан дугаарын дагуу байна; эсхүл

(2) хэрэв энэ зүйлийн (a)-ийн (1)-д заасан стандартын таних тэмдэглэгээ байхгүй бол, шаардагдах стандартын бат бэх чанарыг 50%-ийг хангасан байна.

(b) Хамгаалах ташуу буюу мөрөвчтэй хамгаалах бүс нь (torso restraint) дараах шаардлагыг хангасан байна:

- (1) АНУ-ын техникийн стандарт TSO C114; эсхүл
- (2) цэргийн зориулалтаар ашиглаж байсан агаарын хөлгийн хувьд, цэргийн зураглал болон захиалгын дугаар эсхүл бусад холбогдох цэргийн тэмдэглэгээ эсхүл тусгайлсан дугаарын дагуу байна.

#### **A5. Хүүхдийн хамгаалах бүс**

Хүүхдийн хамгаалах бүс нь:

- (1) АНУ-ын техникийн стандарт TSO C22-д заасан шаардлагыг хангасан хамгаалах бүсээр агаарын хөлгийн сандалд бэхлэгдсэн;
- (2) хүүхдийн тусгай суудлыг агаарын хөлгийн сандалд уяа, эсхүл аргамжаагаар бэхлэгдсэн;
- (3) АНУ-ын техникийн стандарт TSO C100, эсхүл АНУ-ын FMVSS 213, эсхүл Европын стандарт ECE 44-д заасан шаардлагыг хангасан байна.

#### **A6. Агаарын хөлгийн гэрлүүд**

(a) Агаарын хөлгийн мөргөлдөхөөс хамгаалах гэрлийн систем нь дараах зүйлсээс бүрдсэн байна:

- (1) эргэлддэг улаан гэрлэн дохио; эсхүл
- (2) дараах шаардлагыг хангасан /Capacitor Discharge Light/-ын зарчмаар ажилладаг цагаан, эсхүл улаан гэрлэн дохио:
  - (i) АНУ-ын техникийн стандарт TSO C96; эсхүл
  - (ii) тухайн агаарын хөлгийн загварын минимум стандарт шаардлага хангасан; эсхүл
  - (iii) ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн бусад стандарт.

(b) Агаарын хөлгийн байрлалын гэрэл (Position Light) нь АНУ-ын TSO C30-д заасан шаардлагыг хангасан болон дараах шаардлагыг хангасан байна:

- (1) агаарын хөлгийн зүүн талд дээш, доош, хөндлөн  $110^{\circ}$  харагдахуйц байнга асах улаан гэрэлтэй;
- (2) агаарын хөлгийн баруун талд дээш, доош, хөндлөн  $110^{\circ}$  харагдахуйц байнга асах ногоон гэрэлтэй;
- (3) агаарын хөлгийн хойд талд дээш, доош, хөндлөн  $140^{\circ}$  харагдахуйц байнга асах цагаан гэрэлтэй байна.



**A7. Агаарын хөлгийн нислэгийн цагийг мэдээлэх төхөөрөмж**

Агаарын хөлгийн нислэгийн цагийг мэдээлэх төхөөрөмж нь Дарга хүлээн зөвшөөрсөн стандарт шаардлагыг хангасан байна.

**A8. Өндөр хэмжигч**

(a) 7600м /25000 ft/-ээс дээш үнэмлэхүй өндөрт нислэг үйлдэх битүүмжлэгдсэн агаарын хөлгийн өндөр заагч бүр нь:

- (1) хөөрөлтийн хамгийн их хүнд нь 5700 кг хүртэлх агаарын хөлөгт:
  - (i) агаарын хөлгийн даргын өмнө зүүгээр өндөр заагч хүрд хэлбэрт (counter/pointer or drum/pointer) хэрэглэл байна;
  - (ii) багийн бусад гишүүдийн өмнө тоо буюу зүүгээр заагч хүрд хэлбэрт (counter/pointer, or drum/pointer, or three pointer) өндрийн хэрэглэлүүд байна; эсхүл
- (2) хөөрөлтийн хамгийн их хүнд нь 5700 кг-аас дээш агаарын хөлөгт:
  - (i) агаарын хөлгийн даргын өмнө зүүгээр (counter/pointer) заагч өндрийн хэрэглэл байна;
  - (ii) багийн бусад багийн гишүүдийн өмнө зүүгээр заагч (counter/pointer, or drum pointer) болон хүрд хэлбэрт өндөр заагч хэрэглэл байна.

(b) 7600 м /25000 ft/-ээс доош үнэмлэхүй өндөрт ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлгийн өндөр заагч бүр нь зүүгээр заагч (counter/pointer or drum/pointer) хэрэглэлүүд байна.

(c) Гурван зүүгээр заагч өндрийн хэрэглэл нь үнэмлэхүй өндөр 3000 м (10000 ft) хүртэл, судлан зураасаар илэрхийлсэн, бага өндөрт нисэж буйг анхааруулах сектортой байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

- (1) 3000 м (10000 ft) заагч зүү нь бусад зүүний наана халхлагдаагүй; эсхүл
- (2) 3000 м (10000 ft)-ийн интервалыг илэрхийлэх заагч; эсхүл
- (3) энэ зүйлийн (1) болон (2)-т заасан шаардлагыг хамтад нь хангасан.

(d) Даралтын өндөр заагч бүр нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) АНУ-ын техникийн стандартын TSO C10, эсхүл
- (2) Британийн стандарт G115, G2018 G226; эсхүл
- (3) гектопаскал эсхүл милибараар хэмжигдэх барометрийн даралтад шилжүүлж болох 6 м (20 ft)-ийн өндрөөр ялган хялбар унших боломжтой байхаар харагдаж байна.

(e) Нарийвчлал сайтай өндөр заагч шаардлагагүй (not required sensitive pressure altimeter) агаарын хөлөг нь 60 м (200 ft)-ийн өндрөөр ялгах өндрийн хэрэглэлтэй байна.

#### **A9. Холбоо, навигацийн төхөөрөмж**

(a) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, холбоо навигацийн төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) 1-р түвшин бол:

- (i) холбооны төхөөрөмж нь холбогдох АНУ-ын техникийн стандартын TSO-ийн C31, C32, C37, C38, C50-ийн аль нэгийн шаардлагыг хангасан; эсхүл
- (ii) навигацийн төхөөрөмж нь холбогдох АНУ-ын техникийн стандартын TSO-ийн C34, C35, C36, C40, C41, C60, C94, C129-ийн аль нэгийн шаардлагыг хангасан; эсхүл
- (iii) Британийн ИНЕГ-аас зөвшөөрсөн Category WR, VC, LA Class I-ийн шаардлагыг хангасан; эсхүл

(2) 2-р түвшин бол Британийн ИНЕГ-аас зөвшөөрсөн Category LA Class II-ийн шаардлагыг хангасан; эсхүл

(3) 3-р түвшин бол Британийн ИНЕГ-аас зөвшөөрсөн Category LA Class III, эсхүл Category G-ийн шаардлагыг хангасан; эсхүл

(4) 4-р түвшин бол Британийн стандарт 3G,100: Part 2, Section 2-т заасны дагуу компасаас аюулгүй зайд байна.

(b) Хоёр радио холбооны бие даасан систем шаардлагатай бол:

(1) систем тус бүр тусдаа антеннтай байна; эсхүл

(2) тухайн хоёр систем нь нэг тулгуурт бэхлэгдсэн утасгүй антенныг ашиглаж болно.

(c) Тухайн холбооны тоног төхөөрөмжийг суурилуулахдаа техникийн үзүүлэлтийн зохих шаардлагыг хангасан, хүлээн авагч антенныг хөдөлшгүй байрлуулсан бол, планер, хэт хөнгөн, сонирхогч угсарсан агаарын хөлгүүдэд дараах шаардлагыг хангасан радио холбооны төхөөрөмжийг ашиглаж болно:

(1) Британийн ИНЕГ-аас зөвшөөрсөн Category G(a)-д заасан жагсаалтад буй бол; эсхүл

(2) энэ дэд зүйлийн (c)-ийн (1)-д заасан Британийн ИНЕГ-аас зөвшөөрсөнтэй ижил зохих шаардлагыг хангасан Дарга хүлээн зөвшөөрсөн, туршилтын хөтөлбөрөөр баталгаажсан аливаа төхөөрөмж.

**A10. RNP, MNPS, VSM төхөөрөмж**

RNP, MNPS, VSM агаарын зайд үйлдэх нислэгт зориулан суурилуулсан навигацийн систем болон төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) тухайн агаарын зай болон нислэг үйлдэх маршрутад шаардагдах ICAO-ийн Doc 7030 (ICAO Regional Supplementary Procedure Doc 7030)-д заасан холбогдох үзүүлэлтийн заалтууд;
- (2) RNP агаарын зайд үйлдэх нислэгт INS, IRS/FMS, GPS-ээс бүрдсэн хоорондоо хамааралгүй хоёр тусдаа алсын зайн навигацийн системтэй /LRNS/;
- (3) тоног төхөөрөмж болон ажиллагааны шаардлагууд нь дараах бичиг баримтад заагдсан байна:
  - (i) RNP агаарын зайд үйлдэх нислэгт ICAO-ийн Doc 9613 (ICAO Manual on Required Navigation Performance (RNP) Doc 9613); эсхүл
  - (ii) 8900 м /FL290/-ээс 12500 м /FL41000/ хүртэл 300м /1000 ft/-ийн багасгасан босоо зайчлал /RVSM/-аар тогтоогдсон агаарын зайд үйлдэх бол ICAO-ийн Doc 9574.

**A11. CAT II, CAT III-т шаардагдах төхөөрөмж**

(a) "Radio Technical Commission for Aeronautics" (RTCA)-ийн бичиг баримтын ILS-ийн курсийн (localiser) хувьд DO-195, глиссадын (glide slope) хувьд DO-192-т заасан шаардлагуудыг хангана.

(b) Нислэгийн удирдлага хяналтын систем нь үнэлгээний хөтөлбөрт заасан үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.

(c) Радио өндөр хэмжигч бүр нь:

- (1) газрын гадаргуугаас үндсэн дугуй хүртэлх өндрийн хэмжээг  $\pm 1,5$  м ( $\pm 5$  ft) эсхүл 5%-ийн нарийвчлалтайгаар дор дурьдсан үед нисгэх багт үзүүлнэ:
  - (i) тангаж нь буултын оролтын дундаж өнцгөөс  $\pm 5$  градус байх үед;
  - (ii) крен нь аль ч тал руу 20 градус байх үед;
  - (iii) давших хурд нь ойртолт үйлдэх хамгийн бага хурд болон 370 км/ц /200 knots/ -ийн хооронд байх үед;
  - (iv) 30 м /100 ft/-ээс 60 м /200 ft/ хүртэлх өндөрт өндөр алдах босоо хурдны хэмжээ нь 15 ft/сек-ээс их биш байх үед;
  - (v) тэгш гадаргуу дээр бодит өндрийн заалт нь мэдэгдэхүйц хоцорсон эсхүл савлалт байхгүй үед;
- (2) агаарын хөлөг нь 60 м /200 ft/-ийн өндрөөс доош нислэг үйлдэж байхад газрын гадаргуугатай харьцуулсан тухайн агаарын хөлгийн өндрийн өөрчлөлт 10%-иас дээш болж буй бол:

- (i) салгагдахгүй байх;
  - (ii) дэлгэц нь 0.1 секундын дотор хариулах;
  - (iii) хэрэв радио өндөр заагч дахин ажиллавал дохиог 1 секундээс бага хугацаанд авахаар.
- (3) хэрэв дарж шалгах товчтой бол дуриамал өндөр болох 150 метрээс /500 ft/ доош өндөрт системд хийгдэх бүх тестийг шалгана;
- (4) цахилгаан тэжээлгүй болох, эсхүл газраас буцаж ойсон дохио алга болох гэх мэт ажиллагааны гэмтлийг анхааруулах дохиололтой байна.
- (d) Бусад хэрэглэл, төхөөрөмж нь 91.417-т заасны дагуу шаардсан Ашиглагчийн үйл ажиллагааны зааварт дурдсаны дагуу CAT II, CAT III нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх хүчин чадалтай байна.

## **A12. Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл**

Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл бүр нь:

- (1) алдагдах, эсхүл муудаж чанараа алдах зэрэг аливаа эрсдлийг багасгасан саванд хадгалагдсан;
- (2) дараах байдлаар байрлуулсан байна:
  - (i) осол аваар гарах үед гэмтэх, асгарах зэрэг эрсдэл бага байхаар;
  - (ii) агаарын хөлгөөр зорчиж буй хүмүүст аюул учруулахгүй байхаар;
- (3) байрлалын тэмдэглэгээг:
  - (i) тухайн хэрэгслийг хадгалж буй савны гадна талд;
  - (ii) хөөрөлтийн дээд жин нь 5700 кг-аас хэтрэхгүй агаарын хөлгийн гадна талд нь тэмдэглэсэн байна.
- (4) мансууруулах бодис агуулсан эмнэлгийн анхны тусламжийн хэрэгслийг түгжээтэй саванд, аюулгүй байрлалд хадгална.

*Аврах завь нь мансууруулах бодис агуулсан эмнэлгийн анхны тусламжийн хэрэгслийг аюулгүй байрлалд гэдэгт тооцдог.*

## **A13. Гал унтраагч**

Бүх гал унтраагч нь дараах шаардлагуудыг хангасан байна :

- (1) агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа болон багийн гишүүд, зорчигчдын аюулгүй байдалд ноцтой нөлөөлөхгүй байрлалд суурилагдаж, бэхлэгдсэн;
- (2) энэ зүйлийн (4)-т заасныг харгалзан, гал унтраагч нь гарч болзошгүй галын төрөлд тухайн тасалгаа бүрт тохирох төрөл, тоо хэмжээтэй;

- (3) хортой хийнээс гарах эрсдлийг багасгасан байна;
- (4) гал унтраах зориулалтын дараах бодисуудыг агуулсан байна:
  - (i) бромхлоридфлуорметан (halon 1211); эсхүл
  - (ii) бромтрифлуорметан (halon 1301); эсхүл
  - (iii) нүүрстөрөгчийн давхар исэл; эсхүл
  - (iv) хуурай нунтаг буюу химийн хуурай хор; эсхүл
  - (v) гал унтраах зориулалтын бусад бодис, хэрэглэл.

#### **А14. Аврах тоног төхөөрөмж**

- (a) Аврах хантааз нь байршил заагч гэрэлтэй байна.
- (b) Аврах хантааз дараах шаардлагыг хангасан байна:
  - (1) хийлэгддэг аврах хантаазын хувьд:
    - (i) АНУ-ын техникийн стандартын TSO C13; эсхүл
    - (ii) европын стандартын EN 396 (European Norm EN 396); эсхүл
    - (iii) шинэ зеландын стандарт NZ 5823;
  - (2) байнга өмсдөг цувны хувьд: US Coastguard Type V PFD-ийн шаардлага.
- (c) Аврах завь нь АНУ-ын техникийн стандартын TSO C70-д заасан шаардлагыг хангасан, авран хамгаалах хэрэгслийг агуулсан байна.
- (d) Энэ зүйлийн (c)-д заасан авран хамгаалах хэрэгсэлд дараах зүйлсийг багтаасан байна:
  - (1) завины бүрхүүл - нэг;
  - (2) локаторын долгион ойлгогч;
  - (3) завь нөхөгч;
  - (4) завины ус шавхагч;
  - (5) дохионы толь;
  - (6) шүгэл;
  - (7) завины хутга;
  - (8) завь хийлэхэд зориулсан даралттай агаар бүхий баллон;
  - (9) завь хийлэгч гар насос;
  - (10) 25 м урттай аврах олс;
  - (11) соронзон луужин - нэг;
  - (12) усны өнгө хувиргагч будаг;

- (13) гар чийдэн;
- (14) загасчлах хэрэгсэл;
- (15) сэлүүр, эсхүл сэлүүрдэх бээлий - хоёр;
- (16) завины багтаамжинд таарах хүний тоогоор, өдөрт 1000 калори илчлэгтэй 2 өдрийн хоол;
- (17) завин дээрх хоёр хүн тутамд 1,2 л ус, эсхүл далайн усыг давсгүйжүүлэх хэрэгсэл нэг;
- (18) хөнгөн гэмтлийг эмчлэх эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл;
- (19) нислэг үйлдэж буй газар нутгийн тухай ном, лавлах материал;
- (20) зангуу;
- (21) ус тосох уут, эсхүл аяга.

(е) Авран хамгаалах байршил заагч гэрэл нь АНУ-ын техникийн стандартын TSO C85-д заасан шаардлагыг хангасан байна.

#### **A15. Ослын байршил дамжуулагч /ELT/**

(а) Ослын байршил дамжуулагч автомат ELT болон энгийн ELT нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ АНУ-ын техникийн стандартын TSO C126;
- 2/ 121.5 мгц болон 406 мгц давтамж дээр ажилладаг.

(b) Ослын байршил дамжуулагч автомат ELT-ийг:

(1) дараах байдлаар агаарын хөлөгт суурилуулсан байна:

- (i) аваар, ослын үед гэмтэх буюу эвдрэх эрсдлийг багасгасан;
- (ii) ELT бэхэлсэн хэсгийн агаарын хөлгийн их биеийн бүтцийн хүчин чадлыг бууруулах эрсдлийг багасгасан;
- (iii) ELT бэхэлсэн хэсгийн 0,3-аас 1,0 метрийн хоорондох зайд 450 ньютон хүчний үйлчлэл үзүүлэхэд бэхлэгдсэн хэсэгтэй харьцуулсан статик хазайлт нь 2,5 мм-ээс ихгүй;
- (iv) ELT-ийн антенн нь агаарын хөлгийн 3 тэнхлэгийн дагуу нэмэх болон хасах чиглэлд 100 G ачааллыг даах чадвартай байна;
- (v) ELT болон түүний гадна байрлуулсан антенн хоёрыг аль болох ойр байрлуулна;
- (vi) агаарын хөлгөөс салдаггүй болон салдаг автомат дамжуулагчийг /ELT/ аль болох арын хэсэгт байрлуулна;

(2) ослын үед залгагч мэдрэгч нь:

- (i) болгоомжгүй идэвхжихээс сэргийлэх байрлалд;

- (ii) агаарын хөлгийн уртааш тэнхлэгийн дагуу, ослын анхны доргилт чичиргээг мэдрэхээр байрласан байна;
- (3) антенн нь:
  - (i) агаарын хөлгийн хэвийн нислэгийн үед босоо байрлалд байх;
  - (ii) гаднах антенн нь үйлдвэрлэгчээс онцолж заагаагүй бол, бусад VHF-ийн гадна антеннаас 0.6 метрээс багагүй зайтай байх;
  - (iii) дотор антенн нь 0.3 м<sup>2</sup>-аас дээш талбай бүхий цонхонд ил байх бөгөөд металл хэрэгслээс тусгаарлагдсан байх;
- (4) ELT-ын дамжуулагч антенны кабелин төгсгөл бүрт чичиргээнээс хамгаалах холбоог суурилуулсан байна;
- (5) ELT бүр нь хүрэхэд ойр байрлалд, таних тэмдэгтэй байна.
- (с) Онцгой тохиолдлын радио байрлал заагч (EPIRB) нь:
  - (1) Австрали/шинэ зеландын стандарт AS/NZ 4280.1-д заасан шаардлага хангасан;
  - (2) 121.5 мгц болон 406 мгц давтамж дээр ажилладаг.
- (d) Энгийн ELT болон EPIRB нь:
  - (1) ачаалал даах чадвартай;
  - (2) усанд нэвтэрдэггүй;
  - (3) зөөврийнх байна.
- (e) Хувийн байрлал заагч (PLB) нь 121.5 мгц болон 406 мгц давтамж дээр ажилладаг байхаас гадна дараах шаардлагыг хангасан байна:
  - (1) Австрали/шинэ зеландын стандарт AS/NZ 4280.2-д заасан шаардлага; эсхүл
  - (2) COSPAS-SARSAT төрлөөр зөвшөөрөгдсөн.
- (f) Энгийн ELT нь аливаа ослын үед хүрэхэд ойр, ашиглахад хялбар байрлалд байрлуулсан байна.

## **A16. Хүчилтөрөгч**

Агаарын хөлөгт ашиглах хүчилтөрөгч нь Нисэхийн салбарт (Aviation) ашиглах стандарт хүчилтөрөгчийн шаардлагыг хангасан 99%-ийн цэвэр, чийгшил нь нэг м<sup>3</sup>-д 0.0056 граммаас ихгүй, нүүрстөрөгчийн дан исэлгүй байна.

## **A17. Зорчигчийн хүчилтөрөгчийн баг**

Зорчигчийн хүчилтөрөгчийн баг бүр нь АНУ-ын техникийн стандартын TSO C64-т заасан шаардлагыг хангасан байна.

**A18. Нисэх багийн гишүүд шаардлагатай үед хэрэглэх хүчилтөрөгчийн баг**

(a) Нисэх багийн гишүүд шаардлагатай үе хэрэглэх хүчилтөрөгчийн баг нь АНУ-ын техникийн стандартын TSO C78-д заасан шаардлагыг хангасан байна.

(b) Нисэх багийн гишүүд шаардлагатай үе хэрэглэх хүчилтөрөгчийн баг нь онцгой тохиолдлын үед аливаа саадгүйгээр:

- (1) нэг гараараа авч өмсөх боломжтой;
- (2) зохих ёсоор бэхлэгдсэн байх бөгөөд 5 секундын дотор хүчилтөрөгчөөр хангах хүчин чадалтай;
- (3) дараах нөхцлийг хангасан:
  - (i) нүдний шилний гадуур өмсөхөд харагдах нөхцөлийг муутгахгүй;
  - (ii) нисэх багийн гишүүд ажлын байрнаас дотоод холбоогоор ярилцах боломжтой;
  - (iii) нисэх багийн хоёр гишүүний ажлын байр болон зорчигчийн тасалгаа бүрд байгаа багийн нэг гишүүний хооронд холбоо барих боломжтой.

**A19. Хүчилтөрөгчийн тоног төхөөрөмж**

(a) Нисэх багийн хүчилтөрөгчийн тоног төхөөрөмжийн хүчилтөрөгчийн урсгал нь:

- (1) байнгын урсгалтай байх тоног төхөөрөмжийн хувьд, дор дурдснаас их байна:
  - (i) стандарт хэм болон хуурай даралтын (STPD) үед минутан 2 литр; эсхүл
  - (ii) 700 мл амьсгалах эзлэхүүнд стандарт биеийн хэм болон даралт (BTPS) минутанд 15 литр амьсгалахад мөгөөрсөн хоолойн хүчил төрөгчийн хэсэгчилсэн даралт (MTOPP) нь 149 мм м.у.б байх шаардлагатай;
- (2) шаардлагатай үед хэрэглэх тоног төхөөрөмжийн хувьд:
  - (i) 10700 м (35000 ft) хүртэл, шаардагдах мөгөөрсөн хоолойн хүчил төрөгчийн хэсэгчилсэн даралт (MTOPP) нь 120 мм м.у.б багагүй;
  - (ii) 10700 м-ээс (35000 ft) дээш, стандарт биеийн хэм болон даралт (BTPS)-ын үед минутанд 15 литрээс багагүй;
  - (iii) 12500 м-ээс (41000 ft) дээш, тухайн даралтын үед байнга ихсэж байхаар 15 мм м.у.б багагүй болон 13700 м (45000 ft) үед стандарт биеийн хэм болон даралт (BTPS)-ын минутанд 30 литр хүрэхээр;
- (3) хамгаалах тоног төхөөрөмжийн хувьд, харьцангуй өндөр нь 2400 м (8000 ft) үед стандарт биеийн хэм болон даралт (BTPS)-ын минутанд 30 литр байхаар.



(b) Нисэх багийн болон зорчигчдын хүчилтөрөгчийн тоног төхөөрөмж нь дараах хүчилтөрөгчийн урсгалтай байна:

- (1) 3000 м – 5600 м (10 000 feet to 18 500 feet) хоорондох нислэгийн үед, 700 мл амьсгалах эзлэхүүнд стандарт биеийн хэм болон даралт (BTPS) минутанд 15 литр амьсгалахад мөгөөрсөн хоолойн хүчилтөрөгчийн хэсэгчилсэн даралт (MTOPP) нь 100 мм м.у.б багагүй байх шаардлагатай;
- (2) 5600 м – 12200 м (18 500 feet to 40 000 feet) хоорондох нислэгийн үед, 1100 мл амьсгалах эзлэхүүнд стандарт биеийн хэм болон даралт (BTPS) минутанд 30 литр амьсгалахад мөгөөрсөн хоолойн хүчилтөрөгчийн хэсэгчилсэн даралт (MTOPP) нь 83.8 мм м.у.б багагүй байх шаардлагатай;
- (3) 12200 м – 13700 м (40 000 feet to 45 000 feet) хоорондох нислэгийн үед, 1100 мл амьсгалах эзлэхүүнд стандарт биеийн хэм болон даралт (BTPS) минутанд 30 литр амьсгалахад мөгөөрсөн хоолойн хүчилтөрөгчийн хэсэгчилсэн даралт (MTOPP) нь 55 мм м.у.б багагүй байх шаардлагатай;

(c) Зөөврийн хүчилтөрөгчийн хувьд хүчилтөрөгчийн урсгал нь дараах шаардлагаас багагүй байна:

- (1) нам тохируулгатай үед стандарт хэм болон хуурай даралтын (STPD) үед минутан 2 литр;
- (2) өндөр тохируулгатай үед стандарт хэм болон хуурай даралтын (STPD) үед минутан 4 литр.

(d) Шаардлагатай үед хэрэглэх хүчилтөрөгчийн тохируулагч нь АНУ-ын техникийн стандарт TSO C89 шаардлагыг хангасан байна.

## **A20. Амьсгал хамгаалах төхөөрөмж /PBE/**

Амьсгал хамгаалах хэрэгсэл нь:

- (1) АНУ-ын техникийн стандарт TSO C99-д заасан шаардлагыг хангасан;
- (2) хэрэглэгчдийг дор дурдсан нөлөөллөөс хамгаална:
  - (i) утаа; эсхүл
  - (ii) нүүрстөрөгчийн давхар исэл; эсхүл
  - (iii) хортой бусад хий; эсхүл
  - (iv) нисэх онгоцны битүүмжлэл алдагдсанаас бусад нөхцлийн улмаас бий болсон хүчилтөрөгчийн дутагдалтай орчин.

### **A21. Багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж нь АНУ-ын техникийн стандарт TSO C116-д заасан шаардлагыг хангасан байна.

(b) Багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж нь багийн гишүүдийн үүрэгт ажилд саад болохооргүй бол хүчилтөрөгчийн амьсгал хамгаалах зөөврийн хэрэгсэлтэй холбогдсон байж болно.

### **A22. Автомат хариулагч төхөөрөмж**

Автомат хариулагч нь:

- (1) АНУ-ын техникийн стандарт TSO C74с-д заасан шаардлагыг хангасан байна; эсхүл
- (2) S горимд ажиллах төхөөрөмж нь АНУ-ын техникийн стандарт TSO C112-ын зохих ангиллын шаардлагыг хангасан байна.

### **A23. Өндрийн мэдээллийг кодлох тоноглол**

Өндрийн мэдээллийг кодлох хэрэгсэл нь АНУ-ын техникийн стандарт TSO C88-д заасан шаардлагыг хангасан байна.

### **A24. Өндрийн дохиоллын систем**

Газрын гадаргуугаас дээш 1000 м (3000 ft)-ээс доош үйлдэх нислэгт өндрийн дохиоллын систем буюу төхөөрөмж нь харагдах, эсхүл сонсогдох дохионы аль нэгийг өгнө.

### **A25. Аваарын үед хэрэглэх шүхэр**

Аваарын үед хэрэглэх шүхэр нь дараах шаардлагыг хангасан байна:

- (1) зохих маягийн гэрчилгээнд заасан; эсхүл
- (2) АНУ-ын техникийн стандарт TSO C23; эсхүл
- (3) цэргийн зураглал болон захиалгын дугаар эсхүл бусад холбогдох цэргийн тэмдэглэгээ эсхүл тусгайлсан дугаарын дагуу; эсхүл
- (4) LTF 3(5)03; эсхүл
- (5) Европын стантарт EN 12491; эсхүл
- (6) AFNOR and DHV-ийн стандарт.

## **A26. Планер чирэх холбоос**

(a) Энэ зүйлийн (2)-т зааснаас бусад тохиолдолд, планер чирэх холбоосны бат бэх чанарын /тасрах/ хязгаар нь чирэгдэж буй планерын хөөрөлтийн хамгийн их жингийн 80%-иас багагүй, эсхүл 200%-иас ихгүй байна.

(b) Хэрэв холбоосны бат бэх чанарын хязгаар нь чирэгдэж буй планерын нислэгийн хөөрөлтийн хамгийн их жингийн 200%-иас их байх тохиолдолд бэхлэлтийн цэгүүд дээр дараах шаардлагыг хангасан хамгаалах гогцоо суурилуулна:

- (1) чирэгдэж буй планерын бэхлэлтийн цэг дээрх гогцооны хувьд, бат бэх чанарын хязгаар нь тухайн планерын хөөрөлтийн хамгийн их жингийн 80%-иас багагүй, гэхдээ планерын хөөрөлтийн хамгийн их жингээс 2 дахин их байж болохгүй;
- (2) чирж байгаа агаарын хөлгийн бэхлэлтийн цэг дээрх гогцооны хувьд, бат бэх чанарын хязгаар нь планерын хөөрөлтийн хамгийн их жингийн 100%-иас доошгүй, гэхдээ планерын хөөрөлтийн хамгийн их жингээс 2 дахин их байж болохгүй.